



ЭДИЙН ЗАСАГ,
ХӨГЖЛИЙН ЯАМ

МАКРО ЭДИЙН ЗАСГИЙН ТАНИЛЦУУЛГА

2023 оны IV улирал



Цахим хувилбар

Энэхүү тайланд тусгагдсан үр дүн, тайлбар, дүгнэлт нь Эдийн засаг, хөгжлийн яамны байр суурийг илэрхийлэх албагүй болно.

Үг тайланг арилжааны бус зорилгоор бүрэн болон хэсэгчилсэн байдлаар ашиглаж болох бөгөөд ашигласан тохиолдолд "Макро эдийн засгийн танилцуулга", Эдийн засаг, хөгжлийн яам хэмээн эх сурвалж хэсэгт тодотгоно уу.

Санал хүсэлт болон өөр бусад мэдээллийн талаар асууж тодруулах бол info@med.gov.mn цахим шуудан эсвэл дараах хаягаар хандана уу.

Эдийн засаг, хөгжлийн яам, Чингэлтэй дүүрэг, Ж.Самбуугийн гудамж, Засгийн газрын XI байр, Улаанбаатар хот 15141, Монгол Улс



ЭКСПОРТЫН СЭРГЭЛТ

АГУУЛГА

Хураангуй дүгнэлт	7
Макро эдийн засагт 2023 онд хэрэгжүүлсэн бодлогын чиглэл	9
Богино хугацааны төлөв	11
Засгийн газраас 2024 онд баримтлах бодлого, тэргүүлэх чиглэл	12
I. Бодит сектор	14
1.1. Нийт нийлүүлэлт	15
1.2. Нийт эрэлт	22
1.3. Хөдөлмөр ба бизнес	24
II. Төсвийн сектор	27
2.1. Төсвийн бодлого	28
2.2. Засгийн газрын өрийн тогтвортой байдал	31
III. Мөнгөний сектор	35
3.1. Инфляц	36
3.2. Мөнгө, санхүү	39
IV. Гадаад сектор	43
4.1. Гадаад худалдаа	44
4.2. Төлбөрийн тэнцэл	49
4.3. Гадаад өр	51
V. Дэлхийн эдийн засаг	54
5.1. Дэлхийн эдийн засгийн нөхцөл байдал	55
5.2. Түүхий эдийн зах зээлийн хандлага	59
VI. Эрсдэл	61

ЗУРГИЙН ЖАГСААЛТ

Зураг 1.1. Бодит ДНБ-ий өсөлт	16
Зураг 1.2. ХАА-н салбарын үзүүлэлтүүд	19
Зураг 1.3. Жуулчид	20
Зураг 1.4. Төмөр замын хөдлөх бүрэлдэхүүний ашиглалт	21
Зураг 1.5. Бодит ДНБ-ий өсөлт, өрхийн санхүү	22
Зураг 1.6. Үйлдвэрлэлийн зөрүү	23
Зураг 1.7. Хөдөлмөр ба бизнес	25
Зураг 2.1. Төсвийн орлого, зарлага, тэнцэл	28
Зураг 2.2. Төсвийн хөрөнгө оруулалтын зардал	30
Зураг 2.3. Төсвийн төлөв, тэнцэл, автомат тогтворжуулагч	30
Зураг 2.4. Засгийн газрын өрийн бүтэц, гадаад бондын үлдэгдэл	31
Зураг 2.5. Засгийн газрын өрийн дунд хугацааны төлөв	32
Зураг 2.6. Монгол Улсын зээлжих зэрэглэл	33
Зураг 3.1. Инфляцын бүрэлдэхүүн	36
Зураг 3.2. Өрхийн эрүүл мэндийн зардал	38
Зураг 3.3. Мөнгөний үзүүлэлт	40
Зураг 3.4. Зээл	40
Зураг 3.5. Хөрөнгийн зах зээл	41
Зураг 4.1. Уул уурхайн бүтээгдэхүүний биржийн арилжаа	45
Зураг 4.2. Гадаад худалдааны үзүүлэлт	46
Зураг 4.3. Гадаад валютын нөөц, инфляц, ханш	48
Зураг 4.4. Төлбөрийн тэнцэл, урсгал дансны тэнцэл	50
Зураг 4.5. Гадаад өр, гадаад хөрөнгө оруулалтын позиц	52
Зураг 4.6. Гадаад өрийн хандлага	52

Зураг 5.1.	БНХАУ-ын эдийн засгийн үзүүлэлтүүд	55
Зураг 5.2.	ОХУ-ын эдийн засгийн үзүүлэлтүүд	56
Зураг 5.3.	Түүхий эдийн үнэ	60
Зураг 1.	Эрчим хүчний үйлдвэрлэл, оргил ачааллын үеийн хэрэглээ	63
Зураг 2.	Бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлалын төслийн эдийн засгийн бүсчлэл	69
Зураг 3.	Эдийн засгийн бүсчлэл тогтоох, өсөлтийн төвүүдийг тодорхойлох шалгуур үзүүлэлт	70
Зураг 4.	Эдийн засгийн өсөлтийн төвүүд	70
Зураг 5.	Авлигын төсөөллийн индексийн оноо, эрэмбэ	72
Зураг 6.	Авлигын төсөөллийн индексийн эрэмбэ	72
Зураг 7.	Ардчиллын индексийн оноо	73
Зураг 8.	Ардчиллын индексийн эрэмбэ	73
Зураг 9.	Ардчиллын индексийн оноо, дэлхийн топ улсуудаар	73

ХҮСНЭГТИЙН ЖАГСААЛТ

Хүснэгт 2.1.	Төсвийн зарим үзүүлэлт	29
Хүснэгт 5.1.	Дэлхийн эдийн засгийн өсөлтийн төсөөлөл	58
Хүснэгт 1.	Макро эдийн засгийн үндсэн үзүүлэлтүүд	74
Хүснэгт 2.	Бодит секторын үзүүлэлтүүд	75
Хүснэгт 3.	Нэгдсэн төсвийн үзүүлэлтүүд	76
Хүснэгт 4.	Нэгдсэн төсвийн үзүүлэлтүүд /ДНБ-д эзлэх хувиар/	77
Хүснэгт 5.	Төлбөрийн тэнцлийн үзүүлэлтүүд	78
Хүснэгт 6.	Төлбөрийн тэнцлийн үзүүлэлтүүд /ДНБ-д эзлэх хувиар/	79
Хүснэгт 7.	Мөнгөний үзүүлэлтүүд	80

ШИГТГЭЭНИЙ ЖАГСААЛТ

Шигтгээ 1.1.	Хөдөө аж ахуйн салбарын үр ашгийг нэмэгдүүлэх нь	18
Шигтгээ 1.2.	Аялал жуулчлалын салбарын хөгжлийг эрчимжүүлэх	20
Шигтгээ 1.3.	Төмөр замын тээврийн салбарын либералчлал	21
Шигтгээ 2.1.	Зээлжих зэрэглэл	33
Шигтгээ 3.1.	Эмийн үнийн өсөлт, чанар, хангамж	38
Шигтгээ 4.1.	Засгийн газрын 2022 оны 362 дугаар тогтоол	47
Шигтгээ 5.1.	ОХУ-ын эсрэг авч хэрэгжүүлсэн эдийн засгийн хориг арга хэмжээ	57
Шигтгээ 1.	Эрчим хүч	63
Шигтгээ 2.	Хөдөө аж ахуйн салбарт баримтлах бодлогын санал	64
Шигтгээ 3.	Аялал жуулчлалын салбарт баримтлах бодлогын санал	65
Шигтгээ 4.	Хөрөнгө оруулалтын орчин	66
Шигтгээ 5.	Төр хувийн хэвшлийн түншлэлийн тухай хууль	67
Шигтгээ 6.	Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний зохицуулалтын өөрчлөлт	68
Шигтгээ 7.	Бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлал	69
Шигтгээ 8.	Аймаг, сумын бүсчилсэн ногоон хөгжлийн хөрөнгө оруулалтын хөтөлбөр	71
Шигтгээ 9.	Авлигын төсөөллийн индекс	72
Шигтгээ 10.	Ардчиллын индекс	73

ТОВЧИЛСОН ҮГ

АМНАТ	Ашигт малтмалын нөөц ашигласны төлбөр
АНУ	Америкийн Нэгдсэн Улс
АХБ	Азийн Хөгжлийн Банк
БНХАУ	Бүгд Найрамдах Хятад Ард Улс
БНСУ	Бүгд Найрамдах Солонгос Улс
БНЭУ	Бүгд Найрамдах Энэтхэг Улс
БОАЖЯ	Байгаль орчин, аялал жуулчлалын яам
ГВУН	Гадаад валютын улсын нөөц
ДНБ	Дотоодын нийт бүтээгдэхүүн
ЗЗҮ	Зах зээлийн үнэлгээ
НӨАТ	Нэмэгдсэн өртгийн албан татвар
НҮБ	Нэгдсэн Үндэстний Байгууллага
ОУВС	Олон Улсын Валютын Сан
ОХУ	Оросын Холбооны Улс
ОПЕК	Газрын Тос Экспортлогч Орнуудын Байгууллага
ӨҮЦ	Өнөөгийн үнэ цэнэ
ТӨҮГ	Төрийн өмчит, үйлдвэрийн газар
УБТЗ ХНН	Улаанбаатар төмөр зам хувь нийлүүлсэн нийгэмлэг
УИХ	Улсын Их Хурал
УУХҮЯ	Уул уурхай, хүнд үйлдвэрийн яам
ХАА	Хөдөө аж ахуй
ХҮИ	Хэрэглээний үнийн индекс
ХХААХҮЯ	Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам
ЭЗХЯ	Эдийн засаг, хөгжлийн яам
ЭЗХАХБ	Эдийн засгийн хамтын ажиллагаа ба Хөгжлийн байгууллага

ХУРААНГУЙ ДҮГНЭЛТ

Сүүлийн 3 жил дэлхийн улс орнууд цар тахал, геополитикийн тогтворгүй нөхцөл байдлаас үүдэлтэй үнийн өсөлт, эдийн засгийн уналт зэрэг олон хүндрэлүүдтэй нүүр туллаа. Монгол Улсын Засгийн газраас 2023 онд макро эдийн засгийн сэргэлтийг дэмжиж, тогтворжуулах бодлогын чиглэлийг баримтлан ажиллав.

2023 онд эдийн засгийн гадаад эрэлт эрчимжиж, Засгийн газраас экспортын орлого, гадаад валютын улсын нөөц, эдийн засгийн идэвхжилийг нэмэгдүүлэхэд чиглэсэн цогц арга хэмжээ авч хэрэгжүүлсний үр дүнд Монгол Улсын эдийн засаг 7.0 хувиар өсөж, бодит эдийн засгийн хэмжээ цар тахлын өмнөх түвшнээс давлаа. Эдийн засгийн өсөлтөд уул уурхай, тээврийн салбар голлох нөлөөг үзүүлсэн бол боловсруулах, худалдаа, зочид буудал, нийтийн хоол, мэдээлэл холбоо зэрэг бусад эдийн засгийн салбарууд өсөлтийг дэмжлээ. Харин өвөлжилт, хаваржилт хүндэрсний улмаас том малын зүй бус хорогдол 2010 оны түүхэн дээд хэмжээний дараа орж хөдөө аж ахуйн салбарын үйлдвэрлэл буурснаар өсөлтийг саарууллаа.

Цар тахлын үеийн хил хязгаарлалт, тээврийн саатлаас үүдэн 2022 онд 15.3 хувиар агшсан уул уурхайн салбар 2023 онд нүүрс, зэсийн баяжмал, газрын тосны олборлолт нэмэгдсэнээр 23.4 хувиар тэллээ. Тухайлбал, нүүрс олборлолт 81.2 сая тоннд хүрч, өмнөх оноос 2.2 дахин, цар тахлын өмнөх 2019 оноос 1.6 дахин нэмэгдэв. Зэсийн баяжмалын үйлдвэрлэл 1,395 мянган тоннд хүрч, өмнөх оноос 17 хувиар өсөхөд Оюутолгойн гүний уурхайн үйлдвэрлэл эхэлсэн нь голчлон нөлөөлөв. Уул уурхайн үйлдвэрлэлийн сэргэлт болон Засгийн газраас экспортын тээврийн зохион байгуулалтыг сайжруулсны нөлөөгөөр тээврийн салбар өмнөх оноос 39.3 хувиар тэлж, эдийн засгийн өсөлтийг тэтгэлээ. Боловсруулах салбарын хувьд мах боловсруулах үйлдвэрлэл нэмэгдсэнээр өмнөх оноос 5.1 хувиар өслөө.

Эдийн засгийн дотоод эрэлт талаас цалин, тэтгэвэр, тэтгэмжийн өсөлт болон инфляцын бууралт, ханшийн тогтворжилт өрхийн бодит орлогыг сайжруулж, дотоод идэвхжилийг дэмжлээ. Төгрөгийн ханш 2023 оны сүүлийн хагаст тогтворжин аажмаар чангарч, инфляцын өсөлт саарснаар өрхийн бодит орлого өмнөх оны эцсээс 14.1 хувиар сайжрав. Мөн хөдөлмөр эрхлэлтэд гарсан нааштай өөрчлөлт өрхийн орлогыг дэмжлээ. Үр дүнд нь өрхийн хэрэглээ өмнөх оноос тэлж дотоод эрэлтийг нэмэгдүүллээ. Аж ахуйн нэгжүүдийн үндсэн хөрөнгийн хуримтлал 7 хувиар өсөхөд уул уурхай дагасан бүтээн байгуулалтын өсөлт эерэг нөлөө үзүүллээ.

Ашигт малтмалын олборлолтоос экспорт хүртэлх бүх үе шатанд цахим бүртгэл хийж, татварын тооцоолол, тайлагналыг хялбаршуулж автоматжуулснаар далд эдийн засаг хумигдаж, төсвийн орлого сайжирлаа. Уул уурхайн салбараас төсөвт төвлөрүүлсэн орлого 2023 онд өмнөх оноос 51 хувиар өссөнөөр төсвийн нийт орлого төлөвлөгөөнөөс 6 хувиар давж, төсвийн тэнцэл сүүлийн 5 жилд анх удаа ашигтай гарлаа. Төсвийн үндсэн тэнцэл ашигтай гарч, төсвийн бодлого нийт эрэлтийг бууруулах нөлөөтэй буюу инфляцыг хязгаарлах хүрээнд мөнгөний бодлоготой уялдаатай хэрэгжлээ. Монгол Улсын Засгийн газраас хугацаа тулаад байсан бондын эргэн төлөлтийг хийж, өрийн удирдлагыг амжилттай хэрэгжүүллээ. Дунд хугацаанд Засгийн газрын өрийн төлөв тогтвортой хадгалагдах хүлээлттэй байна.

Импортын тээврийн зардал буурч, валютын ханш тогтворжиж, мөнгөний болон төсвийн хатуу бодлого хэрэгжүүлсний нөлөөгөөр инфляц 2023 оны эцэст 7.9 хувьд болж буурч, төв банкны зорилтот интервалд оров. Сүүлийн 3 жилийн гадаад, дотоод эдийн засгийн хүндрэлийн нөлөөгөөр импортын хүнс, шатахууны үнэ өсөж, төгрөгийн ханш суларснаар импортын барааны гаралтай инфляц өсөөд байв. Төв банк бодлогын хүүг 2022 онд нийт 7 нэгж хувиар нэмэгдүүлсэн бол 2023 онд 13 хувьд хэвээр хадгаллаа. Хэдийгээр бодлогын хүүг бууруулаагүй ч мөнгөний нийлүүлэлт 2023 онд 26.8 хувиар өслөө. Мөнгөний нийлүүлэлт өсөхөд уул уурхайн бүтээгдэхүүний экспортын орлого нэмэгдсэнээр арилжааны банкнуудын гадаад актив нэмэгдэж, дотоод зээл олголт нэмэгдсэн нь түлхүү нөлөөллөө. Улмаар банкнуудын шинээр олгосон зээлийн хэмжээ 2023 онд 41.8 их наяд төгрөг болж, өмнөх оноос 33.1 хувиар нэмэгдлээ.

Засгийн газраас 2023 онд гадаад валютын нөөц, экспортыг нэмэгдүүлэх чиглэлд авч хэрэгжүүлсэн цогц арга хэмжээнүүдийн нөлөөгөөр экспорт түүхэн дээд хэмжээнд хүрлээ. Засгийн газраас ашигт малтмал тээвэрлэх, экспортлох үйл ажиллагааны зохион байгуулалтыг сайжруулах, төрийн өмчит хуулийн этгээдүүдэд онцгой дэглэм тогтоож, уул уурхайн бүтээгдэхүүний биржийн үйл ажиллагааг эхлүүлэх зэрэг ажлуудыг хэрэгжүүллээ. Мөн Гашуунсүхайд, Шивээхүрэн хилийн боомтуудад чингэлэг тээврийн терминал байгуулж, автомат удирдлагатай тээврийн хэрэгсэл ашиглалтад нэвтэрлээ. Улмаар гадаад худалдааны тэнцэл 2023 онд 5.9 тэрбум ам.долларын ашигтай гарч, барааны экспорт өмнөх оноос 17 хувиар өсөж, 15.2 тэрбум ам.долларт хүрсэн бол импорт өмнөх оноос 6 хувиар өсөж, 9.3 тэрбум ам.долларт хүрэв. Үр дүнд нь төлбөрийн тэнцлийн урсгал данс 2007 оноос хойш анх удаа ашигтай гарч, гадаад валютын улсын нөөц түүхэн дээд түвшинд хүрлээ.

Хөдөө аж ахуйн бүтээгдэхүүний экспорт нэмэгдлээ. Макро эдийн засгийн 2023 оны бодлогын тэргүүлэх чиглэлд махны экспортыг нэмэгдүүлэх, хувийн хэвшил бизнесийн үйл ажиллагааг дэмжихээр тусгасан. Энэ хүрээнд Засгийн газраас малын махны экспортод тавих хязгаарлалтыг цуцалснаар 2023 онд махны экспорт түүхэн дээд хэмжээнд буюу 309 сая ам.долларт хүрч, өмнөх оноос 6.0 дахин нэмэгдээд байна. Мөн 2013 онд гаргасан боловсруулаагүй арьс ширний экспортыг хориглох тухай шийдвэрийг Засгийн газрын 2023 оны 10 дугаар сарын 372 дугаар тогтоолоор хүчингүй болгосноор арьс, ширний экспорт нэмэгдлээ.

МАКРО ЭДИЙН ЗАСАГТ 2023 ОНД ХЭРЭГЖҮҮЛСЭН БОДЛОГЫН ЧИГЛЭЛ

Засгийн газраас 2023 онд “Шинэ сэргэлтийн бодлого” болон “Монгол Улсын хөгжлийн 2023 оны төлөвлөгөө”-нд тусгагдсан арга хэмжээнүүдийг хэрэгжүүлэхийн зэрэгцээ эдийн засгийн үзүүлэлтэд эерэг өөрчлөлтүүд бий болгох дараах арга хэмжээг авч хэрэгжүүлээ. Үүнд:

Бодлогын чиглэл	Хэрэгжүүлсэн арга хэмжээ	Үр дүн
Нэг. Макро эдийн засгийн тогтвортой байдлыг хангах төсөв, мөнгөний хатуу бодлого хэрэгжүүлж эдийн засгийг тогтворжуулах	Төсөв, мөнгөний хатуу бодлого хэрэгжүүлж эдийн засгийг тогтворжуулах	Нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн тэнцэл 2023 онд 0.8 их наяд төгрөгийн ашигтай гарч, бодлогын хүү 13 хувьд хэвээр хадгалагдлаа.
	Валютын бодит мөнгөн орлогыг нэмэгдүүлэх багц арга хэмжээг авч хэрэгжүүлснээр валютын улсын нөөцийг нэмэгдүүлэх	2022 онд 2.7 тэрбум ам.доллар болж буураад байсан гадаад валютын улсын нөөц 2023 оны эцэст 4.9 тэрбум ам.доллар буюу түүхэн дээд түвшинд хүрлээ.
Хоёр. Экспортын биет хэмжээг цар тахлын өмнөх түвшинд хүргэж нэмэгдүүлэх	Экспортын гэрээнүүд болон олборлолтоос экспорт хүртэлх бүх шатны борлуулалтыг цахимжуулж, бүртгэлийн тогтолцоог нэвтрүүлэх	Гааль, татварын нэгдсэн удирдлага, хяналтын системийг ашиглалтад оруулж, ашигт малтмалын борлуулалт, тээвэрлэлттэй холбоотой гэрээнүүдийг бүртгэлжүүлж, олборлолтоос экспорт хүртэлх бүх шатанд ил тод байдлыг хангав.
	Ашигт малтмалыг уурхайн ам нөхцөлөөр борлуулахыг зогсоож, хил хүртэлх нөхцөлөөр (тээврийн С зөвшөөрлийг төрөөс олгохгүйгээр олборлогч ААН олгох) цаашид борлуулах	Экспортлогч компаниуд шинээр “уурхайн ам” нөхцөлөөр гэрээ байгуулахыг зогсоож “хилийн үнэ” нөхцөлөөр гэрээ байгуулах шийдвэр гаргаж, байнгын ачаа тээврийн хил нэвтрэх “С” төрлийн зөвшөөрлийг олгох эрхийг олборлогч аж ахуй нэгжүүдэд шилжүүллээ.
Гурав. Уул уурхайн бүтээгдэхүүний борлуулалт, төрийн өмчит компаниудын үйл ажиллагааг ил тод болгох	Түүхий эдийн борлуулалт, гэрээнүүдийг ил тод болгож далд эдийн засгийг бууруулах	Ашигт малтмалын экспортын ил тод байдлыг хангах хүрээнд экспортыг Гааль, татварын нэгдсэн удирдлага, хяналтын системийн бүртгэлд үндэслэн гүйцэтгэж байна.
	Уул уурхайн компаниудын үйл ажиллагаа, хөрөнгө оруулалтыг ил тод болгож хяналтын зөв тогтолцоог бий болгох	Засгийн газрын 2022 оны 449 дүгээр тогтоолоор “Эрдэнэс Тавантолгой” ХК-тай холбоотой төрийн нууцад хамааруулсан гэрээнүүдийн мэдээллийг нууцаас гаргаж, компанийн борлуулалт, хөрс хуулалт, олборлолтын гэрээний мэдээллийг олон нийтэд нээлттэй болгов.
Дөрөв. Уул уурхай, хөдөө аж ахуйн бүтээгдэхүүний боловсруулалтын түвшнийг нэг шат ахиулах	Газрын тос боловсруулах үйлдвэр байгуулах	Үйлдвэрийн үндсэн бүтээн байгуулалтыг санхүүжүүлэх БНЭУ-ын Эксим банкны зээлийн эргэн төлөлтийг 2030 он хүртэл хойшлуулж, 1-4 дүгээр хэсгийн бүтээн байгуулалтын ажил бүгд эхлэв. Мөн үйлдвэрийн дэд бүтцийн бүтээн байгуулалтыг гүйцэтгэх Хөгжлийн банкны нийт 248 тэрбум төгрөгийн зээлээс 171.6 тэрбум төгрөгийг олгоод байна.
	Махны экспортыг үргэлжлүүлж нэмэгдүүлэх	2023 онд махны экспорт түүхэн дээд хэмжээ буюу 309 сая ам.долларт хүрч, өмнөх оноос 6.0 дахин нэмэгдлээ. Мөн арьс шир, ноолуурын экспортын техникийн зохицуулалтыг хойшлуулаа.

Бодлогын чиглэл	Хэрэгжүүлсэн арга хэмжээ	Үр дүн
Тав. Эдийн засгийн хөгжлийг хязгаарлаж буй салбаруудад либералчлал хэрэгжүүлэх	Эрчим хүчний салбарыг үе шаттай либералчлах	Эрчим хүний тарифыг үе шаттайгаар нэмэгдүүлж, нийлүүлэлтийг тасралтгүй байлгах хүрээнд 80МВт хүчин чадалтай батарей хуримтлуурын байгууламжийг суурилуулж, оргил ачааллын үед төв шугамд нийлүүлэн тасалдал үүсэх эрсдэлийг буурууллаа.
	Тээврийн салбарыг (төмөр зам, агаарын тээвэр) либералчлах	УБТЗ ХНН-ийн тарифыг өсгөх хүрээнд дотоодын ачаа тээврийн 16, зорчигч тээврийн 2 бүлгийн үнэ, тарифыг өөрчилж, БНХАУ-ОХУ чиглэлийн чингэлэг тээвэрлэлтэд олгож буй дамжин өнгөрөх ачаа тээвэрлэлтийн тарифын хөнгөлөлтийг 61 хувиас 51 хувь болгон буурууллаа.
	Банкны салбарын реформ, өрсөлдөөнийг дэмжих	Монголбанк “Гадаадын банкны салбар, төлөөлөгчийн газрын үйл ажиллагааны нөхцөл, шаардлагыг тогтоох, хэрэгжүүлэх журам”-ыг шинэчилж, гадаадын банк Монгол Улсад үйл ажиллагаа эхлүүлэхэд тавигддаг зарим хатуу шаардлагуудыг уян хатан болгов.
Зургаа. Хувийн хэвшил, бизнесийн үйл ажиллагааг дэмжих	Эдийн засгийг төрөлжүүлэх (хүнсний үйлдвэрлэл, аялал жуулчлал, хөнгөн үйлдвэрлэл)	Засгийн газрын 2023 оны 107 дугаар тогтоолоор хүнс, хөдөө аж ахуйн гаралтай түүхий эд боловсруулах зориулалттай тоног төхөөрөмжийг импортын барааны гаалийн албан татвараас чөлөөлөв.
	Хөрөнгө оруулалтыг дэмжих	Хөрөнгө оруулалт, бизнесийн орчныг сайжруулах, гомдол, маргааныг шийдвэрлэх асуудлыг тодорхой болгох зэрэг зохицуулалтыг Хөрөнгө оруулалтын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөлд тусган УИХ-д өргөн барилаа.
	Төрийн хүнд суртлыг бууруулах (төрийн тусгай зөвшөөрлийн цахим систем г.м)	Төрөөс олгож буй нийт 252 тусгай зөвшөөрлөөс 93 зөвшөөрлийг бүрэн цахим хэлбэрт шилжүүлээ.
Долоо. Санхүүжилтийн эх үүсвэр, төрлийг нэмэгдүүлэх	Хөрөнгийн зах зээлийг хөгжүүлэх	Хөрөнгийн зах зээлийн үнэлгээ 2023 онд өмнөх оноос 1.7 дахин өслөө.
	Даатгалын тогтолцоог бэхжүүлэх	Даатгалын тухай, Даатгалын зуучлалын тухай, Жолоочийн даатгалын тухай хуулиудын шинэчилсэн найруулгын төслийг боловсруулж байна.
Найм. Боомт, тээвэр, логикийн үйл ажиллагааг сайжруулах	Нийт боомтын нэвтрүүлэх хүчин чадлыг нэмэгдүүлэх	Тавантолгой-Гашуунсухайт авто замын нэвтрүүлэлтийг нэмэгдүүлэхээр 4 эгнээ авто зам, тээврийн хэрэгслийн улсын дугаараар төлбөрийн мэдээллийг баталгаажуулах цахим системийг нэвтрүүлж байна.
	Хилийн Гашуунсухайт боомтод төмөр замын чингэлгийн терминал байгуулах	Хилийн Гашуунсухайт боомтын төмөр замын чингэлэг терминалын бүтээн байгуулалтын ажил хийгдэж байна. 2023 оны байдлаар тус боомтоор 37.5 сая тонн бараа бүтээгдэхүүний экспорт хийгдэж, өнгөрсөн оноос 102 хувиар тус өслөө.
	Хилийн Шивээхүрэн боомтод чингэлэг тээврийн терминал байгуулах	Хилийн Шивээхүрэн боомтын чингэлэг тээврийн терминал болон автомат удирдлагатай тээврийн хэрэгсэл (AGV) 2023 оны 2 дугаар улиралд ашиглалт орлоо. Улмаар 2023 оны байдлаар тус боомтоор 19 сая тоннд бараа бүтээгдэхүүний экспорт хийгдэж, өнгөрсөн оноос 3.5 дахин нэмэгдлээ.

БОГИНО ХУГАЦААНЫ ТӨЛӨВ

Эдийн засгийн өсөлт 2024 онд тогтвортой үргэлжлэхээр байна. Оюутолгойн эрдсийн өндөр агуулгатай гүний уурхайн олборлолт үргэлжилснээр баяжмал дахь зэс болон алтны агуулга нэмэгдэж, нүүрс, алт, төмрийн хүдэр зэрэг уул уурхайн бүтээгдэхүүний олборлолт нэмэгдэхээр байгаа нь уул уурхайн салбарын үйлдвэрлэлийг дэмжихээр хүлээгдэж байна. Мөн уул уурхайн салбарын дам нөлөөгөөр тээврийн салбарын идэвхжил тогтвортой байх бол гадаадын жуулчдыг татахад чиглэсэн арга хэмжээнүүд 2024 оны сүүлийн хагас жилээс аялал жуулчлалын салбарт эерэг нөлөө үзүүлэхээр байна. Боловсруулах салбарт 2023 онд тоног төхөөрөмжийн импорт нэмэгдсэн нь тус салбарын ойрын хугацааны үйлдвэрлэлийг дэмжихээр байна. Харин цаг агаарын таагүй нөхцөл байдлын улмаас том малын зүй бус хорогдол 2023 оны түвшнээс давж, хөдөө аж ахуйн салбарын үйлдвэрлэл 2024 онд агшиж болзошгүй байна.

Түүнчлэн, цалин, тэтгэвэр нэмэгдэж байгаатай холбоотойгоор 2024 оны 2 дугаар улирлаас өрхийн хэрэглээ өсөх хүлээлттэй байна. Дотоод эрэлт, өрхийн хэрэглээ эрчимжсэнээр худалдаа, үйлчилгээний салбарууд эдийн засгийн өсөлтөд голлох нөлөө үзүүлэхээр байна. Монгол Улсын Засгийн газраас экспортыг нэмэгдүүлэхэд чиглэсэн арга хэмжээг үргэлжлүүлэн авч хэрэгжүүлэхийн зэрэгцээ БНХАУ-ын хойд хэсгийн эдийн засгийн өсөлт гадаад эрэлтийг тэтгэснээр экспортын өсөлт хадгалагдаж, нийт эдийн засгийн өсөлтийг дэмжихээр байна. Манай улсын

экспортын голлох бүтээгдэхүүнүүд болох зэсийн баяжмал, газрын тосны дэлхийн зах зээл дэх үнэ өсөхөөр хүлээгдэж байгаа бол коксжих нүүрс, төмрийн хүдрийн үнэ буурахаар хүлээгдэж байна. Гэсэн хэдий ч манай улс нүүрс, төмрийн хүдэр, баяжмалыг Уул уурхайн бүтээгдэхүүний биржээр арилжаалж эхэлсэн нь хилийн үнэд эерэг нөлөө үзүүлэхээр байна. Харин өвөлжилт, хаваржилтын нөхцөл байдал хүндэрсэнтэй холбоотойгоор нийлүүлэлтийн шалтгаантай инфляцын дарамт хадгалагдах эрсдэл хэвээр байна.

Макро эдийн засгийн 2024 оны тэргүүлэх бодлогын чиглэлд эдийн засгийн суурийг тэлэх, төрөлжүүлэх хүрээнд уул уурхайн болон уул уурхайн бус экспортыг нэмэгдүүлэх арга хэмжээг үргэлжлүүлэн авч хэрэгжүүлэхээр тусгасан. Энэ хүрээнд Гашуунсүхайд, Замын-Үүд, Шивээхүрэн хилийн боомтуудад ухаалаг гарц болон нүүрсний шинжилгээний лаборатори, рентгений тоног төхөөрөмжийг ашиглалтад оруулж, уул уурхайн бүтээгдэхүүний тээвэрлэлтийн үйл ажиллагааг оновчтой зохион байгуулан, биржээр арилжсан бүтээгдэхүүнийг хил нэвтрүүлэх тусгай гарц, горимыг бий болгож, уул уурхайн бүтээгдэхүүний экспортыг эрчимжүүлэх арга хэмжээг үргэлжлүүлэн хэрэгжүүлнэ. Түүнчлэн Шинэ сэргэлтийн бодлогын хүрээнд хэрэгжих хилийн боомтуудын бүтээн байгуулалт, төмөр зам болон автозамын сүлжээний өргөтгөл, цахилгаан эрчим хүчний станцуудын өргөтгөл болон шинэ бүтээн байгуулалтын томоохон төслүүд эдийн засгийн өсөлтөд эерэг нөлөө үзүүлэхээр байна.

ЗАСГИЙН ГАЗРААС 2024 ОНД БАРИМТЛАХ БОДЛОГО, ТЭРГҮҮЛЭХ ЧИГЛЭЛ

Монгол Улсын Их Хурлын 2023 оны 5 дугаар сарын 30-ны өдрийн 39 дүгээр тогтоолоор Монгол Улсын хөгжлийн 2024 оны төлөвлөгөөг баталсан. Монгол Улсын хөгжлийн 2024 оны төлөвлөгөөний гол зорилго нь өрхийн бодит орлогыг нэмэгдүүлэхэд чиглэсэн бөгөөд нийгэм, эдийн засгийн нөхцөл байдал, тулгамдаж буй асуудлыг шийдвэрлэх хүрээнд дараах 8 бодлогын тэргүүлэх чиглэлийг тодорхойлсон.

Нэг. Экспортыг нэмэгдүүлнэ. Уул уурхайн салбарын экспортыг тогтвортой нэмэгдүүлэхийн зэрэгцээ, гадаад худалдаа хийх процесс, шат дамжлагыг энгийн болгож, экспортыг төрөлжүүлэх, хөдөө аж ахуйн гаралтай бүтээгдэхүүний боловсруулалтын түвшнийг ахиулах замаар уул уурхайн бус экспортыг нэмэгдүүлнэ.

Хоёр. Хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлнэ. Хөрөнгө оруулалтын таатай орчныг бүрдүүлж, томоохон төсөл, хөтөлбөрүүдэд хөрөнгө оруулалт татах замаар гадаадын шууд хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлнэ.

Гурав. Хүний хөгжлийн үзүүлэлтийг сайжруулна. Бүс нутгийн хэрэгцээ шаардлагад нийцсэн төрөлжсөн технологийн коллеж (Коосэн)-ийг бүх аймагт хөгжүүлж, өөрчлөн зохион байгуулах замаар эрэлтэд нийцсэн ур чадвартай хүний нөөцийг бэлтгэж, нэмэгдүүлнэ. Эрүүл мэндийн салбарын үйлчилгээний чанар, хүртээмжийг нэмэгдүүлж, нийгмийн хамгааллын салбарт нийгмийн даатгалын шударга тогтолцоог бий болгох, нийгмийн зорилгод бүлгийг зөв тодорхойлж, зорилтот бүлэгт чиглэсэн нийгмийн халамжийн сангаас олгох тэтгэвэр тэтгэмжийг хэмжээг нэмэгдүүлэх замаар нийгмийн баталгааг сайжруулна.

Дөрөв. Аялал жуулчлалыг хөгжүүлнэ. Аялал жуулчлалын салбарын бүтээгдэхүүний нэр төрлийг нэмэгдүүлэх, дэд бүтцийн хөрөнгө оруулалтыг түлхүү хийх, агаарын тээврийг либералчлах ажлыг эрчимжүүлж, нислэгийн тоог нэмэгдүүлэх замаар жуулчдын тоо, аялал жуулчлалын орлогыг нэмэгдүүлнэ.

Тав. Хүнсний хангамж, аюулгүй байдлыг сайжруулна. Хүн амын хүнсний хэрэгцээний гол нэрийн бүтээгдэхүүний дотоодын үйлдвэрлэлийг нэмэгдүүлж, импортын хамаарлыг бууруулах, нийлүүлэлтийн сүлжээ, аюулгүй байдлыг хангах тогтолцоог бүрдүүлнэ.

Зургаа. Улаанбаатар хотын түгжрэл, агаарын бохирдлыг бууруулна. Нийтийн тээврийн санхүүжилтийн тогтолцоог оновчтой болгох, авто замын ачааллыг бууруулах эдийн засгийн хөшүүргийг нэвтрүүлэх, шинэ тойрог зам, Сэлбэ-Сэргэлт төслийг хэрэгжүүлж, нийслэлийн авто замын үндсэн сүлжээний уртыг нэмэгдүүлнэ. Шинэ суурьшлын бүс, дэд төвүүдийг байгуулж, эдийн засгийн бүсчилсэн хөгжлийг дэмжих замаар төвлөрлийг сааруулна.

Долоо. Засаглалын үзүүлэлтийг сайжруулна. Төрийн цахим үйлчилгээний хүртээмж, төрлийг нэмэгдүүлэх, харилцаа холбооны дэд бүтцийг сайжруулах замаар цахим засаглалын хөгжлийн үзүүлэлтийг сайжруулна. Хувийн хэвшлийн бүтээмжийг дэмжих, төрийн үйлчилгээг авах, хүргэх зардлыг бууруулна. Төрийн болон орон нутгийн өмчит компаниудын засаглал, үр өгөөжийг сайжруулж, үе шаттайгаар хувьцаат компанийн хэлбэрт шилжүүлнэ. Авлига, албан тушаалын гэмт хэрэгтэй тэмцэх ажлыг эрчимжүүлнэ.

Найм. Ногоон хөгжлийн үзүүлэлтийг сайжруулна. Байгальд ээлтэй, нөөцийн хэмнэлттэй, ногоон бүтээгдэхүүн, үйлдвэрлэл, үйлчилгээнд дэмжлэг үзүүлж, Улаанбаатар хотын хүнсний хог хаягдлыг дахин боловсруулах төсөл хэрэгжүүлж, хаягдал ус дахин боловсруулах үйлдвэр барина.

БҮЛЭГ I

БОДИТ СЕКТОР

- 1.1 НИЙТ НИЙЛҮҮЛЭЛТ
- 1.2 НИЙТ ЭРЭЛТ
- 1.3 ХӨДӨЛМӨР БА БИЗНЕС

I. БОДИТ СЕКТОР

ТОЙМ

Нийлүүлэлтийн шалтгаантай бараа, үйлчилгээний үнийн өсөлт тогтворжин инфляц буурч, ажилчдын тоо нэмэгдэн, нүүрсний олборлолт түүхэн дээд хэмжээнд хүрч, эдийн засгийн өсөлт 2023 онд 7.0 хувьд хүрснээр эдийн засаг тогтвортой байлаа.

Өсөлтөд нийлүүлэлт талаас уул уурхайн болон тээврийн салбар голлох нөлөөг үзүүлсэн ба боловсруулах, худалдаа, зочид буудал, нийтийн хоол, мэдээлэл холбоо зэрэг бусад эдийн засгийн салбарууд өсөлтийг дэмжлээ. Харин өвөлжилт, хаваржилт хүндэрсний улмаас том малын зүй бус хорогдол 2010 оны түүхэн дээд хэмжээний дараа орж хөдөө аж ахуйн салбарын үйлдвэрлэл буурснаар өсөлтийг сааруулаа.

Эрэлт талаас нүүрсний экспортын өсөлт гадаад тэнцвэрийг сайжруулсан бол цалин, тэтгэвэр, тэтгэмжийн өсөлт болон инфляц, ханшийн тогтворжилт иргэдийн бодит орлогыг сайжруулж, улмаар эдийн засгийн дотоод эрэлт идэвхжилээ. Эрэлт тогтвортой байхын зэрэгцээ үйлдвэрлэгчийн зардал бууран, хөдөлмөр эрхлэлт нэмэгдэн үйлдвэрлэлийн зөрүү аажмаар хумигдаж байна.

НИЙТ НИЙЛҮҮЛЭЛТ

1. Эдийн засгийн өсөлт хадгалагдаж, бодит эдийн засгийн хэмжээ цар тахлын өмнөх түвшнээс давлаа. Нэрлэсэн ДНБ 2023 онд урьдчилсан гүйцэтгэлээр 68.9 их наяд төгрөгт хүрч, өмнөх оноос 27.9 хувиар, 2015 оны зэрэгцүүлэх үнээр тооцсон бодит ДНБ 30.5 их наяд төгрөг болж, өмнөх оноос 7.0 хувиар тус тус өслөө. Эдийн засгийн өсөлтөд хөдөө аж ахуйгаас бусад салбарууд эерэг нөлөө үзүүлэв.

2. Үйлдвэрлэл талаас уул уурхайн салбарын сэргэлт эдийн засгийн өсөлтийг тэтгэлээ. БНХАУ-ын “Тэг-Ковид” бодлого, хилийн хязгаарлалт, тээвэр, логикийн саатлаас үүдэн 2022 онд 15.3 хувиар агшсан уул уурхайн салбар нүүрс болон газрын тос олборлолт, зэсийн баяжмалын үйлдвэрлэл нэмэгдсэн нөлөөгөөр 2023 онд 23.4 хувиар тэллээ. Тухайлбал, нүүрс олборлолт 2023 онд 81.2 сая тоннд хүрч, өмнөх оноос 2.2 дахин, цар тахлын өмнөх үе буюу 2019 оноос 1.6 дахин нэмэгдээд байна. Оюутолгойн гүний уурхайн үйлдвэрлэл 2023 оны 3 дугаар сард эхэлснээр зэсийн баяжмал үйлдвэрлэл 1,395 мянган тоннд хүрч, өмнөх оноос 17 хувиар өсжээ. Түүнчлэн, 2022 оны эхний хагаст хилийн боомтын үйл ажиллагааны хязгаарлалтаас үүдэн зогсоод байсан газрын тос олборлолт сэргэж, 4.9 сая баррельд хүрч, өмнөх оноос 1.9 дахин нэмэгдсэн байна. Харин алт олборлолт 14.9 тоннд, төмрийн хүдрийн олборлолт 7.6 сая тоннд хүрч, өнгөрсөн оны мөн үеэс тус тус 23 болон 19 хувиар буурсан бөгөөд 2019 оны түвшинд хүрээгүй хэвээр байна.

3. Экспортод гаргах уул уурхайн бүтээгдэхүүний гадаад эрэлт сайн байж, нүүрсний тээвэр нэмэгдсэнээр тээврийн үйлчилгээний салбар тэллээ. Тээвэрлэсэн ачааны хэмжээ 2023 онд 102 сая тоннд хүрч, уул уурхайн бүтээгдэхүүний тээвэр зохион байгуулалт сайжирснаар тээврийн салбар өмнөх онтой харьцуулахад 39.3 хувиар тэлж, эдийн засгийн өсөлтийн 1.8 нэгж хувийг бүрдүүлэв. Тээвэрээр тээсэн ачааны 85 хувийг уул уурхайн бүтээгдэхүүн дангаараа бүрдүүлж байгаа бөгөөд авто замаар тээвэрлэсэн ачаа 2.1 дахин, төмөр замаар тээвэрлэсэн ачаа 17 хувиар өслөө. Мөн манай улсын нутаг дэвсгэрээр дамжин өнгөрөх ачаа тээвэр нэмэгдсэн нь тээврийн салбарын сэргэлтэд нөлөөллөө (шигтгээ 1.3-ыг харна уу).

4. Өрхийн хэрэглээ сэргэж, аялал жуулчлал, дотоодын эдийн засгийн идэвхжил нэмэгдсэнээр худалдаа, үйлчилгээний салбарууд өслөө. Тухайлбал, бөөний болон жижиглэн худалдааны салбар 2023 онд 5.7 хувиар тэлсэн байна. Худалдааны салбарын борлуулалтын орлогын өсөлтөд хүнсний бүтээгдэхүүн болон моторт тээврийн хэрэгслийн сэлбэг, эд анги, шатахууны бөөний худалдаа зэрэг хүнсний бус бүтээгдэхүүнүүдийн борлуулалт өссөн нь гол нөлөө үзүүлжээ. Үйлчилгээний бусад салбаруудын хувьд, аялал жуулчлалын агентлаг, түрээс, лизинг, хөдөлмөр эрхлэлт гэх мэт бизнесийн үйл ажиллагааг дэмжих удирдлагын болон дэмжлэг үзүүлэх салбар 10.2 хувиар өсөв. Үүнд, улсын хилээр орсон жуулчдын тоо 2023 онд 2.1 дахин нэмэгдэж, аялал жуулчлалын салбарын үйл ажиллагаа идэвхэжсэн нь нөлөөлсөн байна (шигтгээ 1.2-ыг харна уу). Мөн зочид буудал, нийтийн хоол, шинжлэх ухааны үйл ажиллагаа, урлаг, үзвэрийн үйлчилгээний салбарууд өсөлттэй байлаа.

5. Мах боловсруулах, консервлох үйлдвэрлэл нэмэгдэж, боловсруулах салбарын өсөлтийг хадгаллаа.


“Мах, махан бүтээгдэхүүний үйлдвэр, худалдааны техникийн зохицуулалт” болон импортлогч орноос тавьдаг шаардлагын дагуу экспортлох малын махыг үйлдвэрийн аргаар боловсруулах шаардлагатай байдаг. 2023 оны 2 дугаар сард Засгийн газар махны экспортын тоо хэмжээний хязгаарлалтыг цуцалж, 2023 оны 7 дугаар сарын 1-ний өдрөөс “Экспортын гэрчилгээний нэг цонхны цахим систем”-ийг нэвтрүүлснээр махны экспорт эрчимжин түүхэн дээд хэмжээнд хүрч, мах боловсруулах үйлдвэрлэлийн өсөлтөд томоохон нөлөө үзүүлээ. Үүний үр дүнд боловсруулсан махны биет хэмжээ 57 мянган тонн болж, өмнөх оноос 123 хувиар өссөнөөр боловсруулах салбар өмнөх оноос 5.1 хувиар тэлж, нийт өсөлтийн 0.4 нэгж хувийг бүрдүүлэв. Түүнчлэн, хүнсний болон хөдөө аж ахуйн үйлдвэрлэлийг дэмжих чиглэлээр “Улсын Их Хурлын Түр хороо” ажлын хэсэг байгуулагдан, иргэд, аж ахуйн нэгжид бага хүүтэй, урт хугацааны зээл, санхүүжилт олгож байна. Тухайлбал, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрлэлийн яамнаас 2023 оны 12 дугаар сарын байдлаар нийт 830 тэрбум төгрөгийн хөнгөлөлттэй зээлийг 11 арилжааны банкаар дамжуулж иргэд, аж ахуйн нэгжүүдэд олгосон байна. Нийт зээл олголтын 73.2 хувь нь үйлдвэрлэлийг дэмжихэд чиглэсэн ба үүнээс газар тариалангийн салбарт 16.1 хувь, хүнсний боловсруулах үйлдвэрлэлд 51.8 хувь, мал аж ахуйн үйлдвэрлэлд 5.4 хувийг тус тус олгосон байна. Мөн нийт зээл олголтын 20.5 хувь нь газар тариалангийн салбарын тоног төхөөрөмж, 6.1 хувь нь зоорины аж ахуй байгуулах буюу агуулах, хадгалалтын чиглэлээр, 0.1 хувь нь зөгийн балын экспортыг дэмжихэд

зориулагдсан байна. Эдгээр нь цаашид хөдөө аж ахуй болон боловсруулах салбарын үйлдвэрлэлийг нэмэгдүүлэх, бүтээмжийн өсөлтөөр дамжин хөрөнгө оруулалтыг дэмжих нөлөө үзүүлэх боломжтой.

6. Ковид-19 цар тахал, ОХУ-Украины дайны нөлөөгөөр тасалдсан барилгын материалын нийлүүлэлтийн сөрөг шокоос үүдэлтэй барилгын өртөг болон үнийн өсөлт үргэлжилсэн нь барилгын салбарын өсөлтийг удаашрууллаа.

Барилгын салбарын үйлдвэрлэлийг орон сууц, орон сууцны бус болон инженерийн барилга байгууламж, их засварын ажил гэсэн ангиллаар тооцон гаргадаг. 2023 онд барилгын салбар өмнөх оноос 0.6 хувиар өсөхөд орон сууцны бус барилгын өсөлт гол нөлөө үзүүлсэн бол инженер, орон сууцны барилга өсөлтийг хязгаарлалаа. Орон сууцны бус барилгын өсөлтөд худалдаа, үйлчилгээ, эмнэлэг, сургууль, соёлын барилгын бүтээн байгуулалт голлон нөлөөлөв. Харин 2022 оны төмөр зам, автозамын томоохон бүтээн байгуулалтын суурийн нөлөөгөөр инженерийн барилга байгууламж 2023 онд өмнөх оноос буурлаа. Мөн орон сууцны үнэ, барилгын үнийн өртгийн өсөлтөөс шалтгаалан ашиглалтад орсон орон сууцны барилга өмнөх оноос 4 хувиар буурч барилгын салбарын өсөлтийг саарууллаа. Тухайлбал, орон сууцны үнэ 2023 онд сард дунджаар 0.6 хувиар өссөн ба 2023 оны 12 дугаар сард өмнөх оны мөн үеэс 8 хувиар өссөн байна. Орон сууцны үнийн өсөлтийг даган үл хөдлөх хөрөнгө худалдах, худалдан авах шилжүүлэх үйл ажиллагааны идэвхжил суларлаа.

Зураг 1.1 Бодит ДНБ-ий өсөлт



7. Мэдээлэл, холбооны салбар дах хөрөнгө оруулалтын өсөлтийн нөлөөгөөр орон нутаг дах суурин интернэт хэрэглэгчийн тоо өсөж, харилцаа холбооны салбар тэллээ.

Үүрэн утасны идэвхтэй хэрэглэгчийн тоо 2023 оны жилийн эцэст 4.9 сая болж өмнөх оноос 0.3 хувиар нэмэгдэж, 4G/LTE сүлжээн дэх дата ачаалал өмнөх оноос 1.2 дахин өссөнөөр салбарын орлого өмнөх оноос 21.8 хувиар өслөө. Түүнчлэн суурин интернэт хэрэглэгчийн тоо өмнөх оноос 21 хувиар, IPTV идэвхтэй хэрэглэгчийн тоо 431 мянга болж өмнөх оноос 23 хувиар тус тус нэмэгдсэнээр мэдээлэл холбооны салбар өмнөх оноос 16.4 хувиар тэлж, нийт эдийн засгийн өсөлтийн 0.5 нэгж хувийг бүрдүүллээ. Тухайлбал, суурин интернэт хэрэглэгчдийн тоо Сэлэнгэ аймагт 267 хувь, Дорноговь аймагт 200 хувь, Орхон аймагт 182 хувь, Дархан-Уул аймагт 142 хувь, Улаанбаатар хотод 27 хувиар тус тус өссөн байна.

Түүнчлэн, дээр дурдсанаас бусад салбарууд өсөлтөд эерэг нөлөө үзүүлсэн байна. Тухайлбал, цахилгаан дулаан, усан хангамжийн салбаруудын үйлдвэрлэл хэвийн байж, өсөлт өмнөх оноос бага зэрэг нэмэгдэв. Мөн импортын автобензин, дизелийн түлшний онцгой албан татварын хэмжээг 2025 оны 1 дүгээр

сарын 1-ний өдрийг хүртэл тэглэсэн ч цэвэр татварын орлого 2023 оны сүүлийн улирлуудад сайн байж, эдийн засгийн өсөлтийн 0.9 нэгж хувийг бүрдүүллээ.

8. Өвөлжилт хүндэрч 2023 оны 12 сарын байдлаар нийт нутгийн 90 хувьд зудын эрсдэл өндөр байснаас хөдөө аж ахуйн салбарын 90 гаруй хувийг бүрдүүлдэг мал аж ахуйн үйлдвэрлэл буурч эдийн засгийн өсөлтөд сөргөөр нөлөөллөө.

Оны эхнээс өвөлжилт, хаваржилт хүндэрснээс шалтгаалан 2023 онд төл бойжилт 28 хувиар буурч, малын хорогдол өмнөх оноос 6.4 дахин (2010 оноос хойших хамгийн өндөр хорогдол) нэмэгдсэнээр мал аж ахуйн салбар 10.3 хувиар агшиж, нийт эдийн засгийн өсөлтийг 1.4 нэгж хувиар бууруулах нөлөө үзүүлэв. Харин газар тариалангийн салбарын үйлдвэрлэл өмнөх оноос 8 хувиар өсөж, өсөлтөд эергээр нөлөөлсөн байна. Тариалсан нийт талбай өмнөх оноос 4 хувиар нэмэгдэж, үр тариа 9.7 хувиар, хүнсний ногоо 40 хувиар, таримал тэжээл 51 хувиар, бэлтгэсэн өвс, хадлан 0.5 хувиар тус тус өслөө. Харин хураасан төмс өмнөх оноос 16 хувиар буурсан байна.

¹ Монгол Улсын Засгийн газрын 2023 оны 6 дугаар сарын 21-ний өдрийн 244 дүгээр тогтоол.

<https://legalinfo.mn/mn/detail?lawid=16759881857501>

² 2023 оны 12 дугаар сарын 20-ны өдрийн Зудын эрсдэлийн тойм мэдээ. <http://w.tsag-aqaar.gov.mn/>

ШИГТГЭЭ 1.1. ХӨДӨӨ АЖ АХУЙН САЛБАР

НӨХЦӨЛ БАЙДАЛ

Хөдөө аж ахуйн салбар нь Монгол Улсын эдийн засгийн 13 хувийг бүрдүүлдэг, уул уурхайн салбарын дараа орох үйлдвэрлэлийн том салбар юм. Тус салбарын 91 хувийг мал аж ахуй, 9 хувийг газар тариалангийн салбар бүрдүүлж байна. Хөдөө аж ахуйн салбар нь цаг уурын өөрчлөлттэй холбоотой байгалийн гэнэтийн үзэгдэл, давагдашгүй хүчин зүйлийн эрсдэлд эмзэг, үйлдвэрлэл нь өндөр хэлбэлзэлтэй, малчин өрхүүдийн орлого гадаад хүчин зүйлээс өндөр хамааралтай байдаг. Тухайлбал, өвөлжилт, хаваржилт хүндэрч, зуд тохиолдсон жилүүдэд (2000-2002, 2010, 2021, 2023 он) малын хорогдол нэмэгдэж, хөдөө аж ахуйн салбарын үйлдвэрлэл буурч байсан. Мөн тус салбарт хөдөлмөр шингээлт их буюу нийт ажилчдын 25 хувь нь ажиллаж байгаа хэдий ч хөдөлмөрийн бүтээмж улсын дунджаас 48.3 хувиар доогуур, малтай өрхүүдийн 84.3 хувийг 500-аас бага малтай өрх эзэлдэг учраас үйлдвэрлэлийн өртөг өндөр, үр ашигтай үйлдвэрлэл эрхлэхэд хүндрэлтэй байна.

Түүнчлэн, хөдөө аж ахуйн салбарт төрийн оролцоо өндөр байгаа бөгөөд түүхий эд бэлтгэн нийлүүлэгч буюу малчин, тариаланчдад арьс шир, улаанбуудай, нөөцийн мах, сүү, ноос, ноолуур гэх мэт гарцад суурилсан дэмжлэг, татаас олгож байна. Энэ нь тус салбарын зах зээлийн үйлдвэрлэл, худалдаанд гажуудал үүсгэхээс гадна байгаль орчны тогтвортой байдалд их хохирол учруулж болзошгүй байна. Түүнчлэн ХАА-н бүтээгдэхүүний нийлүүлэлтийн сүлжээний шат дамжлага хэт их, мах бэлтгэлийн завсрын үүргийг ихэвчлэн ченжүүд гүйцэтгэж байгаагаас эцсийн хэрэглэгч нь гулууз махыг 22-44 хувиар, жижиглэн худалдааны махыг 66-111 хувийн үнийн нэмэгдэлтэй худалдан авч байна. Өөрөөр хэлбэл ХАА-н бүтээгдэхүүний үнийн дээд хязгаарыг хүчээр тогтоож буй тогтолцоо, нийлүүлэлтийн сувгийн сул хөгжил нь салбарын хөгжлийг хязгаарлаж байна.

Мөн Монгол Улсын нийт малын тоо эрчимтэй өсөж, бэлчээр ашиглалтын зохистой харьцаа алдагдсан. Нэг сүрэгт хонь, ямааны харьцаа 3:1 байх нь зохистой гэж судлагдсан ч ямаан сүргийн тоо толгой ноолуурын үнэ цэнэ нэмэгдсэнтэй

холбоотойгоор огцом нэмэгдэж, сүүлийн 15 жилийн дунджаар хонь, ямааны харьцаа 1:1 болж, сүргийн бүтэц алдагдаж байна. Түүнчлэн, бэлчээрийн даац хэтэрч нийт нутаг дэвсгэрийн 77 хувь нь доройтсон байна.

Малын эрүүл мэндийн асуудлын хувьд, олон улсын худалдааны хорио цээртэй малын 4 гоц халдварт өвчин Монгол Улсад бүртгэгдсэн байна. Малын вакцинд хамрагдалтын хувь нь 2022 оны байдлаар шүлхий өвчний 20.7 хувь, үхрийн арьс товруутах өвчний 22.8 хувь, бог малын мялзан өвчний 5.1 хувь, хонины цэцэг өвчний 4.1 хувь байна.

Нийт малын 0.2 орчим хувийг сүү, мах, ноосны эрчимжсэн чиглэлээр үржүүлж байгаа бөгөөд өвс, хадлан тэжээлийн үнэ өндөр, эрэлт их байгаагаас газар тариалангийн бүтээгдэхүүн, өвс, хадлан, тэжээлийн үйлдвэрлэлийг нэмэгдүүлэх, бэлчээрийн мал аж ахуйд тулгуурласан хосолсон мал аж ахуйг хувийн хэвшлийг дэмжих замаар хөгжүүлж, бүтээгдэхүүний нийлүүлэлтийн тогтолцоог бүрдүүлэх боломжтой.

Газар тариалангийн салбарт ургацын гарц буурч, үр тариа тариалах боломжит талбайн хэмжээ буурах хандлагатай байна. Учир нь дэлхийн уур амьсгал өөрчлөгдөж буй өнөөгийн нөхцөлд буудай, төмсний тариалан эрхэлдэг ихэнх аж ахуйн нэгжүүд уринш-буудай, уринш-төмсийг ээлжлэн тарих болсон нь хөрсийг богино хугацаанд доройтуулж байна. Манай улсын жилийн тунадасны хэмжээ бага, тунадасны 80 хувь нь зуны улиралд буудаг учраас тогтвортой ургац авахгүй байх эрсдэлтэй байдаг.

Дэлхийн зах зээлд байгаль орчинд ээлтэй, гарал үүслийг мөшгөх боломжтой түүхий эд, бүтээгдэхүүний эрэлт өндөр байдаг. "Хариуцлагатай нүүдэлчин" малын гаралтай түүхий эд, бүтээгдэхүүний гарал үүслийг мөшгөх системд 2023 оны байдлаар 119 хоршоо хамрагдсан байгаа бөгөөд дэлхийн зах зээлд шаардагдаж буй органик бүтээгдэхүүний эрэлтэд нийцсэн бүтээгдэхүүнийг үйлдвэрлэх, экспортлох боломжит мал аж ахуйн бүтээгдэхүүний гарал үүслийг баталгаажуулж байна.

³ 2023 урьдчилсан тооцоолоор хөдөө аж ахуйн салбар нийт ДНБ-ий 10.3 хувийг эзэлж байна. Эх сурвалж: ЭЗХЯ-ны тооцоолол.

⁴ НҮБ-ын Хөгжлийн хөтөлбөр, 2023, Хөдөө аж ахуй дэмжлэг, урамшууллын судалгааны тайлан.


⁵ Хөдөө аж ахуйн бирж ХХК, 2023.

⁶ ХХААХҮЯ, 2021, Салбарын мэдээлэл.

⁷ ХХААХҮЯ, 2018, Монгол орны үр тарианы таримлын уламжлалт болон сайжруулсан сэлгээ бүхий тариалалтын технологи.


Зураг 1.2 ХАА-н салбарын үзүүлэлтүүд

1. Хөдөө аж ахуйн салбарын бодит үйлдвэрлэлийн өсөлт (хувь)




Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо

2. Хөдөө аж ахуйн салбарын хөдөлмөрийн бүтээмж (мян.төг)



Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо, ЭЗХЯ -ны тооцоолол

3. Малын тооны бүтэц (эзлэх хувь)



Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо

ХЭРЭГЖҮҮЛСЭН АРГА ХЭМЖЭЭ:

Засгийн газрын 2023 оны 233 дугаар тогтоол

Хөдөө аж ахуйн зах зээлийн өрсөлдөөн, бараа, үйлчилгээний нийлүүлэлтийг дэмжих хүрээнд Монгол Улсын Засгийн газраас “Макро эдийн засгийн тогтвортой байдлыг хангах чиглэлээр авах арга хэмжээний тухай” Засгийн газрын 233 дугаар тогтоолыг 2023 оны 6 дугаар сарын 21-ний өдөр баталсан ба Эдийн засаг, хөгжлийн яам нь тус тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллаж байна.

Тус тогтоолд мал эмнэлгийн гэрчилгээтэй холбоотой бүх шат дамжлагыг цахим хэлбэрт шилжүүлэх; мал, малын гаралтай түүхий эд, бүтээгдэхүүнийг хөдөө аж ахуйн биржээр дамжуулан худалдаалж, дундын зуучлалгүйгээр малчдаас хэрэглэгчдэд шууд хүргэх; төв, суурин газарт нийлүүлэгдэж буй байгаа махтай холбоотой төлбөр хураамж, хяналт, шалгалтын давхардлыг арилгах; Хөдөө аж ахуйн биржээр арилжаалсан бараа, түүхий эдийн тодорхойлолт олгох үйл ажиллагааг хөнгөвчлөх, үйлчилгээний хөлсний хэмжээг бууруулах зэрэг арга хэмжээнүүдийг хэрэгжүүлэхээр холбогдох байгууллагуудад үүрэг болгосон.

Тус тогтоолын хэрэгжилтийн хүрээнд:

- ХХААХҮЯ, Мал эмнэлгийн ерөнхий газар мал, амьтан, малын гаралтай түүхий эд, бүтээгдэхүүнд мал эмнэлгийн гэрчилгээг цахимаар олгох “Мал эмнэлгийн нэгдсэн систем”-ийг нэвтрүүлж, гэрчилгээ авах хүсэлт гаргах, хянах, олгох зэрэг үйл ажиллагааг цахим хэлбэрт шилжүүлж, малын эмч өрхийн малын эрүүл мэндийн мэдээлэлд үндэслэн гэрчилгээг олгож, баталгаажуулж байна.

- Мал, махны биржийн арилжааг 2023 оны 3 дугаар улиралд багтаан эхлүүлэхийг тогтоолоор үүрэг болгосон ч тодорхой ахиц гараагүй тул Засгийн газрын 2023 оны 12 дугаар сарын 13-ны өдрийн хуралдааны 50 дугаар тэмдэглэлээр мал, махыг Монголын хөрөнгийн биржийн платформоор дамжуулан 2024 оны 1 дүгээр сард багтаан арилжаалахыг дахин Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд, Монголын хөрөнгийн биржид нарт үүрэг болгосон. Тус тэмдэглэлийн хэрэгжилтийг хангах зорилгоор мал махыг, Хөдөө аж ахуйн бирж эсхүл Монголын хөрөнгийн биржийн худалдааны платформоор дамжуулан арилжаалах боломжийг судлах, арга хэмжээ авч ажиллах ажлын хэсэг байгуулагдсан. Ажлын хэсгийн хуралдааны шийдвэрийн дагуу “Хөдөө аж ахуйн бирж” ХХК нь мал, махны дуудлага худалдаа хийх захиалгын цахим системийг ажиллуулж эхэлсэн бөгөөд мал, махны биржийн арилжааг зохион байгуулах ажлыг 2024 оны 1 дүгээр сарын 17-ны өдрөөс эхлүүлсэн. 2024 оны 2 дугаар сарын 28-ны өдрийн байдлаар 277 хэлцлээр 785 тонн махыг 6.6 тэрбум төгрөгөөр арилжсан бөгөөд биржээр арилжсан махны 7.2 хувь нь дотоодын зах зээлд, 92.8 хувь нь экспортод гарсан байна.

- Мөн тогтоолын хэрэгжилтийг хангах хүрээнд махны экспортын нэг цонхны системийг нэвтрүүлж, экспортын гэрчилгээ олгох хугацаа багассан байна. Мэргэжлийн хяналтын байгууллага татан буугдаж салбарын яамдад хяналтын чиг үүрэг шилжин ирсэнтэй холбогдуулан аймаг, нийслэлийн мал эмнэлгийн газарт мал эмнэлгийн хяналтын улсын байцаагчийн бүтэц орон тоо нэмэгдэн ирснээр хяналтын цэгт хийгдэх хяналт шалгалтын үйл ажиллагааг зохион байгуулж, давхардлыг бүрэн арилгуулсан.

ШИГТГЭЭ 1.2. АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН САЛБАР


НӨХЦӨЛ БАЙДАЛ

Монгол Улс 2023 онд хамгийн их буюу 594 мянган гадаадын жуулчин хүлээн авсан байна. Улсаар нь задлан харвал нийт жуулчдын 35.7 хувь нь ОХУ -аас, 23.5 хувь нь БНСУ -аас, 18.3 хувь нь БНХАУ -аас, 3.5 хувь нь Казакстан улсаас, 3.3 хувь нь Япон улсаас тус тус ирсэн байна. Жуулчдын тоо ийнхүү өссөн хэдий ч манай улсад аялахдаа өндөр зардал гаргадаг орнуудаас ирэх жуулчдын тоо цар тахлын өмнөх үе буюу 2019 онтой харьцуулахад буурсан үзүүлэлттэй байна.

Тухайлбал, жуулчдын тоог улсаар нь авч үзвэл Австрали 50.9 хувиар, Франц 46.3 хувиар, БНХАУ 35.3 хувиар, АНУ 28.1 хувиар, Герман 25.2 хувиар, Япон 19.6 хувиар тус тус буурчээ. Аялал жуулчлалын салбарт улсын хэмжээнд 571 тур оператор компани, 12 агаарын тээвэрлэгч, 442 зочид буудал, 5,526 гаруй жуулчны бааз, амралтын газар, шууд бусаар 939 рестораны, зоогийн газар болон бусад аялал жуулчлалын салбарт хамаарах аж ахуй нэгж байгууллага үйл ажиллагаа явуулж байна.


Зураг 1.3. Жуулчид

1. Жуулчдын тоо (мянган хүн)



Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо

2. Жуулчид (дүнд эзлэх хувиар, 2023 он)



Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо

ХЭРЭГЖҮҮЛСЭН АРГА ХЭМЖЭЭ

Аялал жуулчлалын салбарт 2023 онд эерэг нөлөө үзүүлэх бодлогын шийдэл⁸-ийг Аялал жуулчлалын тухай хуулийн шинэчилсэн найруулгад тусган батлуулсан. Үүнд: 1) Визийг хөнгөвчлөх, чөлөөлөх, 2) Агаарын тээврийн либералчлал, 3) Хил орчмын аялал жуулчлалыг хөгжүүлэх, 4) Эвентийн тоог нэмэгдүүлж, аялал жуулчлалыг идэвхтэй хугацааг уртасгах, 4) Сурталчилгаа, мэдээллийг сайжруулах, 5) Дэд бүтэц, стандартыг сайжруулах, 6) Жуулчдад НӨАТ-ийг буцаан олгох зэрэг бодлогын шийдлийг тусгуулсан.

Агаарын тээврийн либералчлалын бодлогын үр дүнд 2023 онд 40 гаруй улсын 150 чиглэлд нислэг хийх боломж бүрдэж, 2023 оны 7 дугаар сарын 1-ний өдрөөс дотоодын нислэгүүдийг сэргээж эхэлснээс хойш нийт 32 мянган хүн тээвэрлэсний ихэнх нь гадаадын жуулчид гэсэн статистик үзүүлэлт гарсан байна.

Аялал жуулчлалын салбарын хөгжлийг эрчимжүүлэх зорилгоор Монголд Улс 2023-2025 оныг “Монголд зочлох жил” болгон зарласан. Энэ хүрээнд 34 улсын иргэдийг 2025 оныг дуустал буюу 3 жилийн хугацаанд визийн шаардлагаас түр чөлөөлсөн. Улмаар 61 улсын иргэд Монголд визгүй зорчих боломжтой болсон.

Мөн “Монголд зочлох жил” арга хэмжээг Япон, БНХАУ, БНСУ-д зохион байгуулж, тус уриа дор Эдийн засгийн форум-2023-ыг зохион байгуулан, нийт 2,000 гаруй зочин, гадаадын өндөр түвшний 500 гаруй зочин, төлөөлөгчид урьж оролцуулж, CNN, Financial Times, Washington Post зэрэг 40 гаруй дэлхийн томоохон хэвлэл мэдээллийн хэрэгслээр манай улсын тухай эерэг мэдээ, нийтлэлүүд гарсан байна.

Түүнчлэн, өнгөрсөн онд гадаад улсаас дэлхийн алдарт жүжигчид, “инфлүнсэр”-үүд манай улсад хүрэлцэн ирсний нөлөө ирэх жилүүдэд гарах хүлээлттэй байна.

Дээрх арга хэмжээнүүдийн үр дүнд дэлхийн алдартай аялал жуулчлалын нэгдсэн мэдээллийн сайт “Lonely Planet” 50 жилийнхээ ойн босгон дээр 2024 онд аялахад хамгийн тааламжтай орны нэгээр Монгол Улсыг шалгаруулсан байна. Тус мэдээлэлд дурдсанаар Монгол Улсад аялахаар зээж буй жуулчдад үндэсний хөгжим, үндэсний хоол тэр дундаа бууз болон Үндэсний их баяр наадам, байгалийн сайханд морь унаж эрх чөлөө мэдрэх боломжтой аялахад хамгийн тааламжтай, жуулчдад ээлтэй улс хэмээн онцолжээ.

⁸ Солонгос улсаас ирж буй жуулчдын урсгал нэмэгдэхэд нөлөөлсөн хүчин зүйл нь өнгөрсөн жил тус улсын иргэдийг Монголд 90 хүртэлх хоногтой визгүй зорчих боломжтой болгосон.

⁹ Монгол улсад аялж буй гадаадын жуулчдын зардлын түүвэр судалгаа, Монголбанк, Аялал жуулчлалын үндэсний төв, 2015

ШИГТГЭЭ 1.3 ТӨМӨР ЗАМЫН ТЭЭВРИЙН САЛБАРЫН ЛИБЕРАЛЧЛАЛ

Төмөр замын салбар дах үнэ, тарифын өнөөгийн зохицуулалт нь салбарын ашигтай ажиллах боломжийг бууруулснаар зайлшгүй шаардлагатай хөрөнгө оруулалт дутагдалтай байдлыг бий болгож байна. Монгол Улсын нийт төмөр зам 1,996 км бөгөөд үүнээс урд хилээс хойд хил хүртэлх чиглэлд 1,120 км орчим өргөн цагариг бүхий үргэлжилсэн төмөр замтай. УБТЗ ХНН-ийг ОХУ болон Монгол Улсын Засгийн газрууд хувь тэнцүү эзэмшдэг бөгөөд Монгол Улсын төмөр замын нийт сүлжээний 90 гаруй хувийг тус компани

эзэмшдэг. Тарифын зохицуулалтаас үүдэн тус салбарт ашигтай ажиллахад хүндрэлтэй байдгаас төмөр замын салбарт хөрөнгө оруулалт бага байдаг. Жишээ нь “УБТЗ” ХНН нь жилд дунджаар ачаа тээврээр 10-45 хувийн алдагдал, зорчигч тээврээр 45-65 хувийн алдагдал хүлээн ажиллаж байсан. Тухайлбал, 2022 онд орон нутгийн ачаа тээврийн тарифын 19 бүлгээс 13 бүлэгт нь нийт 51.3 тэрбум төгрөгийн, зорчигч тээврээс 63.1 тэрбум төгрөгийн алдагдал тус тус хүлээсэн.

Санхүүгийн үзүүлэлтүүд (тэрбум төгрөг)

	2018	2019	2020	2021	2022
Ашиг/алдагдал	3.6	5.7	11.3	49.5	(61.1)
Нийт дэлгэрэнгүй орлого	0.7	(4.4)	2.5	351.8	(23.4)

Эх сурвалж: Тээврийн статистик, ЗТХЯ


Хөрөнгө оруулалт дутагдалтай байдгаас зайлшгүй шаардлагатай зүтгүүр, ачааны вагон зэрэг үндсэн болон эргэлтийн хөрөнгийн шинэчлэл муу хийгдэж, хүчин чадлын дутагдалтай үйл ажиллагаа явуулж байна. Тухайлбал, УБТЗ-д ашиглаж байгаа 1,537 км төмөр замын 49 хувь нь Р-65 төрлийн буюу орчин үеийн өндөр чанартай, даац сайтай, стандартын төмөр зам ба үлдсэн 51 хувь нь Р-50 төрлийн 30-50 жилийн насжилттай хуучирч металлын бүтцэд өөрчлөлт орсон зам байна. Түүнчлэн, зүтгүүрийн вагоны 41 хувь, ачааны вагоны 94 хувь нь 25-аас дээш жилийн насжилттай, ашиглалтын хугацаа нь дуусах дөхсөн байна. Мөн 2021 оны байдлаар төмөр замын салбарт нийт 164.3 сая төгрөгийн хохирол гарсны 70 хувийг зүтгүүрийн гэмтлийн хохирол эзэлсэн байна.

Төмөр замаар ачаа тээвэрлэх хэрэгцээ жил бүр өсөн нэмэгдэж байна.

Цар тахлын өмнө буюу 2019 онд төмөр замаар нийт 28 сая тонн буюу хүчин чадлаас 3 сая тонноор илүү хэмжээний ачаа тээвэрлэсэн ч энэ нь тухайн оны нийт захиалгын ойролцоогоор 70 хувь нь байжээ. Ингэснээр нийт захиалгын 30 хувьд нь тээвэр хийх боломжоо алдсан байна. Төмөр замаар 2021 онд 32 сая тонн, 2022 онд 28 сая тонн, 2023 онд 32 сая тонн ачаа тээвэрлэж хүчин чадлаасаа давуулан үйл ажиллагаа явуулж байна. Иймд эдийн засгийн хэмжээ, өсөлтийг дагаж төмөр замын ачаа тээврийн хүчин чадал, үр ашгийг нэмэгдүүлэх хүрээнд бодлогын шинэчлэл зайлшгүй шаардлагатай байна.

Засгийн газраас үнэ тарифын мөрдлөгт өөрчлөлт оруулж, тарифыг ашигтай түвшинд хүртэл өсгөх чиглэл өгч дотоодын ачаа болон, зорчигч тээврийн тарифыг өөрчиллөө. Гадаад валютын улсын нөөцийг нэмэгдүүлэхэд чиглэсэн Засгийн газрын 2022 оны 362 дугаар тогтоолын хүрээнд 2022 онд төмөр замын тарифт өөрчлөлт оруулж, салбарыг либералчлах ажлыг эхлүүлээ. Тухайлбал, УБТЗ ХНН-ийн тарифыг өсгөх хүрээнд дотоодын ачаа тээврийн 16, зорчигч тээврийн 2 бүлгийн үнэ, тарифыг өөрчилж, БНХАУ-ОХУ чиглэлийн чингэлэг тээвэрлэлтэд олгож буй дамжин өнгөрөх ачаа тээвэрлэлтийн нэгдсэн нэвтрэх тарифын хөнгөлөлтийг 61 хувиас 51 хувь болгон буурууллаа.

Зураг 1.4. Төмөр замын хөдлөх бүрэлдэхүүний ашиглалт (2021 он)



Эх сурвалж: Тээврийн статистик, ЗТХЯ

Тарифын өөрчлөлт

Төрөл	Индексжүүлэлт
Химийн ачаа	30.0%
Өнгөт ба хар металл	53.4%
Мод, модон эдлэл	68.2%
Зэс, цайрын баяжмал	30.0%
Төмрийн хүдэр	8.0%
Нефть, нефтийн бүтээгдэхүүн	Өөрчлөлтгүй
Жонш	30.0%
Машин механизм	42.7%
Ноос ноолуур, арьс шир	41.8%
Хүнсний бүтээгдэхүүн	Өөрчлөлтгүй
Нүүрс /орон нутаг/	Өөрчлөлтгүй
Экспортын нүүрс	30.0%
Барилгын материал	70.8%
Гэрийн хэрэглэл	34.4%
Чингэлэг	32.3%
Бусад ачаа	30.0%
Нийт	22.5%
ОН-ийн зорчигч тээвэр	50%
ОУ-ын зорчигч тээвэр	50%
Нийт	50.0%


9. Гадаад эрэлт сайн байж, өсөлтийг тэтгэлээ.

БНХАУ-ын хойд бүс нутгийн эдийн засаг харьцангуй өндөр өссөн нь манай улсын нүүрсний эрэлтийг дэмжиж, нүүрсний экспорт 2023 онд 69 сая тоннд хүрч бараа, үйлчилгээний экспорт өнгөрсөн оноос 42.9 хувиар өсөж, төсөвт төвлөрүүлсэн уул уурхайн салбарын орлого 1.5 дахин нэмэгдэн, бараа, үйлчилгээний гадаад худалдааны алдагдал бодит дүнгээр өнгөрсөн оноос 16.6 хувиар бууран гадаад эрэлтийн төлөв сайн байв. Нийт эдийн засгийн өсөлтөд цэвэр экспорт 5.2 нэгж хувь, өрхийн хэрэглээ 4.8 нэгж хувь, төрийн хэрэглээ 1.3 нэгж хувь, үндсэн хөрөнгийн хуримтлал 2.3 нэгж хувийн тус тус эерэг нөлөө үзүүлсэн байна.

10. Өрхийн бодит орлогын өсөлт дотоод эрэлтийг идэвхжүүлж, өсөлтөд эерэг нөлөө үзүүллээ. Төгрөгийн ханш 2022 оны эхний хагаст

суларснаар иргэдийн бодит орлого 2022 оны эцэст 1.8 хувиар, 2023 оны эхний улиралд 5.9 хувиар тус тус буураад байв. Төгрөгийн ханш 2023 оны сүүлийн хагаст тогтворжин аажмаар чангарч, мөн инфляцын өсөлт саарсны зэрэгцээ Засгийн газраас иргэдийн бодит орлогыг хамгаалах хүрээнд цалин, тэтгэвэр, тэтгэмж, халамжийг 2023 оны 7 дугаар сарын 1-ний өдрөөс нэмэгдүүлснээр өрхийн хэрэглээнд ирэх дарамт буурч, өрхийн бодит орлого өнгөрсөн оны эцэсээс 14.1 хувиар сайжрав. Үр дүнд өрхийн хэрэглээ өмнөх оноос 7.4 хувиар тэлж, дотоод эрэлтийг нэмэгдүүллээ. Өрхийн бодит орлогын өсөлтөд нэрлэсэн дүнгээр цалин дунджаар 270.8 мянган төгрөг буюу 27.8 хувиар, тэтгэвэр, тэтгэмжийн орлого 61.2 мянган төгрөг буюу 13.9 хувиар, мал аж ахуйгаас орох орлого 56.3 мянган төгрөг буюу 49.8 хувиар тус тус өссөн нь голлох нөлөө үзүүллээ.

Зураг 1.5. Бодит ДНБ-ий өсөлт, өрхийн санхүү



11. Иргэдийн зээлийн өсөлт өрхүүд хэрэглээгээ нэмэгдүүлэхэд нөлөөлж байна. Зээлийн үйлчилгээ сайжирч, хялбар болсны зэрэгцээ арилжааны банкнууд богино хугацаатай, эрсдэл багатай зээлийг түлхүү олгох хандлагатай байснаар иргэдэд шинээр олгосон зээл 22.1 их наяд төгрөгт хүрч, өнгөрсөн оноос 6.3 их наяд төгрөгөөр буюу даруй 40.2 хувиар өссөн байна. Иргэдэд олгосон зээлийн үлдэгдлийн дийлэнх буюу 13.2 их наяд төгрөг нь хадгаламж барьцаалсан болон цалин, тэтгэврийн зээл байна.


12. Эдийн засаг дах үндсэн хөрөнгийн хуримтлал нэмэгдэв. Уул уурхай дагасан бүтээн байгуулалтын өсөлт эерэг нөлөө үзүүлж үндсэн хөрөнгийн хуримтлал 2023 онд 7.0 хувиар өслөө. Тухайлбал орон сууцны бус барилга байгууламж 18.2 хувиар өссөн бол уул уурхайн хүнд машин, техник хэрэгслийн импорт нэмэгдсэнээр машин тоног төхөөрөмжийн хуримтлал 6.5 хувиар өссөн байна. Түүнчлэн 3000 см3-ээс их моторын багтаамжтай суудлын автомашины импорт 73.5 сая ам.доллаароор, нийтийн тээврийн хэрэгслийн импорт 39.4 сая ам.доллаароор өссөн нь мөн нөлөөлсөн байна. Харин өвөлжилт хүнд байсны улмаас том малын зүй бус хорогдол 4.9 сая толгойд хүрч, өмнөх оноос даруй 7.4 дахин нэмэгдэн том малын тоо толгой буурсан байна. Эх үүсвэр талаас арилжааны банкнуудын шинээр олгосон зээлийн хэмжээ 2023 онд 41.8 их наяд төгрөгт хүрсэн. Үүнээс 19.7 их наяд төгрөгийг аж ахуй нэгж байгууллагуудад олгосон нь өнгөрсөн оноос 26 хувиар өссөн байна. Төсвийн хөрөнгө оруулалт 2023 онд 5.2 их наяд төгрөгт хүрч, өнгөрсөн оноос 35.7 хувиар өссөн бол гадаадын шууд хөрөнгө оруулалтын цэвэр орох урсгал 1,570 сая ам.доллар болж, өнгөрсөн оны мөн үеэс 37.3 хувиар буурсан байна.

13. Агуулах дах нөөц хөрөнгийн хэмжээ буурав. Эргэлтийн хөрөнгийн хуримтлал 45.8 хувиар буурахад нүүрсний экспорт эрчимжиж өмнөх онд эргэлтийн хөрөнгийн хуримтлалд өндөр дүнгээр бүртгэгдэж байсан олборлосон нүүрсний овоолго буурсан нь голлон нөлөөллөө. Мөн төл бойжилт 2023 онд өмнөх оноос 7.1 сая толгой буюу 27.9 хувиар буурсан болон алт тушаалт цэвэр жингээр 29.8 хувиар буурсан нь эргэлтийн хөрөнгийг бууруулсан байна.

14. Эдийн засаг боломжит үйлдвэрлэлийн дээд түвшиндээ ойртлоо. 2023 онд экспортын тээврийн зохион байгуулалт сайжирч, гадаад эрэлт тогтвортой хадгалагдсанаар 2023 оны сүүлийн хагаст үйлдвэрлэлийн сөрөг зөрүү багассан ч өвөлжилт, хаваржилтын нөхцөл байдал хүндэрснээр зүй бус хорогдол 2023 оны жилийн эцэст 2010 оноос хойш хамгийн өндөр буюу 4.9 сая толгойд хүрснээр эдийн засгийн гүйцэтгэл буурч, потенциал түвшнээсээ ялимгүй доогуур байна.

15. Үйлдвэрлэлийн орцын үнэ буурч, хөдөлмөр эрхлэлт нэмэгдэн, бизнесийн санхүүжилт сайжирсан нь үйлдвэрлэлийн гарцад эергээр нөлөөллөө. 2023 оны эцсийн байдлаар төгрөгийн ханш өмнөх оны эцсээс 34 төгрөгөөр чангарснаас гадна импортын түүхий эдийн үнэ буурч үйлдвэрлэгчийн зардал буурч, ажиллагчдын тоо 2023 оны 2 дугаар улирлаас эхлэн алгуур нэмэгдэж, 2023 оны 4 дүгээр улиралд өмнөх оны мөн үеэс 3.3 хувиар буюу 38.6 мянгаар өссөнөөр нийт үйлдвэрлэл өмнөх оноос 7 хувиар өсөв. Мөн 6 улирал дараалан сөрөг утгатай байсан бодит хүү 2023 оны сүүлийн улиралд эерэг болсон нь арилжааны банкны зээлийн нийлүүлэлтийг дэмжих эерэг хандлага ажиллагдаж эхэллээ.

Зураг 1.6. Үйлдвэрлэлийн зөрүү



ХӨДӨЛМӨР
БА БИЗНЕС**16. Хөдөө аж ахуйн салбараас бусад салбарт хөдөлмөр эрхлэлт нэмэгдлээ.**

Хөдөлмөр эрхлэлтийн түвшин 2023 оны 4 дүгээр улиралд өмнөх оны мөн үеэс 0.5 хувиар өсөж, 55.4 хувьд, ажилчид 38.6 мянган хүнээр нэмэгдэж, 1,196 мянган хүнд тус тус хүрлээ. Гэсэн ч ажилчдын тооны өсөлтийн хурд цар тахлын өмнөх үеэс 4 дахин бага байна. Салбараар харвал худалдаа, боловсруулах, тээвэр, үйлчилгээ, уул уурхай, эрчим хүчний салбарт ажилчдын тоо өссөн байна. Харин хөдөө аж ахуйн салбарт сүүлийн 2 жил дараалан зудын нөхцөл байдал хүндэрсэнтэй холбоотойгоор тайлант улиралд ажиллагчдын тоо 30 мянган хүнээр буурч, 261 мянган хүнд хүрлээ.

17. Ажилгүйдлийн түвшин буурлаа.

Ажилгүйдлийн түвшин өмнөх оны мөн үеэс 1.4 нэгж хувиар буурч, 3.9 хувьд хүрлээ. Ажилгүй иргэдийн тоо өмнөх оны мөн үеэс 16 мянгаар, цар тахлын өмнөх түвшнээс 2.2 дахин буюу 56 мянгаар тус тус буурч, 49 мянгад хүрлээ. Ажилгүй иргэдийн тоог бүтцээр нь задлан харвал бүтцийн ажилгүйдэл 0.5 мянгаар нэмэгдсэн бол түр зуурын ажилгүйдэл 14 мянгаар, мөчлөгийн ажилгүйдэл 2.5 мянгаар тус тус буурсан байна. Эдийн засаг сэргэж, идэвхжиж байгаатай холбоотойгоор мөчлөгийн болон түр зуурын ажилгүйдэл буурчээ.

18. Залуучуудын хөдөлмөрийн идэвх бусад насны бүлгүүдээс доогуур байна.

Ажиллах хүчний 8 хувийг, ажилчдын 7 хувийг, ажиллах хүчнээс гадуурх хүн амын 32 хувийг залуучууд буюу 15-24 насны иргэд бүрдүүлж байна. Ажиллагчдын тоог насны бүтцээр задлан харвал, тайлант улиралд өмнөх

оны мөн үеэс 25-54 насны ажилчдын тоо 29 мянгаар, 55-аас дээш насны ажилчдын тоо 18 мянган хүнээр тус тус нэмэгдсэн бол 15-24 насны ажилчдын тоо 8 мянгаар буурсан байна. Мөн 15-24 насны иргэдийн ажилгүйдлийн түвшин өмнөх оны мөн үеэс 1 хувиар нэмэгдэж, 10.4 хувд хүрсэн бөгөөд бусад насны бүлгүүдээс өндөр байна.

19. Ажиллах хүчнээс гадуурх хүн ам тэллээ.

Тайлант улиралд өмнөх оны мөн үеэс ажиллах хүчнээс гадуурх хүн ам 28 мянгаар, цар тахлын өмнөх үеэс 66 мянгаар тус тус нэмэгдэж, 916 мянгад хүрлээ. Шалтгаанаар ялган харвал түр зуурын буюу цалин бага учраас, ажиллах сонирхол бага байгаа, улирлын чанартай ажил хийдэг иргэдийн тоо өмнөх оны мөн үеэс 9 мянгаар нэмэгдсэн бол тэтгэвэрт гарсан, хөгжлийн бэрхшээлтэй зэрэг урт хугацаанд ажиллах хүчнээс гадуур байх иргэдийн тоо 19 мянгаар нэмэгдлээ.

20. Хөдөө аж ахуйн салбарын дундаж цалин хамгийн өндөр өсөлттэй байна.

Дундаж цалингийн хэмжээ 2023 оны 3 дугаар улирлын байдлаар өмнөх оны мөн үеэс 28 хувиар өсөж, 2,009 мянган төгрөгт хүрлээ. Салбараар задлан харвал хөдөө аж ахуй, уул уурхай, тээврийн салбарын дундаж цалин бусад салбараас илүү буюу өмнөх оны мөн үеэс 32 хувь, 27 хувь, 27 хувиар тус тус өссөн байна. Уул уурхай, тээврийн салбарын хувьд салбарын үйлдвэрлэл сэргэж, бүтээмжийн өсөлтийн нөлөөгөөр цалин өссөн бол хөдөө аж ахуйн салбарын хувьд хөдөлмөрийн нийлүүлэлт буурснаас дундаж цалин өссөн байх магадлалтай байна.

21. Худалдаа, үйлчилгээний салбарын үйл ажиллагааны идэвхжил бусад салбараас өндөр байна. Тайлант улиралд өмнөх оны мөн үетэй харьцуулахад үйл ажиллагаа явуулж байгаа аж ахуйн нэгжийн тоо 5 хувиар өсөж, 96.8 мянгад хүрсэн бол үйл ажиллагаагаа түр болон бүр мөсөн зогсоосон аж ахуйн нэгжийн тоо 12 хувиар буурч, 137.4 мянгад хүрсэн байна. Үйл ажиллагаа явуулж байгаа аж ахуйн нэгжийн өсөлтийн 4 нэгж хувийг худалдаа, үйлчилгээний 1-9 ажилтантай жижиг аж ахуйн нэгжүүд бүрдүүлсэн байна.

22. Бизнесийн үйл ажиллагаа нэг байршилд төвлөрсөн байна. Нийт бүртгэлтэй аж ахуйн нэгжийн 75 хувь, үйл ажиллагаагаа явуулж байгаа аж ахуйн нэгжийн 71 хувь нь Улаанбаатар хотод байршилтай байна. Үүнийг салбараар задлан харвал барилга, уул уурхай, худалдаа, үйлчилгээ, тээвэр, боловсруулах салбарт үйл ажиллагаа явуулж байгаа аж ахуйн нэгжийн 60-аас дээш хувь нь нийслэл хотод байршиж байна.

Зураг 1.7. Хөдөлмөр ба бизнес



БҮЛЭГ II

ТӨСВИЙН СЕКТОР

- 2.1 ТӨСВИЙН БОДЛОГО
- 2.2 ЗАСГИЙН ГАЗРЫН ӨРИЙН
ТОГТВОРТОЙ БАЙДАЛ

II. ТӨСВИЙН СЕКТОР

ТОЙМ

Уул уурхайн салбарын сэргэлт болон түүнийг дагасан тээвэр, үйлчилгээний салбарын өсөлтийн нөлөөгөөр төсвийн орлого төлөвлөгөөнөөс 6 хувиар давж, төсвийн тэнцэл сүүлийн 5 жилийн хугацаанд анх удаа ашигтай гарлаа.

Үндсэн тэнцэл ашигтай гарч, төсвийн бодлого нийт эрэлтийг бууруулах, инфляцыг хязгаарлах хүрээнд мөнгөний бодлоготой уялдаатай байна.


Монгол Улсын Засгийн газраас хугацаа тулаад байсан бондын эргэн төлөлтийг хийж, өрийн удирдлагыг амжилттай хэрэгжүүллээ. Дунд хугацаанд Засгийн газрын өрийн төлөв тогтвортой хадгалагдах хүлээлттэй байна.

ТӨСВИЙН БОДЛОГО

23. Төсвийн тэнцэл сүүлийн 5 жилд анх удаа ашигтай гарлаа. Ковид-19 цар тахал, геополитикийн тогтворгүй байдал зэрэг гадаад гэнэтийн хүчин зүйлсийн нөлөөгөөр эдийн засагт томоохон эрсдэл учирч, улсын нэгдсэн төсөв 2020 онд 4.5 их наяд төгрөг, 2021 онд 2.9 их наяд төгрөг, 2022 онд 0.9 их наяд төгрөгийн тус тус алдагдалтай гарсан. Эдгээр хүнд сорилтын цаг үед Засгийн газраас эдийн засгийг тогтворжуулах, төсвийн сахилга батыг бүх

шатанд хэрэгжүүлэх, уул уурхайн далд эдийн засгийг ил болгох, төрийн өмчит компаниудын засаглал, үр ашгийг сайжруулах арга хэмжээг авч хэрэгжүүлсний үр дүнд 2023 онд улсын төсвийн нийт орлого 24.3 их наяд төгрөгт хүрч, өмнөх оноос 31 хувиар өссөн. Улмаар төсвийн нийт тэнцэл 1.9 их наяд төгрөгийн, тэнцвэржүүлсэн тэнцэл 763 тэрбум төгрөгийн тус тус ашигтай гарлаа.

Зураг 2.1. Төсвийн орлого, зарлага, тэнцэл



24. Уул уурхайн салбар төсвийн орлогын өсөлтийг дэмжлээ. Тайлант онд нүүрсний экспорт түүхэн дээд хэмжээнд хүрч, Оюу толгойн далд уурхай ашиглалтад орж, зэсийн баяжмалын экспорт нэмэгдлээ. АМНАТ-ийг оновчтой бүрдүүлэх, олборлолтоос экспорт хүртэлх бүх үе шатанд цахим бүртгэл хийж, татварын тооцоолол, тайлагналыг хялбаршуулж автоматжуулах арга хэмжээг хэрэгжүүлээ. Үүний үр дүнд уул уурхайн салбараас төсөвт төвлөрүүлсэн орлого өмнөх оноос 2.7 их наяд төгрөг буюу 51 хувиар, АМНАТ өмнөх оноос 1.2 их наяд төгрөг буюу 43 хувиар, аж ахуй нэгжийн орлогын албан татвар 1.6 их наяд төгрөг буюу 78 хувиар өссөн нь төсвийн орлого өсөхөд голлон нөлөөллөө. Түүнчлэн бүтээгдэхүүний цэвэр татварууд өмнөх оноос 971 тэрбум төгрөг буюу 16 хувиар өсжээ. Бүтцээр нь харвал дотоодын эдийн засаг идэвхжиж, уул уурхайн бүтээгдэхүүний гарц өндөр байсны нөлөөгөөр НӨАТ-ын орлого 22 хувиар, гадаад үйл ажиллагааны орлого 13 хувиар тус тус нэмэгдсэн

байна. Харин импортын дизель түлшний онцгой албан татварыг 2023 оны 7 сарын 1-ний өдрийг хүртэл чөлөөлсөн шийдвэртэй холбоотойгоор онцгой албан татварын орлого 7 хувиар буурсан байна.

25. Иргэдийн орлогыг хамгаалах төсвийн бодлого хэрэгжлээ. Гадаад хүчин зүйлсийн нөлөөгөөр инфляц 10 хувиас дээш түвшинд хүрч, иргэдийн бодит орлогод сөргөөр нөлөөлсөн. Улмаар Монгол Улсын 2023 оны төсвийн тухай хуулийн нэмэлт, өөрчлөлтөөр цалингийн суурь итгэлцүүрийг шинэчилж, тэтгэврийн зөрүүг арилгаж, нийгмийн халамжийн тэтгэвэр тэтгэмжийг үнийн өсөлттэй уялдуулан нэмэгдүүлж, төрийн албаны цалингийн тогтолцоог 2023 оны 7 дугаар сарын 1-ний өдрөөс эхлэн шинэчлэн тогтоосон. Үүний үр дүнд цалин хөлсний зардал 2023 онд өмнөх оноос 665 тэрбум төгрөг буюу 40 хувиар, тэтгэвэр, тэтгэмжийн зардал 971 тэрбум төгрөг буюу 16 хувиар нэмэгдсэн байна.

Хүснэгт 2.1. Төсвийн зарим үзүүлэлт

Төсвийн үзүүлэлт	Гүйцэтгэл, тэрбум төгрөг				Өөрчлөлт, хувь	
	2021	2022	2023		2023 vs 2022	
			Төлөвлөгөө	Гүйц	₮	%
Бүтээгдэхүүний цэвэр татвар	4,620	6,078	7,408	7,049	971	16%
НӨАТ	2,838	3,919	4,772	4,773	854	22%
Гадаад үйл ажиллагааны орлого	939	1,292	1,644	1,464	172	13%
Онцгой албан татвар	827	848	972	790	-58	-7%
Тусгай зориулалтын орлого	17	19	20	22	3	16%
Тэтгэвэр, тэтгэмжийн зардал	4,484	5,392	6,339	6,122	730	14%
Нийгмийн даатгал	2,627	3,382	4,106	3,990	608	18%
Нийгмийн халамж	520	522	699	612	90	17%
Хүүхдийн мөнгө	1,337	1,488	1,534	1,520	32	2%
Хөрөнгийн зардал	2,982	3,813	6,218	5,175	1,362	36%


Эх сурвалж: Сангийн яам

26. Үнийн өсөлтөөс шалтгаалж хөрөнгө оруулалтын зардлын хэмжээ нэмэгдлээ. Хөрөнгө оруулалтын чиглэлээр 2023 онд шинээр төсөл хэрэгжүүлэлгүй, өмнөх онуудад эхлүүлсэн төслүүдийг дуусгах, ашиглалтад оруулах бодлого баримталсан. Хөрөнгийн зардалд 2023 онд нийт 6.2 их наяд төгрөгийн төсөл, арга хэмжээ хэрэгжүүлэхээр төлөвлөснөөс жилийн эцсийн байдлаар 5.2 их наядын санхүүжилт хийгдэж 83.2 хувийн гүйцэтгэлтэй

байна. Зориулалтаар нь задлан харвал барилга байгууламжид 3,727 тэрбум төгрөгийг, тоног төхөөрөмжид 480 тэрбум төгрөгийг, их засварт 166 тэрбум төгрөгийг бусад хөрөнгийн зардалд 803 тэрбум төгрөгийг тус тус зарцуулсан байна. Монгол Улсын төсвийн хөрөнгө оруулалтын зардлын 56 хувь нь улсын төсвөөс, 32 хувь нь гадаад зээлээс, 7 хувь нь гадаад тусламжаас, үлдсэн 7 хувь нь концессоос бүрдэж байна.

¹⁰ Засгийн газрын "Газрын тосны зарим бүтээгдэхүүний гаалийн болон онцгой албан татварын талаар авах арга хэмжээний тухай" 2022 оны 161 дүгээр тогтоол


Зураг 2.2. Төсвийн хөрөнгө оруулалтын зардал



27. Төсвийн алдагдлыг хязгаарлах, төсвийн хумих бодлого хэрэгжиж байна. Төсвийн тэнцэлд үзүүлж буй бодлогын нөлөөг төсвийн төлөвөөр, төсвийн бодлогоос үл хамаарах нөлөөг төсвийн автомат тогтворжуулагчаар тооцон харууллаа. Нөгөө талаас Засгийн газар заавал төлөх үүрэг хүлээсэн 1.1 их наяд төгрөгийн хүүгийн төлбөрийг хассан төсвийн үндсэн тэнцэл ашигтай гарсан нь төсөв хумьж

байгааг илэрхийлж байна. Эдийн засгийн мөчлөгийн нөлөөнөөс хамаарсан, төсвийн орлогын тасалдлыг автомат тогтворжуулагчаар хэмжсэн бөгөөд 2023 оны жилийн эцсийн байдлаар 110 тэрбум төгрөгт хүрсэн байна.

Зураг 2.3. Төсвийн төлөв, тэнцэл, автомат тогтворжуулагч



¹¹ Засгийн газрын төсвийн бодлогоос үл хамааран төсвийн тэнцэл өөрчлөгдөж, эдийн засгийг тогтворжуулах чиглэлд өөрчлөгдөж байгааг төсвийн тэнцлийн автомат тогтворжуулагч илэрхийлдэг.


ЗАСГИЙН ГАЗРЫН ӨРИЙН ТОГТВОРТОЙ БАЙДАЛ

28. Засгийн газрын нийт өрийн хэмжээ буурлаа. 2023 оны жилийн эцсийн байдлаар Засгийн газрын өрийн нэрлэсэн үлдэгдэл 30.7 их наяд төгрөг болж, өмнөх оноос 3.7 хувиар буурсан байна. Тус бууралтад Засгийн газрын дотоод өр, өрийн баталгаа харгалзан 801 тэрбум, 1,065 тэрбум төгрөгөөр буурсан нь эерэг нөлөө үзүүлсэн бол Засгийн газрын гадаад өр 678 тэрбум төгрөгөөр нэмэгдсэн нь сөрөг нөлөө үзүүллээ. Засгийн газрын гадаад өрийн өсөлтийн задаргааг харвал үнэт цаас буюу бондын хэмжээ харьцангуй тогтвортой байсан ч гадаад зээлийн өсөлт нийт гадаад өрийг нэмэгдүүлэх суурь шалтгаан болсон байна.

29. Бондуудын төлбөрийг хугацаанд нь барагдуулж, дунд хугацааны гадаад өрийн эрсдэл буурлаа. Монгол Улсын Засгийн газар сүүлийн 2 жилийн хугацаанд нийт 2.2 тэрбум

ам.долларын бондын эргэн төлөлтийг хийлээ. Тухайлбал, 2012 онд гаргасан Чингис бондын үлдэгдэл 1 тэрбум ам.доллар, 2017 онд олон улсын зах зээлд гаргасан 800 сая ам.долларын Гэрэгэ бондын үлдэгдэл болох 369 сая ам.долларыг бүрэн төлж барагдууллаа. Мөн 600 ам.долларын Хуралдай бондын төлбөрийг 2024 оны 3 дугаар сард бүрэн төлж барагдуулахаар байна. Улмаар 2025 онд төлөгдөх бондын төлбөр байхгүй болсон нь дунд хугацааны өрийн дарамтыг буурууллаа. Цаашид 2026-2028 онуудад Номад болон Сенчири-1, Сенчири-2 төслийн хүрээнд гаргасан бондуудын төлбөр төлөгдөх хуваарьтай байна. Олон улсын зах зээлд гаргасан бондуудын дундаж хүү 2020 оноос өмнө 7 хувьтай байсан бол тус хугацаанаас хойш гаргасан бондуудын хүү дунджаар 5.9 хувьтай байна. Энэ нь Монгол Улсын макро эдийн засгийн орчин сайжирч, зээлжих зэрэглэл сүүлийн жилүүдэд тогтвортой байсантай холбоотой байна.

Зураг 2.4. Засгийн газрын өрийн бүтэц, гадаад бондын үлдэгдэл



30. Засгийн газрын өрийн дунд хугацааны төлөвт үзүүлэх үндсэн тэнцлийн нөлөө өндөр байна.

Энэ хэсэгт Засгийн газрын өрийн хэмжээ ДНБ-ий өсөлт, инфляц, бодит ба нэрлэсэн гадаад болон дотоод хүү, ханш, төсвийн үндсэн тэнцэл зэрэг макро эдийн засгийн үзүүлэлтүүдээс хамааран хэрхэн өөрчлөгдөх, аль үзүүлэлтэд хариу үйлдэл хүчтэй үзүүлж байгааг шинжиллээ. Тус шинжилгээнд макро үзүүлэлтүүдийн тухайлсан нөлөөг тооцох үүднээс 1) шокийн нөлөө тооцсон хувьсагчаас бусад хувьсагчийг тогтмол; 2) шокийн нөлөө тооцсон оноос бусад онд суурь түвшин өөрчлөгдөхгүй гэж үзэв. Суурь төсөөллөөр ДНБ-ий өсөлт 7 хувьд, инфляц зорилтот түвшинд, ханшийн сулрал болон үндсэн тэнцэл сүүлийн 10 жилийн дундаж түвшинд, бусад макро үзүүлэлтүүд 2023 оны түвшинд тогтвортой байхад 2027 онд Засгийн газрын өр ДНБ-ий харьцаа 48.2 хувьтай тэнцэхээр байна.

ДНБ-ий өсөлтийн өөрчлөлт: Хэрвээ бодит ДНБ-ий өсөлт 2025 онд суурь төсөөллөөс 1 стандарт


хазайлтаар буурах тохиолдолд ДНБ-д харьцуулсан Засгийн газрын өрийн хэмжээ 2027 онд 49.8 хувь болж суурь төсөөллөөс 1.6 нэгж хувиар нэмэгдэх төсөөлөлтэй байна.

Нэрлэсэн гадаад хүүний өөрчлөлт: Харин нэрлэсэн гадаад хүү 2025 онд 2 нэгж хувиар нэмэгдсэн тохиолдолд өр болон ДНБ-ий харьцаа 2027 онд 49 хувь болж суурь хувилбараас 0.8 нэгж хувиар өндөр байхаар байна.

Валютын ханшийн өөрчлөлт: Хэрвээ төгрөгийн ам.доллартой харьцах ханш 2025 онд суурь төсөөллөөс стандарт хазайлтаар буюу 7.2 хувиар сулрахад Засгийн газрын өр болон ДНБ-ий харьцаа 2027 онд 51.1 хувьд хүрч суурь төсөөллөөс 3 хувиар өндөр байх хүлээлттэй байна.

Үндсэн тэнцлийн өөрчлөлт: Хэрвээ 2025 онд үндсэн тэнцэл суурь төсөөллөөс нэгж стандарт хазайлт буюу 5.3 нэгж хувиар буурахад 2027 онд Засгийн газрын ДНБ-д эзлэх хувь 55 хувь болж суурь төсөөллөөс 6.8 нэгж хувиар өндөр байхаар байна.

Зураг 2.5. Засгийн газрын өрийн дунд хугацааны төлөв



Дээрх өрийн тогтвортой байдлын шинжилгээ нь Засгийн газрын өрийн дунд хугацааны төлөв макро эдийн засгийн аль үзүүлэлтэд хамгийн мэдрэг байгааг харуулах зорилготой болно. Шинжилгээний үр дүнд Засгийн газрын өрийн төлөвт үндсэн тэнцлийн сөрөг шок болон валютын ханшийн сулрал хамгийн өндөр


нөлөөтэй байгаа бол нэрлэсэн гадаад хүүний шок нөлөө багатай байна. Иймд төсвийн сахилга батыг бэхжүүлэх замаар төсвийн тэнцлийг сайжруулах нь Засгийн газрын өрийн тогтвортой байдалд чухал ач холбогдолтой байна.

ШИГТГЭЭ 2.1. ЗЭЭЛЖИХ ЗЭРЭГЛЭЛ

Монгол Улс зээлжих зэрэглэлийн үнэлгээг тогтвортой хадгалж байна.

Сүүлийн 6 жилийн хугацаанд Ковид-19 цар тахал, ОХУ-Украины зэвсэгт мөргөлдөөн, дэлхий даяарх инфляцын өсөлт, төв банкуудын мөнгөний хатуу бодлого зэрэг эдийн засгийн амаргүй нөхцөл байдалтай нүүр тулсан хэдий ч Монгол Улс эдийн засгийн тогтвортой байдлыг амжилттай хадгалж, зээлжих зэрэглэлийг бууруулалгүй хадгалж чадлаа.

Зураг 2.6. Монгол Улсын зээлжих зэрэглэл



Moody's, Fitch, S&P зэрэг олон улсын санхүүгийн үнэлгээний байгууллагуудын зээлжих зэрэглэлийн үнэлгээг дэлхийн нийтэд түгээмэл ашиглаж байгаа бөгөөд жил бүр 130 гаруй орнуудыг хамруулан үнэлгээг гүйцэтгэдэг байна.

Тухайн улсын зээлжих зэрэглэл нь гадаад, дотоод зээлийн төлбөрөө эргэн төлөх чадвар, зээлийн эрсдэлийг хэмждэг үзүүлэлт бөгөөд эдийн засгийн өсөлт ба бүтэц, экспортын орлого, гадаад төлбөр түргэн гүйцэтгэх чадвар, гадаад валютын нөөц, өрийн дарамт, гадаадын хөрөнгө оруулалт, төсөв, мөнгөний бодлогын уян хатан байдал, улс төр, засаглалын үр дүнтэй байдал гэх мэт улс төр, нийгэм, эдийн засаг, санхүү, төсвийн үзүүлэлтүүдийг нэгтгэн тодорхойлдог байна.

Дээрх агентлагууд нь зээлжих зэрэглэлийг 18 ангилалд хуваан дүгнэдэг бөгөөд эрсдэлгүй хамгийн сайн (AAA), сайн үнэлгээтэй (Aa1, Aa2, Aa3, AA), дунджаас дээгүүр

(A1, A2, A3, A), дунджаас доогуур үнэлгээтэй (Baa1, Baa2, Baa3, BBB), доогуур үнэлгээтэй (Ba1, Ba2, Ba3, BB), эрсдэлтэй (B1, B2, B3, B), эрсдэл өндөртэй (Caa1, Caa2, Caa3, CCC), төлөх чадамжгүй болох эрсдэлтэй (Ca, CC), зээлээ төлөх чадамжгүй (C) гэж ангилдаг байна. Мөн зээлжих зэрэглэлийн ойрын хугацаанд хүлээгдэж буй төлөв байдлыг гурав ангилан авч үздэг ба "Эерэг" буюу үнэлгээ сайжрах хандлагатай, "Тогтвортой" буюу үнэлгээ өөрчлөгдөхгүй, "Сөрөг" буюу зэрэглэл буурах эрсдэлтэй гэж хуваадаг байна.

Монгол Улсын зээлжих зэрэглэлийн үнэлгээ 1999 оноос хойш хийгдэж байгаа бөгөөд 2024 оны 2 дугаар сарын байдлаар Moody's агентлагаас "B3 Тогтвортой", Fitch агентлагаас "B Тогтвортой", S&P байгууллагаас "B Тогтвортой" гэж үнэллээ. Ингэснээр манай улсын зээлжих зэрэглэлийн үнэлгээ 6 дахь жилдээ тогтмол хадгалагдлаа. Хамгийн сүүлд буюу 2024 оны 2 дугаар сарын 2-ны өдөр Fitch агентлагаас Монгол Улсын зээлжих зэрэглэлийн үнэлгээг зарласан бөгөөд бусад B үнэлгээтэй улсуудтай харьцуулахад дунд хугацаанд эдийн засаг өсөлт болон нэг хүнд ногдох орлогын төсөөлөл өндөр, засаглалын үзүүлэлт сайн байна гэж дүгнэжээ.

Зээлжих зэрэглэлийн үнэлгээнд хамрагдаж байгаа нийт 130 гаруй орноос Монгол Улс 110 дугаарт эрэмбэлэгдэж, дэлхийн сүүл хагаст жагсаж байна. Манай улсын эдийн засаг түүхий эдийн үнийн өөрчлөлт, гадаадын шокоос өндөр хамааралтай, экспортын төрөлжилт болон хэмжээ бага, гадаад валютын нөөцийн савлагаа их, гадаад өрийн түвшин өндөр, төсөв тогтворгүй, инфляцын хэлбэлзэл их байгаа нь зээлжих зэрэглэлийн үнэлгээнд сөргөөр нөлөөлдөг голлох хүчин зүйлс болж байна.

БҮЛЭГ III

МӨНГӨНИЙ СЕКТОР

3.1 ИНФЛЯЦ

3.2 МӨНГӨ, САНХҮҮ

III. МӨНГӨНИЙ СЕКТОР

ТОЙМ

Инфляц 2023 оны эцэст 7.9 хувьд хүрч, төв банкны зорилтот түвшинд оров. Гадаад валютын нөөц нэмэгдэж, төгрөгийн ханш тогтворжин, гадаад үнэ болон тээврийн үнийн өсөлт саарснаар импортын барааны үнийн өсөлт буурч, импортын гаралтай инфляцын дарамт буурав.


Төв банкнаас мөнгөний бодлогын хүүг 2022 онд 5 удаа, нийт 7 нэгж хувиар нэмэгдүүлсэн ба 2023 онд бодлогын хүүг 13 хувьд хэвээр хадгалах шийдвэр гаргасан. Мөнгөний нийлүүлэлт 2023 оны эцэст өмнөх оны мөн үеэс 26.8 хувиар буюу 8.0 их наяд төгрөгөөр нэмэгдэхэд төгрөгийн хадгаламж болон төгрөгийн харилцахын өсөлт голлон нөлөөлөв. Банкны салбарын шинээр олгосон зээлийн хэмжээ нэмэгдсэн байна.

31. Инфляцын түвшин 2023 онд өмнөх төсөөлөлтэй нийцтэйгээр алгуур буурч, оны эцэст нэг оронтой тоонд хадгалагдлаа. Сүүлийн дөрвөн улирлын инфляцын дундаж 10.4 хувь байсан нь зорилтот түвшнээс өндөр байгаа боловч 2022 оны инфляцын дундаж 15.2 хувьтай харьцуулахад буурлаа.

32. 2023 оны 12 дугаар сард жилийн инфляц 7.9 хувь болж, өмнөх оны мөн үеэс 5.3 нэгж хувиар буурсан байна. Нийлүүлэлтийн шалтгаантай үнийн өсөлт тогтворжиж, төгрөгийн гадаад валюттай харьцах ханш жилийн өмнөх түвшнээс чангарч, гадаад үнэ болон тээврийн зардлын өсөлт саарч,

макро эдийн засгийг тогтворжуулахад чиглэсэн арга хэмжээнүүдийн үр дүнд инфляц 2023 онд алгуур буурсан хандлагатай байв. Инфляцын бууралтын 1.3 нэгж хувийг хүнсний барааны бүлэг, 0.2 нэгж хувийг хувцас, бөс бараа, гутлын бүлэг, 0.1 нэгж хувийг гэр ахуйн тавилга, гэр ахуйн барааны бүлэг, 0.3 нэгж хувийг бусад бараа, үйлчилгээний бүлэг, 0.1 нэгж хувийг боловсролын үйлчилгээ, 0.1 нэгж хувийг зочид буудал, нийтийн хоол, дотуур байрны үйлчилгээний бүлэг бүрдүүлжээ. Үүнд эрэлтийн болон нийлүүлэлтийн гаралтай инфляцын өсөлтийн хурд буурсан болон хүнсний бүлгийн үнэ өнгөрсөн үеийн суурь нөлөөгөөр буурсан нь нөлөөллөө.

Зураг 3.1. Инфляцын бүрэлдэхүүн



33. Импортын барааны үнийн өсөлт 2022 оны 6 дугаар сараас хойш алгуур буурч, инфляцын дарамтыг бууруулж байна. Худалдааны түнш орнуудын инфляц саарч, худалдааны эргэлт сайжрахын зэрэгцээ тээврийн зардлын өсөлт саарч, төгрөгийн гадаад валюттай харьцах ханш тогтвортой байсан нь импортын барааны үнийн өсөлтийг сааруулахад голлон нөлөөлсөн байна. Үүний үр дүнд 2022 оны 12 дугаар сард 13.7 хувь байсан импортын инфляц 2023 оны эцэст 6.1 хувь болж, 7.6 нэгж хувиар буурчээ. Цар тахлын үед жилийн 30 хувь хүртэлх өсөлттэй байсан эм тарианы үнийн өсөлт 2023 оны 12 дугаар сард 9.1 хувь болж саарсан байна. Энэ нь инфляцад эзлэх эм тарианы үнийн өсөлтийг 0.7 нэгж хувиар бууруулсан байна (шигтгээ 3.1-ийг харна уу).

34. Дотоодын голлох хүнсний бүтээгдэхүүний үнийн өсөлт өндөр хэвээр байгаа нь инфляцад сөргөөр нөлөөлж байна. 2023 онд хөдөө аж ахуйн гаралтай хүнсний бүтээгдэхүүний үнэ нийлүүлэлтийн шалтгаанаас үүдэлтэйгээр эрчтэй өслөө. Тухайлбал, мах, гурил зэрэг бүтээгдэхүүний нийлүүлэлт буурч, хүнсний бүтээгдэхүүн үйлдвэрлэлийн өртөг нэмэгдсэнээр дотоодын хүнсний үнэ 2023 оны 12 дугаар сард 10.1 хувиар өссөн байна. 2023 оны 12 дугаар сард мах, махан бүтээгдэхүүн өмнөх оны мөн үеэс 16.2 хувиар, гурил болон бусад төстэй бүтээгдэхүүн өмнөх оны мөн үеэс 20.6 хувиар, сүү, сүүн бүтээгдэхүүн өмнөх оны мөн үеэс 16.6 хувиар тус тус өссөн нь нийт инфляцын 28 хувийг бүрдүүллээ.

35. Хүнсний бүлгийн үнийн өсөлт саарч, шатахуун ба хатуу түлшний суурь үеийн нөлөө арилсан нь Улаанбаатар хотын инфляц буурахад голлох нөлөө үзүүллээ. Улаанбаатар хотын инфляц өмнөх улирлаас 1.6 нэгж хувиар буурч, 8.6 хувьд хүрэхэд хүнсний бүлгийн инфляц өмнөх саруудтай харьцуулахад саарч 12.6 хувь болж 1 нэгж хувиар буурсан, АИ-92 шатахууны үнэ¹² сүүлийн нэг жил тогтвортой байгаа, хатуу түлшний өнгөрсөн оны суурь үеийн нөлөө арилсан нь нөлөөлжээ. Мөн зарим бүлгүүдийн үнийн өсөлт саарч, инфляцад эзлэх нэгж хувь нь буурлаа. Тухайлбал, хувцас бөс бараа, гутлын бүлэг 0.2 нэгж хувь, холбооны хэрэгсэл, шуудангийн үйлчилгээ 0.1 нэгж хувь, зочид буудал, нийтийн хоол, дотуур байрны үйлчилгээ 0.1 нэгж хувь, бусад бараа, үйлчилгээний бүлэг 0.3 нэгж хувиар тус тус буурсан нь Улаанбаатар хотын инфляц буурахад эергээр нөлөөллөө.

36. Суурь инфляц¹³ 2023 онд буурахандлагатай байв. Өмнөх улиралд 8.1 хувь байсан суурь инфляц 2023 оны 4 дүгээр улиралд 6.3 хувь болж 1.8 нэгж хувиар буурчээ. Суурь инфляц буурахад 2022 оны өндөр өсөлттэй суурь үеийн нөлөө арилсан болон төгрөгийн гадаад валюттай харьцах ханш тогтворжсон зэрэг нь нөлөөлсөн байна.

37. Төсөв, мөнгөний хатуу бодлого инфляцыг хязгаарлах чиглэлд уялдаатай байна. Төв банк 2022 онд мөнгөний бодлогын хүүг 5 удаа, нийт 7 нэгж хувиар нэмэгдүүлсэн бол 2023 онд бодлогын хүүг 13 хувьд хадгаллаа. Нэгдсэн төсвийн нийт тэнцэл 2023 онд 1.9 их наяд төгрөгийн ашигтай гарсан нь төсвийн бодлого инфляцыг хязгаарлах чиглэлтэй нийцтэй байгааг харуулж байна. Мөнгөний хатуу бодлогын нөлөөгөөр зээлийн хүү 16.7 хувь болж, өмнөх жилээс 1.02 нэгж хувиар өссөн ч шинээр олгосон зээлийн хэмжээ өссөөр байна.

38. Ихэнх худалдааны түнш улсуудын инфляц буурч байна. Евро бүс, АНУ, Япон, БНХАУ, Солонгос, Киргизстан, Казахстан, Гүрж зэрэг улсуудын жилийн инфляц 2023 онд буурсан бол Их Британи, Шри-Ланк, Турк, ОХУ улсуудын инфляцын түвшин өсөж, БНХАУ дефляцитай байв. 2024 оны 1 дүгээр сард дэлхийн хүнсний индекс өмнөх оны мөн үетэй харьцуулахад 10.4 хувиар буурч дэлхийн зах зээл дээр үр тариа, махны үнэ буурсан бол элсэн чихрийн үнэ өссөн үзүүлэлттэй байна. Дэлхийн чингэлэг тээврийн үнэ Улаан тэнгис дэх Суэцийн сувагт үүсээд буй халдлагаас үүдэлтэйгээр өмнөх оны мөн үеэс 93 хувиар өссөн нь импортын инфляц өсөх дарамтыг нэмэгдүүлж байна. Инфляц буурч байгаа хэдий ч зарим улс орнууд бодлогын хүүгээ нэмэгдүүлсээр байна. Тухайлбал, 2023 онд Евро бүс, Их Британи, ОХУ, Солонгос, Турк, АНУ бодлогын хүүгээ нэмэгдүүлсэн бол Киргизстан, БНХАУ, Шри-Ланк, Гүрж, Казахстан улсууд бодлогын хүүгээ бууруулжээ. Улс орнууд бодлогын хүүгээ нэмэгдүүлж байгаа нь зарим улсуудын хөдөлмөрийн идэвхжил өндөр, нийт эрэлт буурахгүй байгаа, инфляц өмнөх оны суурь нөлөөгөөр буурч байгаатай холбоотой байна.

¹² УУХҮЯ-наас Роснефть ХНХ-тэй хийсэн дараагийн хэлцлийн дагуу 2023 оны 3 дугаар сараас АИ-92 автобензинийг хямдралтай үнээр авах нөхцөл бүрдээд байна. Мөн 92 октантай автобензиний гаалийн албан татварын хувийг 2025 оны 01 дүгээр сарын 01-ний өдрийг хүртэл 0 хувиар тогтоосон.

¹³ Суурь инфляц нь хэрэглээний сагсны бараа, үйлчилгээнээс богино хугацааны үнийн хэлбэлзэл ихтэй /нийлүүлэлтийн шинжтэй/ хэсгийг хасаж тооцсон эдийн засгийн суурь динамикийг илтгэх үзүүлэлт юм.


ШИГТГЭЭ 3.1. ЭМИЙН ҮНИЙН ӨСӨЛТ, ЧАНАР, ХАНГАМЖ

Сүүлийн жилүүдэд эмийн үнэ огцом нэмэгдэж, өрхийн санхүүд үзүүлэх дарамт нэмэгдэж байна. Энэ нь Монгол Улсын эм, эмнэлгийн хэрэгслийн худалдан авалт, хангамжийн тогтолцоо бүрэн төвлөрсөн бус бөгөөд эмийн бөөний болон жижиглэнгийн үнийн дээд хэмжээг тогтоох болон хянах тогтолцоо байхгүй, жишиг үнэ хэрэглэдэггүй, мөн зайлшгүй шаардлагатай эмийг татвараас чөлөөлөх зохицуулалт байхгүйтэй холбоотой байна. Хэрэглэгчийн төлж буй эмийн үнэ Азидаа хамгийн өндөр, олон улсын жишиг үнээс 2-5 дахин өндөр байна.

Монгол Улсын эмийн зах зээл импортын эмээс өндөр хамааралтай бөгөөд зах зээлийн дөнгөж 30 орчим хувийг дотоодын эм үйлдвэрлэгчид хангаж байна. Эдгээр эмийн чанар, аюулгүй байдал, үйлчилгээний идэвхийг бодитойгоор үнэлж, дүгнэлт гаргах лавлагаа лабораторийн чадавч бэхжээгүй, эм үйлдвэрлэх, хадгалах, түгээх, худалдах зохистой дадал бүрэн хэвшээгүй зэргээс шалтгаалан эмийн чанар, аюулгүй байдал, үйлчлэлийн идэвхийн баталгааг хангах үйл явц сул, хүн амын дунд эмийн чанар, үйлчлэлд үл итгэх, эргэлзэх хандлага байна. 2022 оны байдлаар Монгол Улсын эмийн 26 үйлдвэрийн ердөө 9 буюу 35 хувь нь эмийн үйлдвэрлэлийн зохистой дадал (GMP)-ын шаардлага хангаж байна.

Өрхийн нийт хэрэглээний зардалд шууд халааснаасаа төлдөг эрүүл мэндийн зардлын эзлэх хувь 4-5 хувийн хооронд хэлбэлзэж байгаа нь Ази, Номхон далайн бүс нутгийн бусад орнуудтай ижил түвшинд байгаа ч Монгол Улсын нийт хүн амын бага болон дунд орлоготой өрхүүд эрүүл мэндийн зардлынхаа 70-96 хувийг эмийн худалдан авалтад зарцуулж байна.

Зураг 3.2. Өрхийн эрүүл мэндийн зардал



Өнөөгийн эм зүйн салбарт тулгарч буй өөр нэг асуудал нь эмийн чанар бөгөөд чанар муутай эмийг зохисгүй хэрэглэх болон зайлшгүй шаардлагатай бус эмийг их хэмжээгээр хэрэглэх явдал юм. Хэдийгээр стандартын шаардлага хангахгүй, бүртгэлгүй эсвэл хуурамч эмийн эзлэх хувь буурч байгаа боловч өндөрт тооцогдохуйц хэвээр байна.

Монгол Улсын Засгийн газар дээрх тулгамдсан асуудлуудыг шийдвэрлэх хүрээнд 2023 оны 233 дугаар тогтоолыг баталсан. Тус тогтоолд эм, эмнэлгийн хэрэгслийн чанар, нийлүүлэлт, хяналтын тогтолцоог сайжруулах талаар арга хэмжээ тусгагдсан. Эрүүл мэндийн яамнаас тус арга хэмжээний хэрэгжилтийг хангах хүрээнд дараах ажлуудыг хийгээд байна.

Үүнд:

- Эм, эмнэлгийн хяналт, зохицуулалтын газрын даргын 2023 оны А/48 дугаар тушаалаар баталсан "Эм, эмнэлгийн хэрэгслийн импорт, экспортын бүртгэл"-ийн журмын 3.1.3-д заасан нь өрсөлдөөнийг хязгаарласан заалтыг хүчингүй болгосон.

- Засгийн газрын 2024 оны 1 дүгээр сарын 25-ны өдрийн хуралдаанаар "Олон улсын чанарын шаардлага хангасан хүний эм, эмнэлгийн хэрэгсэл, био бэлдмэл, вакциныг гадаад улсын үйлдвэрлэгчээс, эсхүл олон улсын байгууллагаас шууд болон дамжуулан худалдан авах журам батлах тухай" 42 дугаар тогтоолыг батлуулсан.

- Эм, эмнэлгийн хэрэгслийн тухай хуулийн шинэчилсэн найруулгад эмийн зах зээлийн гажуудлыг засах эмийн үнийг ил тод болгон цахимжуулах, эмийг хэлцлээр худалдан авах, эмийн чанар, аюулгүй байдлыг хангах чанар, үнийг хослуулах тендерийн зохицуулалтыг бий болгох зэрэг өөрчлөлтүүдийг тусган хуулийн төслийг боловсруулаад байна.

Эм, эмнэлгийн хэрэгслийн тухай хуулийн шинэчилсэн найруулга батлагдсанаар эм, био бэлдмэл, эрүүл мэндийн нэмэлт бүтээгдэхүүн, эмнэлгийн хэрэгслийн зохицуулалтыг хэрэгжүүлэгч талуудын чиг үүрэг тодорхой болж, чанар аюулгүй байдлын зохицуулалт боловсронгуй болж, эм, эмнэлгийн хэрэгслийн үнийн хөөргөдөл буурч, иргэдийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ авахтай холбогдсон санхүүгийн эрсдэл буурах үр дүн гарна гэж хүлээгдэж байна.

39. Мөнгөний нийлүүлэлт өслөө. Мөнгөний нийлүүлэлтийн өсөлт оны эхнээс эрчимжиж, 2023 оны эцэст 26.8 хувьд хүрлээ. Мөнгөний нийлүүлэлт өсөхөд актив талаас уул уурхайн бүтээгдэхүүний экспортын орлого нэмэгдсэнээр арилжааны банкнуудын гадаад цэвэр актив нэмэгдэж, дотоод зээл олголт нэмэгдсэн нь түлхүү нөлөөллөө. Эх үүсвэр талаас төгрөгийн өгөөж нэмэгдсэнээр төгрөгийн хадгаламж болон төгрөгийн харилцах өссөн нь мөнгөний нийлүүлэлтийн өсөлтөд нөлөөллөө.

40. Арилжааны банкнуудын зээлийн үлдэгдэл өслөө. Арилжааны банкнуудын зээл олголт нэмэгдсэнтэй холбоотойгоор банкны салбарын зээлийн үлдэгдэл өсөж, 2023 оны эцсийн байдлаар 27.2 их наяд төгрөгт хүрч өмнөх оноос 23.4 хувиар өслөө. Нийт зээлийн үлдэгдлийн өсөлтийн хамгийн өндөр буюу 4.8 нэгж хувийг хэрэглээний зээл, 3.1 нэгж хувийг худалдааны салбар, 2.3 нэгж хувийг үл хөдлөх хөрөнгийн салбар, 2.2 нэгж хувийг боловсруулах салбар, 1.1 нэгж хувийг уул уурхайн салбар бүрдүүлсэн бол үлдсэн 9.5 нэгж хувийг бусад салбарын өсөлт тус тус бүрдүүлсэн байна.


41. Зээл олголт эрчимжлээ. Шинээр олгосон зээлийн хэмжээ 2023 онд 41.8 их наяд төгрөг болж, өмнөх оноос 33.1 хувиар буюу 1.7 их наяд төгрөгөөр өссөн байна. Шинээр олгосон зээлийн өсөлтөд салбаруудын оруулсан хувь нэмрээр нь харвал 7.0 нэгж хувийг цалингийн зээл, 4.0 нэгж хувийг худалдааны салбарын зээл, 3.1 нэгж хувийг

боловсруулах салбарын зээл, 2.5 нэгж хувийг хадгаламж барьцаалсан зээл, 2.4 нэгж хувийг санхүү даатгалын салбарын зээл, 2.0 нэгж хувийг үл хөдлөх хөрөнгийн салбарын зээл, 1.4 нэгж хувийг барилгын салбарын зээл, харин 10.7 нэгж хувийг бусад зээл бүрдүүлж байна.

42. Салбаруудаас худалдааны салбарын зээлийн эрэлт өндөр байгаа бол иргэдэд зориулсан зээлээс хадгаламж барьцаалсан зээлийн эрэлт хамгийн өндөр байна.

Компаниудад шинээр олгосон зээлийн хэмжээ өмнөх оноос 26 хувиар өсөж, 19.7 их наяд төгрөгийн зээлийг шинээр олгосон бөгөөд үүний 52 хувийг буюу 9.5 их наяд төгрөгийг худалдааны салбарт, 13 хувь буюу 2.4 их наяд төгрөгийг боловсруулах салбарт тус тус олгосон байна. Харин иргэдэд шинээр олгосон зээлийн хэмжээ өмнөх оноос 40 хувиар өсөж, 22.1 их наяд төгрөгт хүрсэн ба үүний 27.5 хувийг буюу 6.1 их наяд төгрөгийг хадгаламж барьцаалсан зээлд, 22.1 хувийг буюу 4.9 их наяд төгрөгийг цалингийн зээлд олгосон байна.


Зураг 3.3. Мөнгөний үзүүлэлт



43. Чанаргүй зээлийн хувь буурч байна. 2023 оны эцсийн байдлаар нийт чанаргүй зээлийн хэмжээ 2.0 их наяд төгрөгт хүрсэн ба энэ нь нийт зээлийн үлдэгдлийн 7.5 хувийг эзэлж байна. Чанаргүй зээлийн хэмжээ өмнөх оноос 20.4 тэрбум төгрөгөөр өссөн

хэдий ч нийт зээлд эзлэх хувь хэмжээгээр өмнөх оноос 1.7 нэгж хувиар буурсан эерэг үзүүлэлттэй байна. Харин аж ахуйн нэгжийн чанаргүй зээлийн хувь 13.3 хувь байгаа бол иргэдийн чанаргүй зээлийн хувь 3.3 хувьтай байна.

Зураг 3.4. Зээл



Эх сурвалж: Монголбанкны статистик

Эх сурвалж: Монголбанкны статистик
Тэмдэглэл: Олгосон зээлийн дүнг тухайн улирлын дүнгээр оруулав.

Эх сурвалж: Монголбанкны статистик
Тэмдэглэл: Аж ахуйн нэгж, иргэдийн чанаргүй зээлийн дүнг нийт зээлийн дүнд нь харьцуулан чанаргүй зээлийн хувийг тооцов.

44. Хөрөнгийн зах зээлийн үнэлгээ өслөө.

Хөрөнгийн зах зээлийн үнэлгээ 2023 онд 11.7 их наяд төгрөг болж, өмнөх оноос 1.7 дахин өслөө. Хөрөнгийн зах зээлийн үнэлгээ ДНБ-ий 17.8 хувьтай тэнцэж байгаа бөгөөд сүүлийн жилүүдэд хөрөнгийн зах зээлийн үнэлгээ болон арилжааны идэвх сайжирч байна. Нийт үнэт цаасны арилжаа 2023 онд 787 тэрбум төгрөг болж, өмнөх оноос 32.3 хувиар өссөн бөгөөд арилжааг доторх төрлөөр нь харвал 66.7 хувийг хувьцааны арилжаа, 15.7 хувийг компанийн бондын арилжаа, 8.1 хувийг хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны арилжаа, 7.7 хувийг хөрөнгө оруулалтын сангийн нэгж эрхийн арилжаа тус тус бүрдүүлсэн байна.

45. Хувьцаа, бондын арилжаа нэмэгдэв.

Өнгөрсөн 2023 онд хөрөнгийн зах зээл дээр нийт 525 тэрбум төгрөгийн хувьцааны арилжаа хийгдсэн ба 7 компани шинээр хувьцаагаа гарган арилжаалж, 338 тэрбум төгрөгийг олон нийтээс татан төвлөрүүлжээ. Мөн компанийн өрийн хэрэгслийн арилжаа 138 тэрбум төгрөг болж өмнөх оноос 3.0 хувиар буюу 4.0 тэрбум төгрөгөөр өссөн бөгөөд үүний 108 тэрбум

төгрөг нь 7 компанийн шинээр гаргасан бондын арилжаа байна. ТОП 20 индекс 2022 онд өмнөх оноос 15.4 хувиар буурсан байсан бол 2023 онд 61,437 нэгж болж өмнөх оноос 10.3 хувиар өслөө. Харин хувьцааны хоёрдогч зах зээлийн арилжааны хөрвөх чадвар 1.5 хувь болж, өмнөх оноос 0.9 нэгж хувиар буурчээ.

46. Системд нөлөө бүхий банкнууд нээлттэй хувьцаат компани болов.

2021 оны 1 дүгээр сард Банкны тухай хуульд нэмэлт өөрчлөлт орж банкны системд нөлөө бүхий банк нь нээлттэй хувьцаат компани хэлбэртэй байхаар заасан бөгөөд уг хуулийн хэрэгжилтийн хүрээнд Төрийн банк, Голомт банк, Хаан банк, Хас банк, Худалдаа хөгжлийн банк зэрэг системийн нөлөө бүхий 5 банк 2021-2023 оны хооронд олон нийтэд нээлттэй хувьцаагаа арилжиж, 303 тэрбум төгрөгийг олон нийтээс татан төвлөрүүлжээ. Улмаар иргэд олон нийт банкны хувьцаа эзэмшиж боломжтой болсон ба хөрөнгийн зах зээлийн үнэлгээ болон арилжааны идэвх сайжрахад мөн эергээр нөлөөлөв.

Зураг 3.5. Хөрөнгийн зах зээл



БҮЛЭГ IV

ГАДААД СЕКТОР

- 4.1 ГАДААД ХУДАЛДАА
- 4.2 ТӨЛБӨРИЙН ТЭНЦЭЛ
- 4.3 ГАДААД ӨР

IV. ГАДААД СЕКТОР

ТОЙМ

Сүүлийн 3 жилд дэлхий дахиныг хамарсан Ковид-19 цар тахал, геополитикийн тогтворгүй байдал, экспортын орлогын тасалдал зэрэг хүчин зүйлсийн нөлөөгөөр уул уурхайн бүтээгдэхүүний экспорт буурч, импортын хүнс, шатахууны үнэ өссөн нь гадаад валютын нөөц буурах, төгрөгийн ханш сулрах, импортын инфляцын өсөхөд нөлөөллөө.

Гэсэн хэдий ч 2021 онд голлох худалдааны түнш орнуудын эдийн засгийн эрэлт нэмэгдсэн, 2022 онд олон улсын нийлүүлэлтийн сүлжээний тасалдлаас үүдэлтэй үнийн өсөлтөөс шалтгаалан голлох түүхий эдийн үнэ өссөн, 2023 онд Засгийн газраас гадаад валютын нөөц, экспортыг нэмэгдүүлэх чиглэлд хэрэгжүүлсэн цогц арга хэмжээнүүдийн нөлөөгөөр Монгол Улсын худалдааны бараа эргэлт 3 жил дараалан өслөө.

2023 онд нүүрсний экспорт түүхэн дээд хэмжээнд хүрч, Оюутолгойн далд уурхай ашиглалтад орсноор зэсийн баяжмалын экспорт нэмэгдэж, хилийн боомтын үйл ажиллагаа жигдэрсэнтэй холбоотойгоор өмнөх жилүүдэд тасалдаад байсан газрын тосны экспорт сэргэв. Экспортын орлого өссөнөөр 2023 оны эцэст төлбөрийн тэнцлийн урсгал данс 2007 оноос хойш анх удаа ашигтай гарч, гадаад валютын улсын нөөц түүхэн дээд түвшинд хүрлээ.

47. Худалдааны эргэлт нэмэгдлээ. Монгол Улс 2023 онд дэлхийн 160 улстай худалдаа хийлээ. Өнгөрсөн 2023 онд экспортын барааны урсгал нэмэгдэж, импортын барааны үнийн өсөлтийн дарамт бага байснаар гадаад худалдааны тэнцэл өнгөрсөн оноос 23 хувиар өсөж, 5.9 тэрбум ам.долларын ашигтай гарлаа. Экспорт өмнөх оноос 17 хувиар өсөж, 15.2 тэрбум ам.долларт хүрсэн бол импорт өмнөх оноос 6 хувиар өсөж, 9.3 тэрбум ам.долларт хүрэв.

48. Экспортын голлох бүтээгдэхүүний биет хэмжээ цар тахлын өмнөх түвшинд хүрлээ.

Макро эдийн засгийн 2023 оны бодлогын тэргүүлэх чиглэлд экспортын биет хэмжээг цар тахлын өмнөх түвшинд хүргэж нэмэгдүүлэхээр тусгасан. Энэ хүрээнд Засгийн газраас гадаад валютын улсын нөөц, экспортыг нэмэгдүүлэх чиглэлд ашигт малтмал тээвэрлэх, экспортлох үйл ажиллагааны зохион байгуулалтыг сайжруулах, төрийн өмчит хуулийн этгээдүүдэд онцгой дэглэм тогтоож, компанийн үйл ажиллагаа бүтэц зохион байгуулалтыг шинэчлэх, уул уурхайн бүтээгдэхүүнийг биржийн үйл ажиллагааг эхлүүлэх зэрэг ажлуудыг хэрэгжүүлсэн. Мөн хилийн Гашуунсухайт, Шивээхүрэн боомтуудад чингэлэг тээврийн терминал байгуулж, автомат удирдлагатай тээврийн хэрэгсэл ашиглалтад нэвтэрсэн зэрэг хүчин зүйлсийн нөлөөгөөр экспортын голлох бүтээгдэхүүний биет хэмжээ цар тахлын өмнөх түвшинд амжилттай хүрлээ.

49. БНХАУ-ын коксжих төрлийн нүүрсний импорт түүхэн дээд хэмжээнд хүрлээ.

Цар тахлын дараа БНХАУ-ын коксжих нүүрсний эрэлт нэмэгдэж, нийлүүлэлтийн тогтвортой байдлыг хангах зорилгоор 2022 оны 2 дугаар улирлаас эхлэн коксжих төрлийн нүүрсний импортын татварыг тэглэх

шийдвэр гаргаж, тус шийдвэрийг 2023 оныг дуустал сунгасан. Мөн коксжих нүүрсний ханган нийлүүлэгч орныг төрөлжүүлэх бодлого хэрэгжүүлсэн. Эдгээр шийдвэрүүд нь бусад өрсөлдөгч орнуудтай харьцуулахад үнийн хувьд өрсөлдөх чадвар өндөртэй манай улсын коксжих нүүрсний эрэлтийг нэмэгдүүлснээр Монгол Улс 2023 онд 69 сая тонн нүүрс экспортоллоо.

50. Уул уурхайн бүтээгдэхүүнийг биржээр арилжаалж эхэлснээр нүүрсний үнэ 40 хүртэл хувиар өслөө.

Түүхий эдийг нээлттэй, ил тод, зах зээлийн үнээр борлуулах хүрээнд 2023 оны 1 дүгээр сард цахим арилжааг эхлүүлж нийт 3.1 сая тонн нүүрсийг дуудах үнээс дунджаар 5.6 хувиар өндөр үнээр борлуулсан байна. Уул уурхайн бүтээгдэхүүний биржийн тухай хууль 2023 оны 6 дугаар сарын 30-ны өдөр хэрэгжиж эхэлсэн ба 2023 оны байдлаар 15 сая тонн нүүрсийг дуудах үнээс дунджаар 10 хувиар, 677 мянган тонн төмрийн хүдэр баяжмалыг дуудах үнээс дунджаар 7 хувиар нэмэгдүүлэн уул уурхайн бүтээгдэхүүний биржээр борлуулаад байна. Уул уурхайн бүтээгдэхүүнийг биржээр арилжаалснаар уурхайн ам нөхцөлөөр хямд үнээр худалддаг, тээврийг худалдан авагч тал хариуцдаг гэх мэт үр ашиг багатай асуудлууд засагдлаа.

51. Оюутолгойн далд уурхай ашиглалтад орлоо.

Оюутолгойн бүлэг ордын нийт нөөцийн 80 гаруй хувь газрын гүнд оршдог. Ил уурхайтай харьцуулахад эрдсийн өндөр агуулгатай гүний уурхай ашиглалтад орсонтой холбоотойгоор 2023 онд зэсийн баяжмалын экспорт 1,525 мянган тоннд хүрч, 2016 оноос хойших дээд хэмжээнд хүрлээ. Цаашид далд уурхайн олборлолтын нөлөөгөөр зэсийн баяжмалын экспорт нэмэгдэж, манай улсын экспортын голлох бүтээгдэхүүн болохоор байна.

52. Хилийн боомтуудын үйл ажиллагаа тогтворжлоо. 2022 оны эхний хагас жилд цар тахлаас шалтгаалан Дорнод аймаг дахь хилийн боомтуудын үйл ажиллагаа хаагдаж, газрын тосны экспорт зогсоод байсан. 2023 он гарснаар хилийн боомтуудын үйл ажиллагаа тогтворжиж, газрын тосны экспорт 2023 онд 4.7 сая баррельд хүрч, өмнөх оноос 2 дахин өслөө. Мөн төмөр замын зохион байгуулалт сайжирч, төмрийн хүдрийн экспорт 5.6 сая тоннд хүрч нэмэгдлээ.


53. Малын махны экспорт түүхэн дээд хэмжээнд хүрлээ. Макро эдийн засгийн 2023 оны бодлогын тэргүүлэх чиглэлд махны экспортыг нэмэгдүүлэх, хувийн хэвшил бизнесийн үйл ажиллагааг дэмжихээр тусгасан. Энэ хүрээнд Засгийн газраас малын махны экспортод тавих хязгаарлалтыг цуцалж “Экспортын гэрчилгээний нэг цонхны цахим систем”-ийг нэвтрүүлснээр экспортлох үйл ажиллагаа хялбаршиж, 2023 онд махны экспорт түүхэн дээд хэмжээнд буюу 309 сая ам.долларт хүрч, өмнөх оноос 6.0 дахин нэмэгдээд байна.

54. Боловсруулаагүй арьс ширний экспорт нэмэгдлээ. 2013 оны 8 дугаар сард боловсруулаагүй арьс ширний экспортыг хориглох тухай шийдвэрийг

Засгийн газар баталсан. Улмаар 2013 оноос хойш арьс ширний экспортын орлого 10 дахин буурсан. Тус зохицуулалтыг Засгийн газрын 2023 оны 10 дугаар сарын 12-ны өдрийн 372 дугаар тогтоолоор хүчингүй болгосноор 2023 онд арьс, ширний экспорт 3.5 сая ам.долларт хүрлээ. 2014 оноос хойш 10 дахин буураад байсан экспортыг сэргээх боломжтой болж ОХУ, Турк, Итали, Узбекистан улсууд руу түүхий арьс шир экспортолж эхэллээ.

55. Техникийн зохицуулалтаас шалтгаалан ноолуурын экспорт буурлаа. Угаасан ноолуур экспортод гаргахыг хориглох тухай техникийн зохицуулалтыг 2022 оны 10 дугаар сард баталсан. Техникийн зохицуулалт хийхээс өмнөх саруудад дунджаар 700-1,400 тонн ноолуур экспортод гарч, дотоодын зах зээлийн дундаж үнэ 95-100 мянган төгрөгийн хооронд байсан. Уг зохицуулалт хэрэгжиж эхэлснээр ноолуурын экспорт сард дунджаар 50-100 тонн хүртлээ буурч, дотоодын зах зээлийн дундаж үнэ 88 мянган төгрөг хүрсэн. Улмаар, экспортын орлогын тасалдал, дотоодын зах зээлийн үнэ бууралт зэргээс сэргийлж, угаасан ноолуурыг экспортод гаргахыг хориглох техникийн зохицуулалтыг Засгийн газрын 2023 оны 2 дугаар сарын 8-ны өдрийн 66 дугаар тогтоолоор хойшлууллаа.

Зураг 4.1. Уул уурхайн бүтээгдэхүүний биржийн арилжаа



56. Дэлхийн улс орнууд бодлогын хүүг нэмэгдүүлэх замаар үнийн өсөлтийг хязгаарлаж, төгрөгийн ханш тогтворжиж, оны сүүлийн хагаст чангарснаар импортын барааны

үнийн дарамт бага байлаа. Ковид-19 цар тахал, геополитикийн тогтворгүй байдлаас үүдэлтэйгээр худалдааны түнш орнуудын бүтээгдэхүүний үнийн өсөлт эрчимжиж, 2022 онд импортын барааны үнийг

нэмэгдүүлснээр импорт 1.9 тэрбум ам.доллаароор өссөний 54 хувийг үнийн өсөлт бүрдүүлж байсан. Харин 2023 онд импорт 500 сая ам.доллаароор өссөний 5 орчим хувийг үнийн өсөлт бүрдүүлж байна. Худалдааны гол түнш болох БНХАУ-д үнийн бууралт явагдаж, ОХУ-Украины геополитикийн тогтворгүй байдлаас үүдэн үнийн өсөлт эрчимтэй явагдсан нефтийн бүтээгдэхүүн, бордоо, үр тарианы үнэ тогтворжиж, буурсан нь импортын үнийн дарамтыг бага байхад голлох нөлөөг үзүүлээ. Мөн манай улсын гадаад валютын нөөц нэмэгдэж, төгрөгийн ханш тогтворжиж чангарсан нь импортын үнийг буурууллаа.


57. Тээвэрлэлтийн саатлаас үүдэлтэй хил орчимд үүсэн бараа бүтээгдэхүүний бөөгнөрөл арилж, импортын барааны урсгал хэвийн үргэлжилж байна. Цар тахлын нөхцөл байдлаас шалтгаалан 2022 онд хилийн боомтуудын үйл ажиллагаа түр саатаж, БНХАУ-ын Тяньжин боомтод чингэлгийн бөөгнөрөл үүсэж, бараа татах төмөр замын хүчин чадал бага байснаас шалтгаалан барааны урсгал 3 сар хүртэлх хугацаагаар саатаж байсан бол 2023 онд хилийн боомтуудын үйл ажиллагаа хэвийн үргэлжиллээ.

58. Уул уурхай, тээвэр, боловсруулах үйлдвэрийн салбарын өсөлтийг дагаж тоног төхөөрөмж, машин механизм, дизелийн түлшний импорт өндөр байсан нь импортын өсөлтөд голлох нөлөөг үзүүлээ. 2023 онд импорт өмнөх оноос 6 хувиар өссөний 5 орчим нэгж хувийг хөрөнгө оруулалтын зориулалттай бараа буюу тоног төхөөрөмж, машин механизм, барилгын материалын импорт бүрдүүлж байна мөн хүнс,

хөдөө аж ахуйн үйлдвэрлэлийн зориулалттай тоног төхөөрөмжийг импортын барааны гаалийн албан татвараас чөлөөлснөөр тус барааны импорт 2023 онд 255 сая ам.доллар болж, өмнөх оноос 55.8 хувиар өслөө. Тоног төхөөрөмжийн импорт нэмэгдэж, цаашид дотоодын боловсруулах үйлдвэрлэлийг дэмжихээр байна. Оны сүүлийн саруудад нүүрсний экспорт саарах хандлагатай байдаг ч 2023 онд гадаад эрэлт сайн байж, оны сүүлийн саруудад нүүрс тээвэрлэлт өндөр байснаар дизелийн түлшний эрэлт нэмэгдэж, дизелийн түлшний импорт 1,090 мянган тоннд хүрч 39.0 хувиар өслөө. Мөн эрчим хүчний тасралтгүй байдлыг хангах үүднээс цахилгаан, дулааны станцуудын өргөтгөлийн ажлыг эхлүүлж, 80МВт хүчин чадалтай хуримтлуурын байгууламжийг суурилуулснаар цахилгаан тоног төхөөрөмжийн импорт 2023 онд 340 сая ам.долларт хүрч өмнөх оны мөн үеэс 46.8 хувиар өслөө. Мөн 2023 онд нийтийн тээврийн парк шинэчлэлийн ажлыг хэрэгжүүлснээр 10-аас дээш хүн тээвэрлэх зориулалттай тээврийн хэрэгслийн импорт өслөө.

59. Хүнсний бүтээгдэхүүний импорт буурлаа. Эдийн засгийн идэвхжиж, өрхийн бодит орлого, зарлага оны сүүлийн хагаст өссөнөөр 2023 оны хүнсний бус хэрэглээний бүтээгдэхүүний импорт, тэр дундаа суудлын автомашины импорт өндөр байлаа. Харин согтууруулах ундааны эргэлтэд хяналт тавих, архидан согтуурахтай тэмцэх тухай хууль 2023 оны 1 дүгээр сарын 1-ний өдрөөс эхлэн мөрдөгдөж, согтууруулах ундааны онцгой албан татвар нэмэгдсэнээр импорт буурсан нь хүнсний бүтээгдэхүүний импорт буурахад голлох нөлөөлөө.

Зураг 4.2. Гадаад худалдааны үзүүлэлт



ШИГТГЭЭ 4.1. ЗАСГИЙН ГАЗРЫН 2022 ОНЫ 362 ДУГААР ТОГТООЛ

Төлбөрийг нүүрсээр барагдуулах нөхцөлтэй болон төлбөрийг урьдчилан авч ашигласан гэрээнүүдийн нөлөөгөөр Монгол Улсын экспортын бодит мөнгөн орлого буурч, 2022 оны 8 дугаар сарын эцэст төлбөрийн тэнцлийн алдагдал 1.5 тэрбум ам.долларт хүрч, төгрөгийн ам.долларт харьцах ханш оны эхнээс огцом сулраад байв.

Эдийн засгийн тогтвортой байдлыг хангах, экспортын орлогыг нэмэгдүүлэх хүрээнд Монгол Улсын Засгийн газраас “Гадаад валютын улсын нөөцийг нэмэгдүүлэх чиглэлээр авах зарим арга хэмжээний тухай” Засгийн газрын 362 дугаар тогтоолыг 2022 оны 10 дугаар сарын 5-ны өдөр баталсан ба Эдийн засаг, хөгжлийн яам нь тус тогтоолын хэрэгжилтэд тогтмол хяналт тавьж ажиллаж байна.

Тус тогтоолд уул уурхайн биржийн тогтолцоог нэвтрүүлэх, гааль, татварын автомат бүрдүүлэлтийн систем бий болгох, ашигт малтмалын борлуулалт, хөрөнгө оруулалт, худалдан авалттай холбоотой ил тод байдлыг хангах, ашигт малтмалыг хилийн үнээр худалдан борлуулах, экспорт, тээвэрлэлтийн үйл ажиллагааг оновчтой зохион байгуулах, байнгын ачаа тээврийн хил нэвтрэх С төрлийн зорчих зөвшөөрлийг олгох эрхийг олборлолтын үйл ажиллагаа эрхлэх аж ахуйн нэгжүүдэд шилжүүлэх зэрэг цогц арга хэмжээнүүдийг авч хэрэгжүүлэхээр заасан.

Тогтоолын хэрэгжилтийг хангах хүрээнд 2022-2023 онд Засгийн газрын 3 тогтоол батлагдаж, Засгийн газрын 17 удаагийн хуралдааны тэмдэглэлийн хүрээнд нийт 58 үүрэг даалгавар Засгийн газрын гишүүд болон холбогдох байгууллагуудад өгөгдсөн байна.

Тогтоолын хэрэгжилтийн хүрээнд гарсан шийдвэрүүд: Засгийн газрын тогтоолууд

Огноо	Дугаар	Тогтоол
2022.10.26	385	“Эрдэнэс Тавантолгой” ХК-ийн талаар авах зарим арга хэмжээний тухай
2023.05.03	159	Нээлттэй цахимаар арилжсан нүүрсний экспортын талаар авах зарим арга хэмжээний тухай
2023.12.20	453	Ашигт малтмалын экспортын үйл ажиллагааны талаар авах зарим арга хэмжээний тухай

Засгийн газрын хуралдааны тэмдэглэлүүд

Огноо	Дугаар	Тэмдэглэлээр өгөгдсөн зарим үүрэг, даалгаврууд
2022.10.05	48	<ul style="list-style-type: none"> Нүүрсний ачилт, тээвэрлэлт, экспортыг нэмэгдүүлж, валютын орох урсгалыг нэмэгдүүлэх Ашигт малтмалыг олборлох, боловсруулах, тээвэрлэх зэрэг бүх дамжлагуудад цахим төлбөрийн баримт үйлдэхтэй холбоотой төлбөрийн баримтын загварыг батлах “Гаалийн хилээр нэвтрүүлэх бараа, тээврийн хэрэгсэлд гаалийн хяналт тавих нийтлэг журам”-ыг цахим бүрдүүлэлтийн системтэй нийцүүлэн шинэчлэх Уурхайн гүний гааль болон гаалийн хяналтын талбай дахь ухаалаг гарц, автомат жинг гааль, татварын автомат бүрдүүлэлтийн системд холбох Уул уурхайн биржийн тогтолцооны цахим системийг бүрдүүлэх зорилгоор уул уурхайн бүтээгдэхүүнийг цахимаар нээлттэй арилжих харилцааг зохицуулах түр журмыг боловсруулах Байнгын ачаа тээврийн хил нэвтрэх “С” төрлийн зөвшөөрөл олгох эрхийг олборлолтын үйл ажиллагаа эрхлэх аж ахуйн нэгжүүдэд шилжүүлэх Уул уурхайн олборлолт, тээвэрлэлтийн хэвийн үйл ажиллагаа явуулахад шаардлагатай дизель түлшний хангамж, нийлүүлэлтийг тогтвортой байлгах Төрийн болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдүүдийн эзэмшилд байгаа ачааны хагас вагоны хуваарилалтыг гадаад валютын бодит орлогыг тогтвортой нэмэгдүүлэх чиглэлд хамгийн үр ашигтай байх хувилбараар зохион байгуулж ажиллах “Улаанбаатар төмөр зам” ХНН-ийн ачаа болон зорчигч тээвэрлэлтийн тарифыг тус нийгэмлэгийн 2020-2025 оны дунд хугацааны тарифын бодлогын хүрээнд шийдвэрлэх, шаардлагатай бол уг бодлогод өөрчлөлт оруулах асуудлыг тус нийгэмлэгийн Ерөнхий хороогоор хэлэлцүүлэн шийдвэрлүүлэх Экспортын тээврийн гарцыг нэмэгдүүлэх, хилийн боомтуудын ажиллах цагийн хуваарьт өөрчлөлт оруулах асуудлыг судалж, танилцуулах Ашигт малтмалыг ашиглалтын тусгай зөвшөөрлийн талбай, уурхайн эдэлбэр газар, эсхүл уурхайн амнаас худалдан авагчийн болон дамжуулан борлуулагчийн заасан талбай, гаалийн хяналтын болон түр хяналтын талбай хүртэл тээвэрлэх үйл ажиллагаатай холбоотой тээврийн, зуучлалын болон эрх шилжүүлсэн зэрэг бүх төрлийн гэрээг Гааль, татварын нэгдсэн удирдлага, хяналтын системд бүртгэх Гааль, татварын нэгдсэн удирдлага, хяналтын системд бүртгэлтэй худалдан борлуулах болон тээвэрлэх үйл ажиллагаатай холбоотой гэрээний мэдээлэлд үндэслэн ухаалаг гарц суурилагдсан хилийн боомтууд дээр гаалийн бүрдүүлэлтийг автоматжуулах, шат дамжлагыг бууруулах зохион байгуулалтын арга хэмжээ авч хэрэгжүүлэх Уул уурхайн бүтээгдэхүүний биржээр арилжаалах бүтээгдэхүүний нэр төрлийг нэмэгдүүлж, биржийн арилжааг эхлүүлэх арга хэмжээ авах Хилийн Гашуунсухайт, Замын-Үүд, Шивээхүрэн боомт дээрх ухаалаг гарц, нүүрсний шинжилгээний лаборатори, рентгений тоног төхөөрөмжийг ашиглалтад оруулах Гаалийн итгэмжлэгдсэн тээврийн зөвшөөрөл олгох болон гаалийн бүрдүүлэлт хийхэд шаарддаг бичиг баримтын давхардлыг арилгаж, гаалийн бүрдүүлэлтийг цахимжуулах арга хэмжээг авч эрчимжүүлэх
2022.11.02	53	
2022.11.09	54	
2022.11.23	56	
2022.12.07	58	
2022.12.21	62	
2023.01.04	1	
2023.01.18	4	
2023.03.07	11	
2023.04.05	15	
2023.05.03	19	
2023.06.07	24	
2023.09.06	36	
2023.10.04	40	
2023.12.13	50	

ЗАСГИЙН ГАЗРЫН 2022 ОНЫ 362 ДУГААР ТОГТООЛЫН ХЭРЭГЖИЛТИЙН ХҮРЭЭНД:

- **“Эрдэнэс Тавантолгой” ХК-д онцгой дэглэм тогтоож, үйл ажиллагааны үр ашгийг дээшлүүлж, экспортыг нэмэгдүүлэв.** Гадаад валютын орох урсгалыг нэмэгдүүлж, Засгийн газрын 2022 оны 362 дугаар тогтоолыг хэрэгжүүлэх хүрээнд “Эрдэнэс Тавантолгой” ХК-д онцгой дэглэм тогтоож, Засгийн газрын бүрэн эрхт төлөөлөгчийг томилов. Онцгой дэглэмийн хугацаанд худалдан авагчид өгөх 582 сая ам.долларын өр төлбөрийг барагдуулж, 2023 онд 32.8 сая тонн нүүрс борлуулж, 2.7 их наяд төгрөгийн татвар, хураамжийг төсөвт төвлөрүүлээ. Мөн компанийн үйл ажиллагааны үр ашгийг сайжруулсны үр дүнд 2022 онд 1.3 их наяд төгрөгийн, 2023 оны хүлээгдэж буй гүйцэтгэлээр 3.2 их наяд төгрөгийн цэвэр ашигтай ажилласан байна.

- **Уул уурхайн бүтээгдэхүүний биржийн үйл ажиллагааг эхлүүлэв.** Уул уурхайн бүтээгдэхүүний тухай хууль 2022 оны 12 дугаар сарын 23-ны өдөр батлагдаж, 2023 оны 6 дугаар сарын 30-ны өдөр хэрэгжиж эхлэв. Ашигт малтмалыг нээлттэй борлуулах хүрээнд 2023 оны 1 дүгээр сарын 12-ны өдрөөс нүүрсний цахим арилжааг эхлүүлсэн бөгөөд 2023 онд цахим арилжаа болон уул уурхайн бүтээгдэхүүний биржээр нийт 14.9 сая тонн нүүрсийг анхны дуудах үнээс дунджаар 8.5 хувиар, 667 мянган тонн төмрийн баяжмал, хүдрийг анхны дуудах үнээс дунджаар 8.7 хувиар өсгөн нээлттэй борлуулсан байна. Цаашид уул уурхайн бүтээгдэхүүний биржээр арилжаалах бүтээгдэхүүний нэр төрлийг нэмэгдүүлж, жонш, зэс, молибденийн баяжмал, бүтээгдэхүүний арилжааг эхлүүлэхээр ажиллаж байна.

- **Гааль, татварын автомат бүрдүүлэлтийн систем ашиглалтад орж, уул уурхайн салбар ил тод болов.** Тогтоолын хүрээнд Гааль, татварын нэгдсэн удирдлага, хяналтын системийг ашиглалтад оруулж, ашигт малтмалыг олборлохоос борлуулах хүртэлх бүх гэрээг тус системд бүртгэж эхэлснээр уул уурхайн салбар ил тод боллоо. Бүх төрлийн

ашигт малтмалын экспортыг гааль, татварын бүрдүүлэлтийн системд бүрэн бүртгэлжүүлснээр татварын орлого нэмэгдэж, 50 сая тонн нүүрс тутамд 1 их наяд төгрөгийн АМНАТ илүү төвлөрдөг болов. 2023 оны эцсийн байдлаар уг системд нийт 551 аж ахуйн нэгжийн 6,679 ашигт малтмалын экспортын гэрээ хүчин төгөлдөр үргэлжилж байна. Мөн тус системд тээврийн гэрээний бүртгэлийг 2023 оны 06 дугаар сараас эхлүүлж, 538 аж ахуйн нэгжийн 1,324 тээврийн гэрээг бүртгээд байна.


- **Нууцад хамаарах гэрээнүүдийг ил болгов.** Ашигт малтмалын борлуулалт, хөрөнгө оруулалт, худалдан авалттай холбоотой ил тод байдлыг хангах хүрээнд Засгийн газрын 2022 оны 449 дүгээр тогтоолоор “Эрдэнэс Тавантолгой” ХК-тай холбоотой төрийн нууцад хамааруулсан гэрээнүүдийн мэдээллийг нууцаас гаргаж, ил тод болгохын зэрэгцээ компанийн борлуулалт, хөрс хуулалт, олборлолтын гэрээний мэдээллийг олон нийтэд нээлттэй болгоод байна.

- **“С” төрлийн зөвшөөрлийг олгох эрхийг олборлогч аж ахуйн нэгжүүдэд шилжүүлэв.** Тэвэрлэлт, экспортын үйл ажиллагааны зохион байгуулалтыг сайжруулах хүрээнд “Авто тээврийн үндэсний төв” ТӨҮГ-аас байнгын ачаа тээврийн хил нэвтрэх “С” төрлийн зөвшөөрлийг олгох эрхийг олборлогч аж ахуй нэгжүүдэд шилжүүлээд байна.

- **Экспортлогч компаниуд шинээр “уурхайн ам” нөхцөлөөр гэрээ байгуулахыг зогсоож “хилийн үнэ” нөхцөлөөр гэрээ байгуулах шийдвэр гаргав.** Үүний үр дүнд экспортын тээвэр зохион байгуулалтын үр ашиг, нүүрс тээврийн зохион байгуулалт сайжирч, тээврийн компаниудын үйл ажиллагааг дэмжсэнээр, төсөвт төлөх татварын хэмжээ нэмэгдэв. Мөн уурхайгаас хил хүртэлх гадаадын компаниар зөөлгөх тээврийн валютын гадагшлах зардлыг хэмнэж, гадаад валютын нөөц өсөхөд нөлөөлөв.

Үр дүнд нь 2023 онд нүүрсний экспорт 69 сая тоннд хүрч, өмнөх оноос 2 дахин нэмэгдсэнээр гадаад валютын улсын нөөц 2023 оны эцэст 4,921 сая ам.доллар буюу түүхэн дээд түвшинд хүрлээ. Гадаад валютын нөөц нэмэгдсэн нь төгрөгийн ханш тогтворжиж, 2022 онд 16.9 хувь хүрч нэмэгдээд байсан инфляцын түвшин 2023 оны эцэст 7.9 хувь болж, төв банкны зорилтот түвшинд хүрч буурахад нөлөөллөө.

Зураг 4.3. Гадаад валютын нөөц, инфляц, ханш



Цаашид Засгийн газрын зүгээс экспорт, гадаад валютын нөөцийг тогтвортой нэмэгдүүлэх хүрээнд хил дамнансан төмөр замын холболтын ажлыг эрчимжүүлэх, экспортын зохион байгуулалт, үр ашгийг сайжруулах, уул уурхайн бүтээгдэхүүний биржийн арилжааг өргөжүүлэхэд чиглэсэн цогц арга хэмжээг үргэлжлүүлэн авч хэрэгжүүлж байна.

ТӨЛБӨРИЙН
ТЭНЦЭЛ**60. Урсгал данс болон төсвийн тэнцэл 2007 оноос хойш анх удаа нэгэн зэрэг ашигтай гарч, гадаад валютын улсын нөөц түүхэн дээд түвшинд хүрлээ.**

Засгийн газраас гадаад валютын нөөцийг нэмэгдүүлэх хүрээнд 2022 оны сүүлийн улирлаас эхлэн авч хэрэгжүүлсэн цогц арга хэмжээнүүдийн үр дүнд 2023 онд нүүрсний экспортын биет хэмжээ түүхэн дээд түвшинд хүрч, 2022 оны эцэст 0.7 тэрбум ам.долларын алдагдалтай гарсан төлбөрийн тэнцэл 2023 оны эцэст 1.5 тэрбум ам.долларын ашигтай гарлаа. Төлбөрийн тэнцэл ашигтай гарснаар гадаад валютын улсын нөөц 2023 оны эцэст 4,921 сая ам.доллар болж, түүхэн дээд түвшинд хүрлээ. Энэ нь бараа, үйлчилгээний импортын 4.3 сарын хэрэгцээг хангах түвшин байна. Төв банк 2023 онд өмнөх оноос 1.0 тэрбум ам.доллараар бага буюу 3.9 тэрбум ам.долларыг зах зээлд нийлүүлсэн нь экспортын орлого өсөж, зах зээл дээрх ам.долларын хомсдол буурсныг харуулж байна. Гадаад валютын нөөц нэмэгдсэнээр 2022 оны эцэст 6 хувиар сулраад байсан төгрөгийн бодит ханш 2023 оны эцэст өмнөх оноос 15 хувиар чангарсан байна.

61. Урсгал данс 2007 оноос хойш анх удаа ашигтай гарлаа.

Барааны экспортын өсөлт импортын өсөлтөөс өндөр байснаар төлбөрийн тэнцлийн урсгал данс 2007 оноос хойш анх удаа ашигтай гарлаа. Үйлчилгээний дансны алдагдал өмнөх оноос нэмэгдсэн ч алдагдлын өсөлтийн дүн өмнөх оноос 2.7 дахин буурлаа. Үйлчилгээний худалдааны гол данснуудыг харвал, гадаадаас Монгол улсад ирэх жуулчдын тоо нэмэгдсэн ч Монгол Улсаас гадаадад зорчих жуулчлал мөн өссөнтэй холбоотойгоор аялал жуулчлалын үйлчилгээний орох, гарах урсгалын

зөрүү өмнөх оны түвшинд байв. Мөн уул уурхайн салбарыг дагасан тээврийн салбарын идэвхжил нэмэгдсэн ч ачаа тээврийн үйлчилгээний орох, гарах урсгалын зөрүү мөн өмнөх оны түвшинд байв. Харин техникийн, худалдааны болон бизнесийн үйлчилгээний импорт 2023 онд өмнөх оноос өссөн нь нийт үйлчилгээний дансны алдагдал нэмэгдэхэд нөлөөлөв.

62. Зээлийн орох урсгал нэмэгдсэн ч шууд хөрөнгө оруулалтын орох урсгал буурснаар санхүүгийн дансны ашиг өмнөх оноос буурлаа.

Хувийн хэвшлийн зээлийн ашиглалт нэмэгдсэн ч шууд хөрөнгө оруулалтын орох урсгал буурч, гадаад бондуудын эргэн төлөлт хийгдсэнтэй холбоотойгоор 2023 онд санхүүгийн дансны ашиг буурлаа. Тухайлбал, Засгийн газар болон хувийн хэвшлийн зээлийн ашиглалт төлөлтөөсөө давсан бол нийт шууд хөрөнгө оруулалт 2023 онд 3.1 тэрбум ам.долларт хүрч, өмнөх оноос 334 сая ам.доллараар буюу 10 хувиар буурсан байна. Үүнд уул уурхайн салбарын хөрөнгө оруулалт 376 сая ам.доллар буюу 13 хувиар буурсан нь голлон нөлөөллөө. Мөн уул уурхайгаас гадна барилга, тээвэр, үл хөдлөх, санхүү зэрэг дийлэнх салбарын хөрөнгө оруулалт буурсан бол худалдаа, мэргэжлийн, шинжлэх ухаан, техникийн үйл ажиллагаатай холбоотой хөрөнгө оруулалт өссөн дүнтэй байна. Улсын бүртгэлд бүртгэлтэй гадаадын хөрөнгө оруулалттай хязгаарлагдмал хариуцлагатай компанийн тоо 2023 онд 265 болж, өмнөх оноос 130-аар нэмэгдсэн ч гадаадын шууд хөрөнгө оруулалт буурсан үзүүлэлттэй байна.


¹⁴ Сүүлийн 1 жилийн бараа, үйлчилгээний импортын дунджаар тооцов.

63. Гадаад бондуудын төлбөрийг амжилттай төлж барагдуулаа. Цар тахал, геополитикийн тогтворгүй байдалтай нүүр тулсан сүүлийн 3 жилийн хугацаанд Монгол Улсын Засгийн газар өрийн зохицуулалтын арга хэмжээг амжилттай хэрэгжүүлснээр төсөв, төлбөрийн тэнцэлд ирэх өрийн дарамтыг бууруулж, өрийн дефолтын эрсдэлээс сэргийлж, зээлжих зэрэглэлийг тогтвортой хадгалж чадлаа. Тухайлбал, 2016 онд авсан “Кредит свисс” банкны 60 сая ам.долларын синдикат зээлийг 2021 оны 3 дугаар сард, 2016 онд гарсан “Мазаалай” бондын үлдэгдэл 133 сая ам.долларыг 2021 оны 4 дүгээр сард, 2012 онд гарсан “Чингис” бондын өрийн үлдэгдэл 137 сая ам.долларыг 2022 оны 12 дугаар сард тус тус төлж барагдуулсан. Харин 2023 оны 1 дүгээр сард Сенчири-2 төслийн хүрээнд 8.65 хувийн хүүтэй, 5 жилийн хугацаатай, 650 сая ам.долларын бонд, 2023 оны 11 дүгээр сард Сенчири-3 төслийн хүрээнд 7.875 хувийн хүүтэй, 5.5 жилийн хугацаатай, 350 сая ам.долларын бондыг олон улсын хөрөнгийн зах зээлд амжилттай арилжаалж, 2017 онд авсан 800 сая ам.долларын “Гэрэгэ” бондын өрийн үлдэгдэл болох 369 сая ам.долларыг бүрэн төлж барагдуулахын зэрэгцээ 2024 онд төлөгдөх хуваарьтай “Хуралдай” бонд, 2026 онд төлөгдөх хуваарьтай “Номад” бондын тодорхой хэсгийг дахин санхүүжүүлэх өрийн зохицуулалтын арга хэмжээг авч хэрэгжүүлээ. Сенчири-3 төслийн хүрээнд гаргасан бондын хувьд

Монгол Улсын Засгийн газрын эрсдэлийн түвшин түүхэндээ хамгийн бага буюу 2.3 хувь байв. Мөн 2023 онд Монгол Улсын Хөгжлийн Банкны чанаргүй зээлийн эргэн төлөлтүүдийг эрчимжүүлсний үр дүнд 2023 оны сүүлийн улиралд 2018 онд гаргасан 500 сая ам.долларын Евробонд, 2013 онд гаргасан 30 тэрбум иенийн Самурай бондын төлбөрүүдийг амжилттай төлж барагдуулаа.

64. Үндэсний нийт хадгаламж өсөж, хөрөнгө оруулалт буурлаа. Урсгал дансны алдагдал нь тухайн улс үндэсний нийт хадгаламжаасаа давсан хөрөнгө оруулалтыг хийж байгааг харуулна. ДНБ-д харьцуулсан эцсийн хэрэглээ өмнөх оноос буурсантай холбоотойгоор үндэсний нийт хадгаламж өсөхийн зэрэгцээ үндэсний нийт хөрөнгө оруулалт мөн буурснаар ДНБ-д харьцуулсан урсгал дансны тэнцэл 2023 оны эцэст өмнөх оноос 14.2 нэгж хувиар сайжирч 0.7 хувийн ашигтай гарлаа. Уул уурхайн салбарын өсөлттэй холбоотой төсвийн орлогын өсөлтийн нөлөөгөөр Засгийн газрын орлого нэмэгдсэнээр Засгийн газрын хадгаламж өсөж, Засгийн газрын хадгаламж, хөрөнгийн оруулалтын зөрүү өмнөх оноос нэмэгдлээ. Харин хөрөнгө оруулалтын бууралттай холбоотойгоор хувийн секторын хадгаламж, хөрөнгийн оруулалтын сөрөг зөрүү өмнөх оноос агшсан байна.

Зураг 4.4. Төлбөрийн тэнцэл, урсгал дансны тэнцэл



65. Монгол Улсын нийт гадаад өрийн үлдэгдэл 34.6 тэрбум ам.долларт хүрэв.

Монгол Улсын гадаад өрийн үлдэгдэл 2023 оны эцэст өмнөх оны мөн үеэс 1.3 тэрбум ам.доллараар буюу 3.7 хувиар нэмэгдэж, 34.6 тэрбум ам.долларт хүрсэн бол ДНБ-ий өсөлттэй холбоотойгоор ДНБ-д харьцуулсан гадаад өрийн хэмжээ 174 хувь болж, өмнөх оноос 20 нэгж хувиар буурлаа. Хугацаагаар харвал, нийт гадаад өрийн 93 хувь нь урт хугацаат, 7 хувь нь богино хугацаат өр байна.

66. Засгийн газрын гадаад өрийн үлдэгдэл буурч, хувийн хэвшлийн гадаад өрийн үлдэгдэл нэмэгдлээ.

Гадаад бонд болон зээлийн эргэн төлөлттэй холбоотойгоор Засгийн газрын болон төв банкны гадаад өрийн үлдэгдэл 2023 онд өмнөх оноос 482 сая ам.доллараар буурсан бол шууд хөрөнгө оруулалттай компанийн компани хоорондын зээллэгийн үлдэгдэл 1.7 тэрбум ам.доллараар өслөө. Тухайлбал, Оюутолгойн хөрөнгө оруулалттай холбоотойгоор уул уурхайн салбарын гадаад өрийн үлдэгдэл 2.0 тэрбум ам.доллараар нэмэгдсэн бол санхүү болон даатгал, боловсруулах болон худалдааны салбарын гадаад өрийн үлдэгдэл өмнөх оноос буурлаа.


67. Нийт гадаад өрийн дийлэнх хувийг хувийн хэвшлийн өр бүрдүүлж байна.

Монгол Улсын нийт гадаад өрийн үлдэгдлийн 72 хувийг хувийн хэвшлийн өр, 23 хувийг Засгийн газрын өр, 5 хувийг төв банкны өр тус тус бүрдүүлж байна. Хувийн хэвшлийн нийт гадаад өрийн дийлэнх буюу 77 хувийг уул уурхайн салбар, 9 хувийг санхүүгийн салбар, 4 хувийг худалдааны салбарын өр, харин үлдсэн 10 хувийг бусад 18 салбарын өр бүрдүүлж байна.

68. Гадаад позиц сул байгаа нь манай улс гадаад шокоос үүдэлтэй хямралд өртөх эрсдэл өндөр байгааг харуулж байна.

Гадаад хөрөнгө оруулалтын цэвэр позиц нь гадаад улсад байршиж буй Монгол улсын эзэмшлийн санхүүгийн хөрөнгө болон Монгол улс бусад улсад төлөх үүрэг бүхий өр төлбөрийн зөрүүг харуулдаг. Манай улсын гадаад хөрөнгө оруулалтын цэвэр позиц 2023 оны эцсийн байдлаар -41.8 тэрбум ам.доллар буюу ДНБ-ий -210 хувьтай тэнцэж байна. Сөрөг позиц өмнөх оноос мөнгөн дүнгээр 186 ам.доллараар, ДНБ-д эзлэх хувиар 35 нэгж хувиар буурлаа. 2023 оны эцсийн байдлаар манай эдийн засгийн харьяат 8.7 тэрбум ам.долларын хөрөнгийг гадаад улсад байршуулсан бол манай улс 50.5 тэрбум ам.долларын санхүүгийн өр төлбөрийг бусад улсад төлөхөөр байна. Нийт гадаад активын дийлэнх буюу 56 хувийг (4.9 тэрбум ам.доллар) нөөц хөрөнгө, гадаад пассивын дийлэнх буюу 61 хувийг (30.6 тэрбум ам.доллар) шууд хөрөнгө оруулалт бүрдүүлж байна. Монгол улсад байршиж буй, гадаад улсын эзэмшлийн санхүүгийн хөрөнгийн дүн гадаад улсад байршиж буй Монгол улсын эзэмшлийн санхүүгийн хөрөнгөөс хэт өндөр байгаа нь манай улсын эдийн засаг гадаад шокоос үүдэлтэй хямралд өртөх эрсдэл өндөр байгааг харуулж байна. Иймд Засгийн газрын зүгээс төлбөрийн тэнцлийг сайжруулах, гадаад өрийн дарамтыг бууруулах замаар гадаад хөрөнгө оруулалтын позицыг сайжруулах чиглэлд үргэлжлүүлэн ажиллаж байна.

Зураг 4.5. Гадаад өр, гадаад хөрөнгө оруулалтын позиц



69. Гадаад өрийн динамик дунд хугацаанд харьцангуй тогтвортой байна.

Доорх хэсэгт ДНБ-д харьцуулсан гадаад өрийн хэмжээ ДНБ-ий өсөлт, гадаад хүү, төгрөгийн ханшийн шокуудад хэр мэдрэг байгааг энгийн шинжилгээгээр тооцоолсныг харуулав. Ингэхдээ тухайн шок тохиосон оноос бусад оны үзүүлэлтүүд суурь төсөөлөлтэй ижил байхаар тооцов. Суурь төсөөлөлд 2024-2027 он хүртэлх ДНБ-ий бодит өсөлтийг 7.0 хувь, инфляцыг төв банкны зорилтот түвшин, нэрлэсэн гадаад хүүг 4.5 хувь, ханшийн өөрчлөлт, ДНБ-д харьцуулсан урсгал дансны үндсэн тэнцэл болон өрийн бус бусад хөрөнгийн урсгалыг сүүлийн 10 жилийн дундажтай тэнцүү байхаар тус тус тооцов. Уг суурь төсөөлөөр урсгал дансны ашиг, бодит хүүгийн бууралтаас шалтгаалан гадаад өр болон ДНБ-ий харьцаа дунд хугацаанд аажмаар буурч, 2027 онд 168 орчим хувьд хүрэхээр байна.

ДНБ-ий өсөлтийн шок: Хэрэв бодит ДНБ-ий өсөлт 2025 онд суурь төсөөллөөс 3.8 нэгж хувиар буурах


тохиолдолд ДНБ-д харьцуулсан гадаад өрийн хэмжээ 2025 онд суурь төсөөллөөс 6 нэгж хувиар нэмэгдэж, 2027 онд 174 хувь болохоор байна.

Нэрлэсэн гадаад хүүгийн шок: Харин нэрлэсэн гадаад хүү 2025 онд суурь төсөөллөөс 2 нэгж хувиар нэмэгдэх тохиолдолд гадаад өр болон ДНБ-ий харьцаа 2027 онд суурь төсөөллөөс 3 нэгж хувиар их буюу 171 хувь болохоор байна.

Ханшийн шок: Хэрэв төгрөгийн ам.доллартой харьцах ханш 2025 онд суурь төсөөллөөс 5.4 нэгж хувиар илүү сулрах тохиолдолд гадаад өр болон ДНБ-ий харьцаа 2027 онд 177 хувь болж, суурь төсөөллөөс даруй 9 нэгж хувиар нэмэгдэхээр байна.

Гадаад өрийн тогтвортой байдлыг хангахад макро эдийн засгийн тогтвортой байдлыг хангах, Монгол Улсын зээлжих зэрэглэл буурах эрсдэлээс сэргийлэх, гадаад валютын нөөцийг нэмэгдүүлэх замаар төгрөгийн ханш сулрах дарамтыг бууруулах, гадаад өрийн удирдлагыг оновчтой хэрэгжүүлэх нь чухал байна.

Зураг 4.6. Гадаад өрийн хандлага



БҮЛЭГ V

ДЭЛХИЙН ЭДИЙН ЗАСАГ

- 5.1 ДЭЛХИЙН ЭДИЙН ЗАСГИЙН НӨХЦӨЛ БАЙДАЛ
- 5.2 ТҮҮХИЙ ЭДИЙН ЗАХ ЗЭЭЛИЙН ХАНДЛАГА

V. ДЭЛХИЙН ЭДИЙН ЗАСАГ

ТОЙМ

Дэлхийн эдийн засаг 2023 онд үнийн өсөлт, мөнгөний хатуу бодлого, геополитикийн тогтворгүй байдал, байгалийн гамшигт үзэгдэл зэрэг олон сорилтуудтай нүүр туллаа.

Үл хөдлөх салбарын хямрал үргэлжилж байгаа хэдий ч манай улсын худалдааны гол түнш болох БНХАУ-ын эдийн засгийн өсөлт тус улсын Засгийн газрын зорилтот түвшнээс давлаа.

Олон улсын тээвэр логистикийн саатал, эрчим хүчний хямрал, гадаад улсуудын өндөр инфляц зэрэг хүчин зүйлсээс шалтгаалан 2021 болон 2022 онуудад манай улсын голлох экспортын түүхий эдийн үнэ өсөлттэй байсан бол 2023 онд нийлүүлэлт тогтворжиж, дэлхийн эдийн засгийн идэвхжил удааширсантай холбоотойгоор эрэлт багассанаар ихэнх түүхий эдийн үнэ буурлаа.


ДЭЛХИЙН ЭДИЙН ЗАСГИЙН НӨХЦӨЛ БАЙДАЛ

70. БНХАУ-ын эдийн засгийн өсөлт Засгийн газрын зорилтот түвшнээс давав.

Манай улсын худалдааны гол түнш болох БНХАУ-ын эдийн засаг 2023 онд дотоод, гадаад эрэлтийн бууралт, үл хөдлөх салбарын хямрал зэрэг сорилтуудтай тулсан хэдий ч 5.2 хувиар өсөж, өсөлтийн түвшин тус улсын Засгийн газрын зорилтот 5 хувиас давлаа. Нийт эдийн засгийн өсөлтийн 82 хувийг хэрэглээ, 29 хувийг хөрөнгө оруулалт, харин -11 хувийг цэвэр экспорт бүрдүүллээ. Өнгөрсөн 2023 онд худалдааны эргэлт буурч, залуучуудын ажилгүйдлийн түвшин нэмэгдэж, инфляц буурсан бол аж үйлдвэрлэлийн салбар өсөж, хэрэглээ нэмэгдсэн нь нийт эдийн засгийн өсөлтийг голлон дэмжлээ. Тухайлбал, 2023 онд экспорт 2016 оноос хойш анх удаа, импорт цар тахлын үе буюу 2020 оноос хойш анх удаа тус тус буурсан бол аж үйлдвэрийн гарц 4.6 хувиар, жижиглэнгийн

худалдаа 7.2 хувиар тус тус өсөж, эдийн засгийн өсөлтийг дэмжлээ. Тус улсын БНХАУ-ын ДНБ-ий 20 орчим хувь, орон нутгийн төсвийн орлогын 30 орчим хувь, өрхийн хөрөнгийн 74 орчим хувийг тус тус бүрдүүлдэг үл хөдлөх хөрөнгийн салбарын хөрөнгө оруулалт 2023 онд өмнөх оноос 9.6 хувиар, борлуулалтын талбайн хэмжээ 8.5 хувиар тус тус буурлаа. БНХАУ 2023 онд эдийн засгийн өсөлтийг дэмжих зорилгоор төсвийн алдагдлыг нэмэгдүүлэх, бодлогын хүү, банкнуудын заавал байлгах нөөцийн хувь хэмжээг бууруулж, төсөв мөнгөний тэлэх бодлогыг хэрэгжүүлсэн бол үл хөдлөх хөрөнгийн салбарыг дэмжих хүрээнд компаниудын зээлийн төлбөрийг хойшлуулах, орон сууцны урьдчилгаа, ипотекийн зээлийн хүүг бууруулах, үл хөдлөх хөрөнгө хөгжүүлэгч компаниудын зээл, санхүүжилтийг дэмжих зэрэг арга хэмжээг авч хэрэгжүүллээ.

Зураг 5.1. БНХАУ-ын эдийн засгийн үзүүлэлтүүд



Олон улсын байгууллагууд БНХАУ-ын эдийн засгийг 2024 онд 4.5 орчим хувиар, 2025 онд 4.0 орчим хувиар өснө гэж төсөөлж байна. Харин ОУВС 2024 оны 1 дүгээр сард БНХАУ-ын эдийн засгийн өсөлт 2024 онд 4.6 хувь, 2025 онд 4.1 хувь байх төсөөллийг


зарлаад байна. Олон улсын шинжээчдийн үзэж байгаагаар ойрын хугацаанд БНХАУ-ын Засгийн газар эдийн засгийн идэвхжилийг дэмжих хүрээнд төсвийн алдагдлыг өндөр хэвээр хадгалах, хувийн хэрэглээ эдийн засгийн өсөлтийн гол тулгуур хэвээр байх,

үл хөдлөх хөрөнгийн салбарт чиглэсэн бодлогын дэмжлэг үргэлжлэх, богино хугацаат давамгайлсан хөрөнгийн дотогшлох урсгал нэмэгдэх ч гадаадын хөрөнгө оруулагчид урт хугацаат хөрөнгө оруулалт хийх болгоомжлол өндөр хэвээр байх, хөдөлмөрийн зах зээлийн эрэлт нийлүүлэлтийн зөрүүнээс үүдэлтэй залуучуудын ажилгүйдлийн түвшин өндөр хэвээр байх төлөвтэй байна. Мөн технологи, уур амьсгалын өөрчлөлт, геополитикийн асуудлуудыг тойрсон дэлхий дахин болон БНХАУ доторх өрнөлүүд тус улсын улс төр, эдийн засгийн төлөвт нөлөөлөхөөр байна. БНХАУ-ын хойд хэсгийн эдийн засгийн өсөлт өндөр буюу Өвөр Монголын эдийн засаг 2023 онд 7.3 хувиар, Гансү муж 6.4 хувиар, Хэбэй муж 5.5 хувиар, Нинша муж 6.6 хувиар тус тус өссөн нь манай улсын гадаад эрэлтийн төлөвт эергээр нөлөөлж байна.

71. ОХУ-ын эдийн засаг дэлхийн дундаж түвшнээс өндөр өсөлттэй байв. ОХУ, Украины хооронд үүсээд байгаа геополитикийн тогтворгүй

нөхцөл байдлаас шалтгаалан дэлхийн улс орнууд ОХУ-ын эсрэг үе шаттайгаар эдийн засгийн хориг арга хэмжээ авч хэрэгжүүлсэн хэдий ч тус улсын эдийн засаг 2023 онд 3.6 хувиар өслөө. Эдийн засгийн өсөлтөд цэрэг армийн зардалтай холбоотой төсвийн зардлын тэлэлт, түүхий эдийн өндөр үнэ гол нөлөө үзүүлээ. Засгийн газрын хэрэглээ 2023 онд 6.9 хувиар өссөн бол экспорт өмнөх оноос 28.4 хувиар буурч, импорт 10.1 хувиар өссөн байна. Экспортын бууралт, импортын өсөлтийн нөлөөгөөр 2023 онд рублийн ам.доллартой харьцах ханш 30 орчим хувиар суларлаа. ОХУ-ын Төв банк бодлогын хүүг 2023 оны 1 дүгээр сарын түвшин 7.5 хувиас 2023 оны 12 дугаар сард 16 хувь болгож нэмэгдүүлсэн байна. Инфляцын түвшин 2023 оны 12 дугаар сард 7.4 хувь болж өмнөх оны мөн үеэс 4.5 нэгж хувиар буурсан боловч төв банкны зорилтот түвшин 4 хувиас өндөр хэвээр байна. Аж үйлдвэрийн салбарын бодит өсөлт 2023 оны 12 дугаар сард өмнөх оны мөн үеэс 4.5 хувиар өссөн байна.

Зураг 5.2. ОХУ-ын эдийн засгийн үзүүлэлтүүд



Үйлдвэрлэлийн өсөлт ажлын байр бий болгоход түлхэц өгч, 2023 оны 12 дугаар сард ажилгүйдлийн түвшин 3.0 хувь болж, өмнөх оны мөн үеэс буурсан ба ажил эрхлэлт мөн нэмэгдлээ. Европын холбоо болон Их долоо (G7)-ын орнууд 2022 оны 12 дугаар сарын 5-ны өдөр ОХУ-аас далайгаар дамждаг түүхий газрын тосны экспортыг хориглож, газрын тос, бүтээгдэхүүний үнийн дээд хязгаарыг баррель нь 60 ам.доллар байхаар тогтоосон. Хориг арга хэмжээний улмаас ОХУ үнийн дээд хязгаар тогтоосон орнууд руу газрын тос тээвэрлэхээ зогсоож, Азийн зах зээл тэр дундаа үнийн дээд хязгаарт нэгдээгүй БНХАУ болон БНЭУ руу хөнгөлөлттэй үнээр газрын тос экспортолсон. 2023 онд Европын Холбооны орнуудад хийсэн тус

улсын экспортын хэмжээ өмнөх оноос 45 хувиар буурсан байна. ОХУ 2023 оны 9 дүгээр сард нефтийн бүтээгдэхүүний экспортод тавьсан хязгаарлалтыг 4 дүгээр улиралд аажмаар сулруулж, 10 дугаар сард далайн боомтуудад дамжуулах хоолойгоор хүргэсэн дизель түлшний экспортод тавьсан хориг, 11 дүгээр сард шатахууны, дизель түлшний экспортод тавьсан хоригийг тус тус цуцалсан. Гэхдээ Украины дайралттай холбоотой газрын тос шилжүүлэн ачих, тээвэрлэх үйл ажиллагаа түр зогссон, Хар тэнгис дэх далайн шуурганы улмаас ОХУ-ын боомтуудын тээврийн хөдөлгөөн хязгаарлагдмал байгаа нь экспортод сөргөөр нөлөөлсөн хэвээр байна.

ШИГТГЭЭ 5.1. ОХУ-ЫН ЭСРЭГ АВЧ ХЭРЭГЖҮҮЛСЭН ЭДИЙН ЗАСГИЙН ХОРИГ АРГА ХЭМЖЭЭ

Европын холбооноос эдийн засгийн 13 удаагийн багц хориг арга хэмжээг ОХУ-ын эсрэг авч хэрэгжүүлсэн. Сүүлийн 2 жилийн хугацаанд Европын Холбооноос батлан хэрэгжүүлсэн хориг арга хэмжээнд нийт 1,718 хувь хүн, 419 аж ахуйн нэгж хамрагдаад байна. Хамгийн сүүлийн 13 дахь багц хориг арга хэмжээг 2024 оны 2 дугаар сарын 23-ны өдөр Европын холбооны 269/2014 тоот журмаар 194 хувь хүн, аж ахуйн нэгжийг хоригийн жагсаалтад нэмж оруулсан байна. Тус хоригийн гол зорилго нь өмнөх багц хориг арга хэмжээнүүдтэй адил нэмж бүртгэгдсэн хувь хүн, аж ахуйн нэгжийн Европын Холбооны орнуудад байрших хөрөнгийг царцаах, битүүмжлэх мөн хөрөнгө оруулалтын сан болон бусад санхүүгийн эх үүсвэрээр санхүүжих боломжийг хязгаарлах юм. Энэхүү жагсаалт нь ОХУ-ын пуужин, нисгэгчгүй онгоц, нисгэгчгүй онгоцны эд анги, зенитийн пуужингийн систем, цэргийн машин, зэвсэг болон бусад цэргийн техник хэрэгслийн өндөр технологийн бүрэлдэхүүн хэсэг үйлдвэрлэдэг цэргийн аж үйлдвэрийн компани, холбоо бүхий хувь хүмүүс рүү чиглэсэн байна. Мөн хоригийн жагсаалтад Беларусь, Хойд Солонгосын холбогдох аж ахуй нэгжүүд Хойд Солонгосын зэвсгийг ОХУ руу тээвэрлэхэд оролцсон гэх үндэслэлээр хамрагдсан байна. Түүнчлэн хориг арга хэмжээний багцад БНХАУ, Казахстан, Энэтхэг, Серби, Тайланд, Шри Ланка, Турк зэрэг улсуудын компаниудыг нэмж оруулсан байна.

Европын холбооны мэдээлснээр, 2022 оны 2 дугаар сараас хойш Европын Холбоо ОХУ руу экспортлох байсан 43.9 тэрбум евро, ОХУ-аас импортлох 91.2 тэрбум еврогийн барааг хориглосон байна. Европын Холбоо ОХУ-ын санхүү, худалдаа, эрчим хүч, зам тээвэр, технологи, батлан хамгаалахын салбарт чиглэсэн эдийн засгийн хориг арга хэмжээг 2024 оны 7 дугаар сарын 31-ний өдрийг хүртэл сунгасан байна.

Үүнд:

Санхүүгийн салбар

- ОХУ-ын нийт 10 банкны үйл ажиллагаанд SWIFT хориг тавьсан
- ЕХ-ны хөрөнгө, санхүүгийн зах зээлд нэвтрэх эрхийг хязгаарласан
- ОХУ-ын Төв банктай хийх гүйлгээг хориглосон
- ОХУ-д Еврогийн мөнгөн дэвсгэрт нийлүүлэхийг хориглосон
- ОХУ-ын иргэдэд Крипто валютаар гүйлгээ хийх, хөрөнгө оруулахыг хориглосон

Эрчим хүчний салбар

- ОХУ-аас газрын тос, нүүрс импортлохыг хориглосон
- ОХУ-ын газрын тосны далайн тээвэртэй холбоотой үнийн дээд хязгаар тогтоосон
- Газрын тос боловсруулах үйлдвэрт технологийн бүтээгдэхүүн экспортлохыг хориглосон

- ОХУ-ын эрчим хүч, уул уурхайн салбарт шинэ хөрөнгө оруулалт хийхийг хориглосон

Тээврийн салбар

- ЕХ-ны агаарын орон зайг ОХУ-ын эзэмшлийн бүх нисэх онгоцонд хаасан
- ОХУ-ын авто тээврийн операторуудыг хориглосон
- ОХУ-д бүртгэлтэй чиргүүл, хагас чиргүүлийг хориглосон
- ЕХ-ны боомтуудаар ОХУ-ын хөлөг онгоц нэвтрэхийг хориглосон
- ОХУ-ын газрын тосыг гуравдагч орнууд руу далайгаар тээвэрлэхийг хориглосон
- ОХУ-д нисэх, далайн болон сансрын салбарын технологийн бүтээгдэхүүн экспортлохыг хориглосон

Батлан хамгаалахын салбар

- ОХУ-д экспортлохыг хориглосон
- Цэргийн зориулалттай давхар хэрэглээний бараа, технологи
- Хагас дамжуулагч материал
- Электрон болон оптик бүрэлдэхүүн хэсгүүд
- Навигацийн хэрэгслүүд
- Нисгэгчгүй онгоцны хөдөлгүүр, мотор эд анги
- Зэвсэг, иргэний галт зэвсэг, тэдгээрийн эд анги
- Сум, цэргийн машин, хагас цэрэгжсэн тоног төхөөрөмж
- ОХУ-ын аж үйлдвэрийн хүчин чадлыг нэмэгдүүлэх бусад бараа

Худалдаа, үйлчилгээний салбар

- ОХУ руу тансаг зэрэглэлийн бараа экспортлохыг хориглосон
- ОХУ-аас импортлохыг хориглосон
- Алмаз (зүссэн, өнгөлсөн), алмазын үнэт эдлэл
- Алт, алтан үнэт эдлэл
- Ган, төмөр, ширэм, ган төмөр
- Цемент, асфальт
- Зэс, хөнгөн цагаан утас, тугалган цаас
- Мод, цаас, синтетик резин, хуванцар
- Далайн хоол, спирт, тамхи, гоо сайхны бүтээгдэхүүн
- ОХУ-ын хувь хүн, аж ахуй нэгжид дараах үйлчилгээг хориглосон
- Мэдээллийн технологийн зөвлөх үйлчилгээ, хуулийн зөвлөх үйлчилгээ
- Зар сурталчилгаа, зах зээлийн судалгаа, олон нийтийн санал асуулгын үйлчилгээ
- Техникийн туслалцаа зуучлалын үйлчилгээ
- Оюуны өмчийн эрх эсвэл худалдааны нууц (хориг арга хэмжээнд хамаарах бараа, технологитой холбоотой)
- Архитектур, инженерийн үйлчилгээ

Эх сурвалж: Блүүмберг, Европын Холбооны зөвлөл

72. Евро бүсийн эдийн засгийн өсөлт хүлээлтээс доогуур байв. Эрчим хүчний үнийн шокоос үүдэлтэй инфляц 2023 онд аажмаар саарч оны эцэст 2.9 хувьд болсон ч хэрэглээ хангалттай түвшинд хүрч сэргээгүй, инфляцыг хязгаарлахаар төв банкнудаас барьж буй мөнгөний хатуу бодлогын нөлөөгөөр бүс нутаг дах хөрөнгө оруулалт, санхүүгийн зах зээлийн үйл ажиллагаа суларч улмаар эдийн засгийн өсөлт 2023 онд хүлээлтээс доогуур буюу 0.4 хувь байлаа. Бүс нутгийн томоохон эдийн засгуудын нэг ХБНГУ-ын эдийн засаг 2023 онд 0.3 хувиар агшсан байна. Эрчим хүчний үнийн шокийн нөлөө аажмаар саарч, инфляцын бууралт өрхийн хэрэглээг дэмжсэнээр тус бүсийн эдийн засаг 2024 онд 0.9 хувь, 2025 онд 1.7 хувиар өсөн алгуур сэргэх төлөвтэй гэж ОУВС үзэж байна.

73. АНУ-ын эдийн засгийн өсөлт эрчимжив. Өрхийн хэрэглээ эрчимжиж, Засгийн газрын хэрэглээ, экспорт нэмэгдсэнээр 2022 онд 1.9 хувиар өссөн АНУ-ын эдийн засаг 2023 онд 2.5 хувиар өслөө. АНУ-ын төв банк 2023 оны 7 дугаар сараас хойш бодлогын хүүг 5.25-5.5 хувьд хадгалж байгаа бол инфляц 2023 оны эцэст 3.4 хувь болж буурсан байна. Цаашид инфляцын бууралтын эрчим, хөдөлмөрийн зах зээлийн төлөв бодлогын хүүг бууруулах хугацааг тодорхойлохоор байна. Мөнгөний хатуу бодлогын

нөлөө, эрэлтийн бууралтын нөлөөгөөр тус улсын эдийн засгийн өсөлт 2024 онд 2.1 хувь, 2025 онд 1.7 хувь болж саарах төлөвтэй байна.

74. Дэлхийн эдийн засгийн өсөлт 3 орчим хувьд тогтвортой байх төлөвтэй байгаа ч тодорхой бус байдал өндөр хэвээр байна. Цар тахлын дараах хүндрэл бүрэн арилаагүй үед үнийн өсөлт, түүнээс шалтгаалсан мөнгөний хатуу бодлого, геополитикийн тогтворгүй байдал, байгалийн гамшигт үзэгдэл зэрэг сорилтуудтай нүүр тулсан дэлхийн эдийн засаг 2023 онд 3.1 хувиар өссөн бол ирэх жилүүдэд өсөлт тогтворжиж, 2024 онд 3.1 хувь, 2025 онд 3.2 хувь байна гэж ОУВС төсөөлж байна. Блүүмбергийн төсөөллийг бүрдүүлэгч хувийн байгууллагууд дэлхийн эдийн засгийн өсөлтийг 2024 онд 2.8 хувь, 2025 онд 2.9 хувь, 2026 онд 3.1 хувь байна гэж таамаглаж байна. Гэсэн хэдий ч геополитикийн тогтворгүй нөхцөл байдал болон байгалийн гамшигт үзэгдлээс үүдэлтэй үнийн өсөлт даамжрах, инфляц төсөөллөөс удаан хугацаанд өндөр түвшинд хадгалагдах, БНХАУ-ын эдийн засгийн идэвхжил удаашрах, мөнгөний бодлогын төлөв болон өрийн хуримтлалаас шалтгаалан санхүүгийн зах зээлд тогтворгүй байдал үүсэх зэрэг эрсдэлүүд дэлхийн эдийн засгийн өсөлтийн төлөвийг муутгаж болзошгүй байна.

Хүснэгт 5.1. Дэлхийн эдийн засгийн өсөлтийн төсөөлөл

	ОУВС		Дэлхийн банк		АХБ		ОЕСД	
	2024.01 сар		2024.01 сар		2023.12 сар		2024.02 сар	
Дэлхий	3.1%	3.2%	2.4%	2.7%	-	-	2.9%	3.0%
БНХАУ	4.6%	4.1%	4.5%	4.3%	5.2%	4.5%	4.7%	4.2%

ТҮҮХИЙ ЭДИЙН ЗАХ ЗЭЭЛИЙН ХАНДЛАГА

75. Ихэнх түүхий эдийн үнэ 2023 онд буурлаа.

Ковид-19 цар тахал, олон улсын тээвэр логистикийн саатал, БНХАУ-ын эрчим хүчний хямрал, гадаад улсуудын өндөр инфляц, томоохон уурхайнуудын осол, ажил хаялт зэргээс шалтгаалан 2021 болон 2022 онуудад голлох түүхий эдийн үнэ өндөр өсөлттэй байв. Харин 2023 онд төв банкнууд инфляцын эсрэг мөнгөний бодлогоо чангаруулсан, БНХАУ-ын эдийн засгийн өсөлт саарсан, олон улсын геополитикийн асуудал хурцадсан жил байсантай холбоотойгоор түүхий эдийн эрэлт тогтворгүй байснаас гадна, Чили, Перу дэх зэсийн уурхайнууд, Австрали дахь нүүрсний уурхайн үйл ажиллагаа хэвийн болж, нийлүүлэлт нэмэгдсэнээр 2022 онд 16 хувь хүртэл өсөөд байсан Блүүмбергийн түүхий эдийн индекс 2023 онд 8 хувиар буурлаа.

76. 2024 онд дэлхийн эдийн засгийн өсөлтийн удаашрал, геополитикийн тогтворгүй байдлаас шалтгаалан үнэ буурах эрсдэлтэй байна.

Олон улсын шинжээчид 2024 онд дэлхийн эдийн засгийн өсөлт 2023 оны түвшинд хадгалагдахаас гадна БНХАУ-ын эдийн засгийн өсөлт 4.5-4.6 хувь буюу 2020 оныг эс тооцвол 1990 оноос хойших хамгийн бага түвшинд байхаар таамаглаж байна. Энэ нь түүхий эдийн эрэлт тогтворгүй байх, үнэ буурах хүлээлтийг бий болгож байна.

77. Лондоны металлын бирж дэх цэвэр зэсийн үнэ 2023 онд дунджаар 8,479 ам.доллар болж, өмнөх оны эцсээс 4 хувиар буурсан байна.

2022 онд Чили, Перу дэх уурхайнууд усны нөөц болон ажил хаялтаас шалтгаалан олборлолт нь удааширч зэсийн үнэ өссөн. 2023 он гарснаар Чили, Перу дэх уурхайнуудын олборлолт тогтворжиж, Лондоны металлын биржийн агуулах дэх зэсийн хэмжээ нэмэгдсэн нь үнэ буурахад голлон нөлөөллөө. 2024 оны зэсийн үнийн төсөөллийг өмнөх төсөөллөөс бууруулан тооцоонд авсан хэдий ч 2023 оны түвшнээс өсөхөөр хүлээж байна. Дэлхийн томоохон зэсийн ил

уурхайнуудын нэг болох “Кобре Панам” хаагдсан нь нийлүүлэлтийн тогтворгүй байдлыг богино хугацаанд нэмэгдүүлж байна. Эрэлт талаас дэлхийн зэсийн хэрэглээний талаас илүү хувийг бүрдүүлдэг БНХАУ-ын эдийн засгийн тогтворгүй байдал сөрөг нөлөө үзүүлж болзошгүй.

78. Зүүн хойд БНХАУ дахь 62 хувийн агууламжтай төмрийн баяжмалын 2023 оны дундаж үнэ 120 ам.доллар болж, өмнөх оны эцсээс 1 хувиар өссөн байна.

БНХАУ-ын үл хөдлөх хөрөнгийн салбар сул хэвээр байгаа хэдий ч дэд бүтцийн бүтээн байгуулалтууд ихээр хийгдэж аж үйлдвэрийн гарц 4.6 хувиар өссөн нь ган хайлуулах үйлдвэрийн гол түүхий эд болох төмрийн хүдэр, коксжих нүүрсний эрэлтийг нэмэгдүүлж үнийн өсөлтийн гол шалтгаан боллоо. 2024 оны төмрийн хүдрийн төсөөллийг өмнөх төсөөллөөс нэмэгдүүлэн тооцоонд авсан хэдий ч 2023 оны түвшнээс буухаар хүлээж байна. Африк, Австрали зэрэг улсууд шинэ уурхайн бүтээн байгуулалтын төслүүдийг эрчимжүүлж, Бразил улс нийлүүлэлтээ жил болгон 6 хувиар нэмэгдүүлэхээ зарлаад байна. Эрэлт талаас БНХАУ-ын эдийн засгийн өсөлт удаашралтай байгаагаас шалтгаалан тогтворгүй байхаар байна.

79. Сингапурын бирж дэх Австралийн сайн чанарын коксжих нүүрсний үнэ 2023 онд дунджаар 296 ам.долларт хүрч, өмнөх оны эцсээс 23 хувиар буурсан байна.

Байгалийн гамшгаас шалтгаалан саатаад байсан Австралийн коксжих нүүрсний олборлолт хэвийн болж нийлүүлэлт тогтворжсон нь үнэ буурахад голлон нөлөөллөө. 2024 оны коксжих нүүрсний үнийг өмнөх төсөөллийн орчим байхаар тооцоонд авлаа. Уурхайн хяналт шалгалтын улмаас БНХАУ-ын дотоод үйлдвэрлэл нэмэгдэх төлөвгүй байгаа нь коксжих нүүрсний үнэд эерэг нөлөө үзүүлж болзошгүй. Гэвч Европын холбооноос хэрэгжүүлж буй хориг арга хэмжээнээс шалтгаалан ОХУ-аас БНХАУ-д хямд үнэтэй нүүрс

нийлүүлэх, БНХАУ коксжих нүүрсний импортын тарифыг сэргээснээр эрэлт буурах зэрэг хүчин зүйлс сөрөг нөлөө үзүүлэх эрсдэлтэй байна.

80. Brent төрлийн газрын тосны үнэ 2023 онд 79 ам.долларт хүрч өмнөх оны эцсээс 25 хувиар буурлаа. 2024 оны газрын тосны үнийн төсөөллийг өмнөх төсөөллөөс орчимд байхаар тооцоонд авсан ба 2023 оны түвшнээс өсөхөөр хүлээж байна. ОПЕК-

ийн орнууд өнгөрсөн оны 6 дугаар сард 2024 онд олборлох газрын тосны хэмжээг бууруулах шийдвэр зарласнаас гадна нефьт, газрын тосны 35 орчим хувийг бүрдүүлдэг. Ойрх дорнод дахь мөргөлдөөн нь газрын тосны нийлүүлэлтийн тогтворгүй байдлыг бий болгож байна. Түүнчлэн, алт болон газрын тосны томоохон хэрэглэгч Энэтхэг улсын эдийн засгийн идэвхжил газрын тосны эрэлтийг нэмэгдүүлэх төлөвтэй байна.

Зураг 5.3. Түүхий эдийн үнэ



ЭРСДЭЛ

НЭГ. ТҮҮХИЙ ЭДИЙН ЭРЭЛТ, ҮНЭ:

БНХАУ-ын ган, төмөр үйлдвэрлэлийн орц түүхий эдийн хэрэглээ нь Монгол Улсын экспортын эрэлтийг тодорхойлж байна. Түүхий эдийн дэлхийн зах зээлд өндөр нөлөө бүхий БНХАУ-ын үл хөдлөх хөрөнгийн салбарын уналт үргэлжилж байгаа бөгөөд олон улсын байгууллагууд тус улсын эдийн засгийн өсөлт 2024 онд өмнөх оноос саарна гэж төсөөлж байна. БНХАУ-ын эдийн засгийн өсөлт хүлээлтээс доогуур байх нь манай улсын экспортын түүхий эдийн эрэлт, үнийг бууруулах замаар экспортын орлогод сөргөөр нөлөөлж болзошгүй байна.

ХОЁР. ИНФЛЯЦ: Дэлхийн нефть, газрын тосны экспортын 35 орчим хувийг бүрдүүлдэг Газын зурвас, Израйл орчмын бүс нутгийн мөргөлдөөн хурцдах, дэлхийн худалдааны 11 орчим хувь дамжин өнгөрдөг Улаан тэнгист халдлага үргэлжлэх, ОХУ-Украины мөргөлдөөн даамжрах зэрэг хүчин зүйлс чингэлэг тээврийн зардлыг нэмэгдүүлж, авто бензин, улаан буудай, хүнс, эрчим хүч зэрэг манай улсын импортын голлох бараа бүтээгдэхүүний үнийг өсгөх эрсдэлтэй байна. Мөн дэлхийн дулаарал, уур амьсгалын өөрчлөлт хүнсний ургацад сөргөөр нөлөөлж, дэлхийн хүнсний үнийн өсөлт манай улсын инфляцыг өсгөх эрсдэлтэй байна. Түүнчлэн, 2024 оны 2 дугаар улирлаас цалин, тэтгэвэр нэмэгдэх, “Эрдэнэс Тавантолгой” ХК ногдол ашиг тараахтай холбоотойгоор эрэлтээс өдөөгдсөн инфляц нэмэгдэж болзошгүй байна. Мөн зудаас шалтгаалан малын зүй бус хорогдол өндөр байгаа нь нийлүүлэлтийн шалтгаантайгаар махны үнэ нэмэгдэх, хүнсний инфляц өсөх дарамтыг нэмэгдүүлж байна.

ГУРАВ. ЗУД, ГАН, МАЛ, АМЬТНЫ ӨВЧИН:

Хөдөө аж ахуйн салбарын үйлдвэрлэл нь цаг агаарын таагүй байдал, ган, зудын нөхцөл байдлаас өндөр хамааралтай. Өвөлжилт, хаваржилтын нөхцөл байдал хүндэрч 2023 онд том малын зүй бүс хорогдол 2010 оноос хойш хамгийн өндөр түвшинд хүрч нэмэгдсэн бөгөөд 2024 оны эхнээс ихэнх нутгаар цас их хэмжээгээр орж, жил дараалсан зуд тохиолдож 2024 оны 2 дугаар сарын 29-ний өдрийн байдлаар 3 сая толгой мал хорогдоод байна. Цаашид зудын эрсдэл нэмэгдэж, хаваржилт хүндрэх, зуншлага тааруу байх, ган тохиолдох, малын халдварт өвчин тархах эрсдэлтэй байна. Улмаар өрхүүдийн орлого буурах, инфляц өсөх, орлогын тэгш бус байдал нэмэгдэх, хөдөөгөөс хот руу шилжиж ирэх хөдөлгөөн нэмэгдэх, төвлөрөл нэмэгдэх, хөдөө аж ахуйн салбар төсөөллөөс илүү агших эрсдэлтэй байна.

ДӨРӨВ. ЭРЧИМ ХҮЧНИЙ ТАСРАЛТГҮЙ, НАЙДВАРТАЙ БАЙДАЛ:

Эрчим хүч нь эдийн засаг, нийгмийн тогтвортой байдлыг хангах суурь хүчин зүйл боловч манай улс дотоодын цахилгаан хүчний хэрэглээний 20 орчим хувийг хөрш орнуудаас худалдан авч хэрэглэж байна. 2023 оны 12 дугаар сард ОХУ-ын 2 станцад гэмтэл гарснаар Монгол Улс руу нийлүүлэх эрчим хүчийг хязгаарлах тухай мэдэгдэж байсан ба энэ нь манай улсад эрчим хүчний тасалдал үүсэх эрсдэл өндөр байгаа харуулж байна. Мөн манай улсын эрчим хүчний хангамж нь төвлөрсөн системтэй ба станцуудын насжилт өндөр, түгээлтийн шугам, тоног төхөөрөмжийн дийлэнх нь хуучирч, элэгдсэн эрсдэлтэй нөхцөлд ажиллаж байна (шигтгээ 1-ийг харна уу).

ХАВСРАЛТ

- НЭМЭЛТ ШИГТГЭЭ
- ЭДИЙН ЗАСГИЙН ҮЗҮҮЛЭЛТҮҮД

ШИГТГЭЭ 1. ЭРЧИМ ХҮЧ

НӨХЦӨЛ БАЙДАЛ

Монгол Улс 2022 онд өмнөх оноос 3.3 хувиар их буюу 8.2 тэрбум кВт.ц цахилгаан эрчим хүч үйлдвэрлэсэн ч дотоодын хэрэглээний 20 хувийг буюу 2.1 тэрбум кВт.ц цахилгаан эрчим хүчийг импортолсон. Цахилгаан эрчим хүчний хэрэглээ сүүлийн жилүүдэд дунджаар 7-8 хувиар өсөж, цаашид 5-6 хувиар өсөх төлөвтэй байгаа нь дотоодын цахилгаан эрчим хүч үйлдвэрлэлийн ачааллыг нэмэгдүүлэхийн зэрэгцээ эрчим хүчний импортыг өсгөхөөр байна. Мөн 2022 онд 15.6 сая Гкал дулаан үйлдвэрлэж дотоодын хэрэглээг бүрэн хангаж байгаа ч оргил ачааллын үеийн хэрэглээ суурилагдсан хүчин чадлаасаа давж, нийлүүлэлт тасалдах эрсдэл өндөр байна. 2023 онд оргил ачааллын үед цахилгаан эрчим хүчний станцууд суурилагдсан хүчин чадлаас 20 хувиар, дулааны эрчим хүчний станцууд 67 хувиар давуулан ажиллаж байгаа ба хүчин чадлаас давуулан ашиглалт жилээс жилд нэмэгдсээр байна.


Эрчим хүчний хангамж нь төвлөрсөн системтэй ба дулааны цахилгаан станцуудын насжилт 35-60 жил, цахилгаан түгээх сүлжээний насжилт 32-62 жил бөгөөд дулааны шугам сүлжээний дамжуулах хоолой, дэд станцын 30 хувь нь гучаас дээш жилийн насжилттай, тоног төхөөрөмжийн ашиглалтын хугацаа дууссан байдалтай байгаа нь өссөн нэмэгдэж буй цахилгаан, дулааны эрчим хүчний хэрэглээг хангаж чадахааргүй байна. Эрчим хүчний нийт үйлдвэрлэлд алдагдал өндөр буюу дулааны эрчим хүчний 18-19 хувийг, цахилгаан эрчим хүчний 13-15 хувийг түгээлт, дамжуулалт болон барилга байгууламжийн дулааны алдагдлаас шалтгаалан алдаж байна.

Мөн цахилгаан эрчим хүчний тариф үйлдвэрлэсэн нэгжийн өртгөөс 11.5 хувиар доогуур байгаа ба салбарын үйл ажиллагаа үргэлж алдагдалтай ажилласаар ирсэн бөгөөд төрөөс татаас өгөх замаар алдагдлыг нөхөж байна. Хэрэглээтэй уялдаагүй үнэ, тарифын системээс шалтгаалан хэрэглэгчид хэрэглээгээ хэмнэх, зөвөөр удирдах хөшүүрэггүй байна.

ХЭРЭГЖҮҮЛСЭН АРГА ХЭМЖЭЭ

Эрчим хүч нь бодит салбарын үйл ажиллагаанд голлох хүчин зүйл тул нийлүүлэлтийн тасралтгүй байдлыг хангаж, алдагдлын хэмжээг бууруулж, төрийн оролцоог багасгаж, бие даасан салбар болгох нь нэн тэргүүний асуудал болоод байна. Энэ хүрээнд 2023 онд эрчим хүчний либерлалчлын ажлыг эхлүүлж, тарифыг үе шаттайгаар нэмэгдүүлж, цахилгаан дулааны станцуудыг өргөтгөлийн ажлыг эхлүүлж, 80МВт хүчин чадалтай хуримтлуурын байгууламжийг суурилуулж, ачаалал бага үеийн эрчим хүчийг хуримтлуулан оргил ачааллын төв шугамд нийлүүлж тасалдал үүсэх эрсдэлийг буурууллаа.

Зураг 1. Эрчим хүчний үйлдвэрлэл, оргил ачааллын үеийн хэрэглээ



ШИГТГЭЭ 2. ХӨДӨӨ АЖ АХУЙН САЛБАРТ БАРИМТЛАХ БОДЛОГО

Хөдөө аж ахуйн салбарын нөхцөл байдал, тулгамдаж буй асуудалд үндэслэн тус салбарыг бизнесийн үр ашигтай, бүтээмжтэй, өрсөлдөх чадвартай салбар болгон хөгжүүлэхэд дараах бодлого, арга хэмжээг хэрэгжүүлэх нь чухал байна.

- Цаашид хөдөө аж ахуйн гаралтай бараа, түүхий эдийн биржийн тухай хуулийг шинэчлэх, олон талын оролцоог хангасан мал, махыг борлуулах нэмэлт сувгийг нээж, энгийн шийдлээр нээлттэй арилжааг тогтмолжуулах, хөдөө аж ахуйн биржийн зах зээлийг олон талт, өрсөлдөөнт хэлбэрт шилжүүлэх шаардлагатай.
- Хөдөө аж ахуйн салбар дах төрийн оролцоог шат дараатайгаар бууруулах. Үр дүнгүй татаас, урамшууллыг үе шаттайгаар бууруулж, зах зээлийн олон талт, өрсөлдөөнт хэлбэрт шилжүүлэх. Дэмжлэг урамшууллын зорилгыг тодорхойлж, зорилгодоо хүрсэн тохиолдолд зогсоох, дэмжлэгийг эцсийн үр дүнд /боловсруулсан бүтээгдэхүүнд, хэрэглэгчдэд/ чиглүүлэх.
- Хөдөө аж ахуйн гаралтай бүтээгдэхүүний үнийн хяналтын тогтолцоог арилгаж, нийлүүлэлтийн сувгийг нэмэгдүүлэх.
- Хөдөө аж ахуйн гаралтай бүтээгдэхүүний гадаад худалдаа буюу экспорт, импортод аливаа төрлийн хориг, хязгаарлалт, квотыг цуцалж, гадаад худалдааг нээлттэй болгох.
- Бэлчээрийн мал аж ахуйд тулгуурласан хосолсон мал аж ахуйг хувийн хэвшлийг дэмжих замаар хөгжүүлж, бүтээгдэхүүний бэлтгэн нийлүүлэлтийн тогтолцоог бүрдүүлэх.
- Мал, амьтны тандалт, хяналт үйлчилгээний технологид олон улсын стандартыг нэвтрүүлж, өвчний тархалтыг хязгаарлан, Дэлхийн мал, амьтны эрүүл мэндийн байгууллагын тайван бүсийн үзүүлэлтийг бүсчлэн тогтоож, тогтвортой хадгалах.
- Мал, амьтны гоц халдварт өвчний вакциныг олон улсын стандартад нийцүүлэн дотоодод үйлдвэрлэх. Мөн гадаадаас импортлох боломжийг хязгаарлахгүй байх.
- Мал, амьтныг вакцинжуулах үйл ажиллагааг үр ашигтай зохион байгуулах, вакцинжуулалтын тогтолцоог сайжруулах.
- Малын чанар, үүлдрийг сайжруулах судалгаа, шинжилгээг хувийн хэвшлийн байгууллагуудын зах зээлийн шаардлагатай уялдуулан, бизнесийн зарчмаар хөгжүүлэх тогтолцоог бүрдүүлэх.
- Хөдөө аж ахуйн гаралтай бүтээгдэхүүнийг бүх боомтоор экспортлох.
- Экспортын баримжаатай хөдөө аж ахуйн бүтээгдэхүүний боловсруулалтын түвшнийг ахиулах үйлдвэр технологийн паркуудын дэд бүтцийн бүтээн байгуулалтыг дуусгах.
- Малын гаралтай бүтээгдэхүүний гарал үүслийг мөшгөх "Хариуцлагатай нүүдэлчин" систем, стандартыг нэвтрүүлж, хэвшүүлэх, түүнийг гадаадын зах зээл болон дотоодод /малчдад/ сурталчлах.

- Газар тариалангийн нийт эргэлтийн талбайн ашиглалтыг сайжруулж, нэгжийн гарцыг нэмэгдүүлэх
- Экспортын баримжаатай хөдөө аж ахуйн бүтээгдэхүүний боловсруулалтын түвшнийг ахиулах үйлдвэр технологийн паркуудын дэд бүтцийн бүтээн байгуулалтыг дуусгах.
- Малын гаралтай бүтээгдэхүүний гарал үүслийг мөшгөх "Хариуцлагатай нүүдэлчин" систем, стандартыг нэвтрүүлж, хэвшүүлэх, түүнийг гадаадын зах зээл болон дотоодод /малчдад/ сурталчлах.
- Газар тариалангийн нийт эргэлтийн талбайн ашиглалтыг сайжруулж, нэгжийн гарцыг нэмэгдүүлэх.

ТУРШЛАГА: ШИНЭ ЗЕЛАНД УЛСЫН ХӨДӨӨ АЖ АХУЙН САЛБАРТ ХЭРЭГЖҮҮЛСЭН БОДЛОГЫН ШИНЭЧЛЭЛ

Шинэ Зеланд улсад 1974 оноос эхэлсэн газрын тосны үнийн өсөлтөөс шалтгаалан дэлхийн эдийн засгийн хямралын нөлөөгөөр инфляц, ажилгүйдлийн түвшин нэмэгдэж эхэлсэн. Инфляцыг тогтвортой түвшинд хүчээр барьж, ХАА-н үйлдвэрлэлийг дэмжих зорилгоор 1975 оноос татварыг хөнгөлөх, бага хүүтэй зээл олгохын зэрэгцээ, урамшуулал, буцалтгүй тусламжийг олгож эхэлсэн. Энэ бодлого нь үйлдвэрлэлийг дэмжих биш эсрэгээрээ зах зээл дээр гажуудал үүсгэж эхэлсэн. Тухайлбал, төсөвт учруулах дарамт нэмэгдэж, хөдөө аж ахуйн бүтээгдэхүүнүүд өрсөлдөх чадваргүй болж, шинэлэг, эрэлтэд нийцсэн бүтээгдэхүүний үйлдвэрлэл багассан байна.

Улмаар 1985 онд мах, ноос, сүү, сүүн бүтээгдэхүүн, бордоо, усалгаа зэрэг хөдөө аж ахуйн бүтээгдэхүүний бүх татаас, үнийн дэмжлэгийг зогсоосон. 1988-1990 онд уг шинэчлэлийг хөнгөвчлөхийн тулд Засгийн газраас нэн шаардлагатай хүмүүст ажилгүйдлийн тэтгэмжтэй дүйцэхүйц дэмжлэг үзүүлэх, зээлийн нөхцөлийг өөрчлөх, тэлэх замаар өрийн менежмент хийх, хөдөө аж ахуйн бус салбарт бизнес эрхлэхэд санхүүгийн зөвлөгөө, тусламжийн үйлчилгээ санал болгосон.

Уг бодлогын шинэчлэлийн үр дүнд нийт тариаланчдын 16 хувь нь дампуурна гэж тооцоолж байсан ч 10 дахин бага буюу 1.6 хувь нь л зах зээлээс гарч, үйл ажиллагаагаа зогсоосон бөгөөд төсвийн зардал буурах, ХАА-н салбарын бүтээмж нэмэгдэх, бүтээгдэхүүний үнэ дэлхийн зах зээл дээрх үнэтэй жишиг түвшинд хүртэл нэмэгдэх, ХАА, аялал жуулчлал, бусад үйлчилгээний салбаруудын үйлдвэрлэл тэлж, эдийн засгийн төрөлжилт нэмэгдсэн зэрэг олон эерэг үр дүнгүүд гарсан. Уг бодлогын шинэчлэлийн дараагаас Шинэ Зеланд улс нь хөдөө аж ахуйн салбарын дэмжлэгийг зөвхөн малын өвчний хяналт, гамшгийн үеийн дэмжлэгт чиглүүлэхийн зэрэгцээ хөрөнгө оруулалтыг судалгаа, шинжилгээ мэдээлэл, технологид чиглүүлж байна¹⁵.

¹⁵ OECD, 2021, Agricultural Policy Monitoring and Evaluation.

ШИГТГЭЭ 3. АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН САЛБАРТ БАРИМТЛАХ БОДЛОГО

Аялал жуулчлалын салбарын нөхцөл байдал, тулгамдаж буй асуудалд үндэслэн тус салбарт байгальд ээлтэй, тогтвортой аялал жуулчлалыг хөгжүүлж, эдийн засгийг төрөлжүүлэхэд дараах бодлого, арга хэмжээг хэрэгжүүлэх нь чухал байна.

I. Гадаад сурталчилгаа, маркетинг

- Зорилтот орнуудад Social Media, барууны орнуудад уламжлалт сувагар сурталчилгаа хийх
- Аялал жуулчлалын контент хөгжүүлэх
- Контент үйлдвэрлэгчдээр дамжуулан монгол орны онцлог, өв уламжлалыг олон улсад сурталчлах

II. Хил орчмын аялал жуулчлал хөгжүүлэх

- Хил орчмын аялал жуулчлалын маршрутыг батлах, маршрутын дагуух дэд бүтцийг хөгжүүлэх
- Хил орчимд автомашинтайгаа аялах нөхцөлийг бүрдүүлэх

III. Виз олголт, цахим шилжилт

- Визийн шаардлагаас 2025 он хүртэл чөлөөлөөд байгаа дэлхийн өндөр хөгжилтэй Европын 32 улс болон Австрали, Шинэ Зеланд зэрэг улсуудыг цаашид бүрэн чөлөөлөх
- 1 хүнд ноогдох ДНБ манай улсаас өндөр бусад улс орны визийг үе шаттай чөлөөлөх
- Олон Улсад Монгол орны аялал жуулчлалын тухай цогц мэдээлэл авах, урьдчилан захиалга өгөх нэгдсэн цахим портал хөгжүүлэх
- МУ-д аялах холбоотой мэдээллийг олон хэлээр, нээлттэй байрлуулах
- Салбарт цахим шилжилтийн ажлыг зохион байгуулах

IV. Агаарын тээврийн хүртээмж, суудлын тоог нэмэгдүүлэх

- Олон улсын (УБ хотоос 8 цагийн зайтай 1 сая хүнээс дээш хүн амтай хотууд) чиглэлийг нэмэгдүүлэх
- Зарим орон нутгийн нисэх буудлуудыг Олон улсын нислэг хүлээн авах чадамжтай болгох (4С ангилал)

V. Нэвтрэх чадамжийг нэмэгдүүлэх

- Боомтын сэргэлтийн бодлоготой уялдуулан шинэчлэл хийж буй боомтуудын жуулчин нэвтрүүлэх хүчин чадлыг нэмэгдүүлэх.

VI. Бүтээгдэхүүн хөгжүүлэх

- Түүхэн, өвлийн, адал явдалт аялал жуулчлалын бүтээгдэхүүнүүдийг хөгжүүлж аялал жуулчлалын хугацааг уртасгах
- Нүүдэлчин соёл, тусгай хамгаалалтын газарт тулгуурласан өндөр зэрэглэлийн аялал жуулчлалыг хөгжүүлэх

VII. Дэд бүтцийг сайжруулах

- Боомтын сэргэлтийн бодлоготой уялдуулан автозамыг бүтээн байгуулах
- Олон улсын зэрэглэлтэй зочид буудал, ресортуудыг Монгол Улсад салбараа нээж, үйл ажиллагаа явуулах боломжоор хангаж, хөрөнгө оруулалтыг татах
- Орон нутгийн зам дагуу, үйлчилгээний газруудын ариун цэврийн асуудлыг шийдэх
- Амрах өртөө (200 км тутамд)-ний тоог нэмэгдүүлэх
- Отоглох цэгийг нэмэгдүүлэх
- Жуулчид төвлөрсөн аяллын бүсэд цахилгаан эрчим хүчний эх үүсвэрийн найдвартай байдлыг хангах
- Аялал жуулчлалын бүтээгдэхүүний стандартуудыг олон улсын түвшинд нийцүүлэн баталж, үйлчилгээний байгууллагуудад мөрдүүлэх

ШИГТГЭЭ 4. ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ОРЧИН

Хөрөнгө оруулалтын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл

Эдийн засаг, хөгжлийн яамнаас Хөрөнгө оруулалтын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон дагалдах хуулийн төслийг боловсруулж 2023 оны 4 дүгээр сарын 14-ний өдрөөс эхлэн 2 сарын хугацаанд олон нийтээс санал авч, 2 удаа нээлттэй хэлэлцүүлгийг зохион байгуулсан.

Тус хугацаанд олон улсын байгууллага, хөгжлийн түнш, Монгол Улсад суугаа Элчин сайдын яамд, мэргэжлийн холбоод, бизнесийн зөвлөл, танхимууд, төрийн байгууллага, гадаад, дотоодын аж ахуйн нэгж, иргэдээс нийт 695 саналыг хүлээн авсан бөгөөд нийт ирүүлсэн саналын 60 хувийг тусган Хөрөнгө оруулалтын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг боловсруулан Засгийн газрын 2023 оны 6 дугаар сарын 21-ний өдрийн хуралдаанаар хэлэлцүүлж, улмаар 2023 оны 6 дугаар сарын 23-ны өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн.

Хуулийн төсөлд хөрөнгө оруулалтын үйл ажиллагааг хориглосон, хязгаарласан зарим зохицуулалтуудыг арилгах, хөрөнгө оруулагчдад үзүүлэх баталгааг олон улсын сайн туршлагад нийцүүлэх, хөрөнгө оруулагчийн эрх, ашгийг хамгаалах зөвлөл буюу гомдол шийдвэрлэх тогтолцоог бүрдүүлэх, хөрөнгө оруулагч, төр хооронд үүссэн хөрөнгө оруулалтын маргааныг олон улсын арбитрын журмаар шийдвэрлүүлэх эрхийг баталгаажуулах, хөрөнгө оруулалтыг хамгаалах, дэмжих үүргийг төрийн бүх байгууллагуудын чиг үүрэг болгон тусгах, төрөөс хийх төлөвлөгөөт хяналт шалгалтын давхардлыг арилгах, тогтворжуулах гэрчилгээ олгох шалгуурыг хялбаршуулж, цахимаар олгох нөхцөлийг бүрдүүлэх зэрэг зохицуулалтуудыг тусгасан.

Гадаадын хөрөнгө оруулагчдын гомдол шийдвэрлэлт

Эдийн засаг, хөгжлийн яам нь хөрөнгө оруулагчийн хууль ёсны эрх ашгийг хамгаалах чиглэлээр онцгой анхаарч, хөрөнгө оруулагчийн гомдлыг тогтмол хүлээн авч, Засгийн газрын хуралдаанд танилцуулан шийдвэрлүүлж, хэрэгжилтэд байнгын хяналт тавьж ажиллаж байна.

Энэхүү ажлын хүрээнд Засгийн газрын 2022 оны 413 дугаар тогтоолоор сэргээгдэх эрчим хүч, уул уурхай болон бусад чиглэлд үйл ажиллагаа явуулж буй гадаадын хөрөнгө оруулалттай 32 аж ахуйн нэгжээс ирүүлсэн гомдлыг, 2023 оны 160 дугаар тогтоолоор уул уурхай, газрын тос, иргэний агаарын тээвэр болон барилгын салбарт үйл ажиллагаа явуулж буй гадаадын хөрөнгө оруулалттай 5 аж ахуйн нэгжээс ирүүлсэн гомдлыг судалж, хуулийн дагуу шуурхай шийдвэрлэхийг холбогдох байгууллага, албан тушаалтанд үүрэг болгосон.

Хөрөнгө оруулагчийн гарын авлага

Эдийн засаг, хөгжлийн яам нь Германы олон улсын хамтын ажиллагааны нийгэмлэгтэй хамтран хөрөнгө оруулагч нарт зориулсан гарын авлагыг бүрэн шинэчилж эхний төслийг “Монголын эдийн засгийн форум 2023”-ын үеэр танилцуулсан. Тус гарын авлагад Монгол Улсын эдийн засгийн нөхцөл байдал, хөрөнгө оруулалт, бизнесийн орчин, худалдаа болон гаалийн зохицуулалт, ажиллах хүч болон визний мэдээлэл, татварын орчин, компанийн бүртгэл, үйл ажиллагаа болон тусгай зөвшөөрөл, Засгийн газрын бодлого, хөрөнгө оруулалтын боломж, дэмжлэг зэрэг бизнесийн үйл ажиллагаа эхлүүлэхээс татан буугдах хүртэлх хөрөнгө оруулагч нарт шаардлагатай бүхий л мэдээллийг 12 бүлэгт цогцоор нь багтаасан.

ШИГТГЭЭ 5. ТӨР, ХУВИЙН ХЭВШЛИЙН ТҮНШЛЭЛИЙН ТУХАЙ ХУУЛЬ

Монгол Улсын Их Хурлын 2022 оны 12 дугаар сарын 9-ний өдрийн чуулганаар Төр, хувийн хэвшлийн түншлэлийн тухай хууль батлагдсан. Энэхүү хуулийг 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

Хуулийн зорилт: Нийтийн зориулалттай дэд бүтэц, төрийн үйлчилгээний салбарт төр, хувийн хэвшлийн түншлэлийн төслийг хэрэгжүүлэх, хувийн хэвшлийн оролцоо, хөрөнгө оруулалтыг дэмжих, төр, хувийн хэвшил эрсдэлийн оновчтой удирдлагад суурилан түншлэлийн гэрээний дагуу урт хугацаанд үр ашигтай хамтран ажиллах болон санхүү, төсвийн зохистой удирдлагыг хэрэгжүүлэхтэй холбогдуулан эрх зүйн таатай орчныг бүрдүүлэхэд оршино.

Үйлчлэх хүрээ: Төр, хувийн хэвшил хамтран хэрэгжүүлэх төслийг төлөвлөх, боловсруулах, үнэлэх, судлан шинжилсний үндсэн дээр төслийг сонгох, хувийн хэвшлийн түншлэгчийг сонгон шалгаруулах, түншлэлийн гэрээг байгуулах болон хэрэгжүүлэхтэй холбогдсон харилцаанд уг хууль үйлчилнэ.

Түншлэлийн зарчим: Нийтийн зориулалттай дэд бүтэц, төрийн үйлчилгээний салбарт хэрэгжүүлэх, олон нийтийн ашиг сонирхолд нийцсэн, олон нийтэд үйлчлэх зорилгыг дэмжсэн, төрийн үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулах, төсөв, санхүүгийн удирдлагад хяналт, зохицуулалтын тэнцвэрийг хангаж, хувийн хэвшилд суурилсан эдийн засгийн өсөлтийг дэмжихэд чиглэсэн, төр, хувийн хэвшлийн хооронд эрх, үүргийг тодорхойлж, эрсдэлийг оновчтой хуваарилах, сайн засаглалын зарчимд тулгуурлах, урт хугацаанд төсвийн зардлыг чанар, үр дүн, гүйцэтгэлд үндэслэн хуваарилах, төрийн үйлчилгээг хангах санхүүгийн эх үүсвэрийг нэмэгдүүлэх замаар эдийн засгийн үр ашгийг дээшлүүлэхэд чиглэсэн байх.

Түншлэлийн төрөл:

- Түншлэлийн төслийн зардлыг хэрэглэгчийн төлбөр, хураамж болон төслийн орлогоор санхүүжүүлэх
- Түншлэлийн төслийн зардлыг түншлэлийн гэрээнд заасны дагуу төсвөөс санхүүжүүлэх
- Холимог төрөл

Түншлэлийн гэрээний төрөл:

- Зураг төсөл, төсвийг боловсруулах, барих, ашиглах, шилжүүлэх
- Барих, ашиглах, шилжүүлэх
- Барих, шилжүүлэх, ашиглах
- Барих, түрээслэх, ашиглах, шилжүүлэх
- Барих, өмчлөх, ашиглах, шилжүүлэх
- Түрээслэх болон түрээслүүлж төрийн үйлчилгээг үзүүлэх
- Ашиглалт болон засвар арчлалтыг хэрэгжүүлэх
- Сэргээн засварлах, эзэмших, ашиглах, шилжүүлэх
- Удирдлагыг хэрэгжүүлэх
- Төслийн бүрэн шинжилгээгээр тодорхойлсон түншлэлийн гэрээний бусад төрлүүд

Барих-шилжүүлэх төрлөөр барьж байгуулаад шууд шилжүүлэх нөхцөлтэй, богино хугацаанд хэрэгжүүлэх, төсвийн хөрөнгө оруулалтаас үл ялгагдах төрлийн гэрээг байгуулах болон түншлэлээр хэрэгжүүлэхийг хориглоно.

Түншлэлийн төв: Түншлэлээр хэрэгжүүлэх төслийн тооцоо судалгааг хийх, төслийг хөгжүүлэх, техник эдийн засгийн үндэслэлийг боловсруулах, эрсдэлийг үнэлэх, хувийн хэвшлийн оролцоо, чадамж, сонирхлыг тандан судлах, түншлэлийн төслийг хөрөнгө оруулагч болон бусад сонирхогч талуудад сурталчлах үндсэн чиг үүрэг бүхий төвийг байгуулна

Түншлэлийн төсөл хөгжүүлэх сан: Түншлэлийг хэрэгжүүлэх, санхүүжилтийг шийдвэрлэх, төслийн бэлтгэл ажиллагаа, судалгаа шинжилгээ, сонгон шалгаруулалтыг явуулах, зөвлөх үйлчилгээний зардал болон түншлэлийн төвийн үйл ажиллагааны зардлыг санхүүжүүлэх зорилготой санг байгуулна.

Уг хуулийн хүрээнд хэрэгжүүлэхээр төлөвлөж буй төслүүдээс:

- “Шинэ тойрог зам” төслийн урд хэсэг “Туулын авто зам” төсөл
- Хөвсгөл, Ховд, Дорнод, Өмнөговь аймгуудын нисэх буудлын хүчин чадлыг нэмэгдүүлэх төслүүд
- “Рашаант-Хөшигийн хөндий-Хоолт зөрлөг” чиглэлийн 4 эгнээ, “Налайх-Багахангай-Чойр-Сайшанд-Замын-Үүд” чиглэлийн 2 эгнээ тусгай зориулалтын авто зам барих төсөл
- “Дархан-Алтанбулаг” чиглэлийн авто замыг 4 эгнээ болгон өргөтгөн шинэчлэх төсөл

ШИГТГЭЭ 6. БАЙГАЛЬ ОРЧИНД НӨЛӨӨЛӨХ БАЙДЛЫН ҮНЭЛГЭЭНИЙ ЗОХИЦУУЛАЛТЫН ӨӨРЧЛӨЛТ

Одоо мөрдөгдөж буй хуулиар байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээ хийлгэхийг том жижиг гэлтгүй бүх төрлийн бизнесүүдээс шаардаж байна. Тухайлбал Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хуулийн 7.3-т "... энэ хуулийн хавсралтад заасан ангиллын дагуу ... байгаль орчны нөлөөллийн ерөнхий үнэлгээ хийлгэнэ" гэж ангиллыг хавсралтаар тогтоохоор хуульчилсан ба тус ангилал нь бүх төрлийн үйл ажиллагааг хамарч байна.

Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хуулийн хавсралт дахь "Байгаль орчны нөлөөллийн ерөнхий үнэлгээ хийх төслийн ангилал":

- Уул уурхай
- Эрчим хүч
- Хөдөө аж ахуй
- Боловсруулах
- Аялал жуулчлал
- Үйлчилгээ
- Биологийн төрөл зүйл
- Дэд бүтцийн хөгжил
- Хүнсний үйлдвэр
- Хөнгөн үйлдвэр
- Хүнд үйлдвэр
- Бусад салбар

Байгаль орчинд нөлөөлөх байдлын ерөнхий үнэлгээ хийлгэхэд хамгийн багадаа 90 хоног, 3-8 сая төгрөгийн зардал харин нарийвчилсан үнэлгээ хийлгэхэд хамгийн багадаа 200 хоног, 4-20 сая төгрөг зарцуулж байгаа гэсэн тооцоо байна. Мөн үнэлгээнд үндэслэж, бизнесүүд байгаль орчны менежментийн төлөвлөгөө батлуулан мөрддөг ба тухайн төлөвлөгөөний хэрэгжилтэд шаардлагатай санхүүжилтийн 50-аас доошгүй хувьтай тэнцэх хэмжээний мөнгөн хөрөнгийг төсөл хэрэгжих харьяа сум, дүүргийн Засаг даргын дэргэдэх байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээлтийн тусгай данс эсвэл байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын нөхөн сэргээлтийн тусгай дансанд төвлөрүүлж, төлөвлөгөөний хэрэгжилтийг жил бүр тайлагнадаг байна. Түүнчлэн хэрэгжилтэд хяналт тавих, байгаль орчинд нөлөөлөх байдлын ерөнхий болон нарийвчилсан үнэлгээнд магадалгаа хийлгэх, давтан үнэлгээ хийлгэх, мөн байгаль орчны хуримтлагдсан нөлөөллийн үнэлгээ хийлгэх зэрэг цаг, хөрөнгө зарцуулсан маш төвөгтэй хяналт, шалгалтуудтай бизнес эрхлэгч нар тулгарч байна.

Эдийн засаг, хөгжлийн яамны зүгээс бизнес эрхлэх болон хөрөнгө оруулалтын таатай орчин бүрдүүлэх зорилгоор байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээ хийлгэх шаардлага бүхий бизнесийн төрлийг цөөрүүлж, тодорхой хүрээнд хязгаарлан тогтоох, үнэлгээний процессыг хялбарчлах, төрийн болон хүний оролцоог бууруулах, цахим хэлбэрт шилжүүлэх бодлогыг баримтлан холбогдох арга хэмжээг Засгийн газрын 2023 оны 233 дугаар тогтоолд батлуулж, хэрэгжилтийг ханган ажиллаж байна.

Энэ хүрээнд БОАЖЯ-аас "Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай" хуулийн төсөл, дагалдан гарах байгаль орчны үнэлгээ хийлгэх бизнесийн ангиллын төслийг боловсруулаад байна. Хуулийн өөрчлөлтөөр үнэлгээнд зарцуулж буй хугацааг 60-70 өдрөөр бууруулна гэсэн хүлээлттэй байна.

Эдийн засаг, хөгжлийн яам байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний зохицуулалтыг сайжруулах чиглэлд бизнесийн байгаль орчинд үзүүлэх нөлөөллийн зэрэглэлийг үйл ажиллагааных нь хүчин чадал, цар хүрээний тодорхой шалгуур үзүүлэлтээр зааглан, цөөн тодорхой тооны байгаль орчинд их нөлөө бүхий томоохон үйл ажиллагаанаас шаарддаг болох, бусад бүх бизнесийг тус үнэлгээнээс бүрэн чөлөөлөх, байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний материалыг цахимаар хүлээн авч, цахимаар шийддэг болох, үнэлгээний процессыг цахимаар хянах, үнэлгээний дүгнэлт, шийдвэр, хэрэгжилт зэрэг холбогдох мэдээллийг цахим орчинд байршуулах замаар ил тод байдлыг хангах бодлогыг барин ажиллаж байна.

ШИГТГЭЭ 7. БҮСЧИЛСЭН ХӨГЖЛИЙН ҮЗЭЛ БАРИМТЛАЛ

Монгол Улсын 2023 оны 481 дүгээр тогтоолоор “2024 оныг Бүсчилсэн хөгжлийг дэмжих жил” болгон зарласны хүрээнд Бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлалыг шинэчлэн боловсруулж байна.

Монгол Улсын УИХ 2001 оны 57 дугаар тогтоолоор “Монгол Улсын бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлал”-ыг баталснаас хойш 22 жилийн хугацаа өнгөрсөн. Тус баримт бичгийн гол үзэл санаа нь Монгол Улсын газар түүний баялаг, түүхий эдийн нөөц, оюуны чадавхыг оновчтой ашиглан хүн ам, үйлдвэрлэлийн зохисгүй бөөгнөрлийг задалж хот, хөдөөгийн хөгжлийн ялгаа, аймаг, бүс нутаг хоорондын тэнцвэргүй байдлыг багасган хөгжлийн түвшнийг ойртуулж, үндэсний эдийн засаг, нийгмийн дэвшлийг түргэтгэх байв.

Энэ хугацаанд Улаанбаатар хотод нийт хүн амын 46.9 хувь нь амьдарч, ААН-ийн 70.8 хувь нь үйл ажиллагаа явуулж,

ДНБ-ний 63 хувийг бүрдүүлж байна. Харин орон нутагт нийт хүн амын 53.1 хувь нь амьдарч, ААН-ийн 29.2 хувь нь үйл ажиллагаа явуулж, ДНБ-ий 37 хувь бүтээгдэж байгаа нь хөгжил бүс, орон нутгуудын хувьд ялгаатай, тэнцвэргүй байдал үүссэнийг илэрхийлж байна.

Өнгөрсөн 20 жилийн хугацаанд энэхүү үзэл баримтлалыг хэрэгжүүлэх талаар зарим нааштай өөрчлөлт, алхмууд хийгдсэн боловч дээрх зорилт бүрэн үр дүнтэй хэрэгжиж чадаагүй байна.

Иймээс эдийн засгийн хязгаарлагдмал нөөц болох ажиллах хүч, капитал, байгалийн баялгийг хамгийн үр ашигтай, хөрөнгө оруулалтын оновчтой хуваарилалтыг бий болгох, хөгжлийг түргэсгэхийн тулд бүсчилж хөгжүүлэх нь чухал ач холбогдолтой юм.

Зураг 2. Бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлалын төслийн эдийн засгийн бүсчлэл



Бүсийн тогтолцоонд шилжсэнээр улсын төсвийн хөрөнгө оруулалтын төсөл хөтөлбөрүүд нь орон зайн хувьд оновчтой, эдийн засгийн илүү их үр өгөөж өгөх, хувийн хэвшлийн хөгжлийг дэмжихэд чиглэнэ. Ингэснээр орон нутагт үйлдвэр үйлчилгээ, хувийн байгууллага шилжин суурьших таатай орон зайг бий болгоно. Энэ үед бүс, орон нутагт ажилгүйдэл, ядуурал буурч, хөдөлмөр эрхлэлт, өрхийн орлого нэмэгдэнэ. Бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлалын хүрээнд байгаль орчин, эдийн засаг, нийгмийн шалгуур үзүүлэлтээр функциональ бүсүүдийг мөн тодорхойлсон.

Үүнд:

- (1) Хүнд үйлдвэрлэл хөгжүүлэхэд тохиромжтой бүс;
- (2) Хөнгөн үйлдвэрлэл хөгжүүлэхэд тохиромжтой бүс;
- (3) Аялал, жуулчлал хөгжүүлэхэд тохиромжтой бүс.

Дээрх функциональ бүсүүдийг тодорхойлсноор салбар хоорондын уялдаа, бүсүүдийн хоршилт, төрөлжилтийг дэмжих, бүс нутгийн эдийн засгийн хамтын ажиллагааг

өргөжүүлэх, байгалийн нөөц, чадавхыг эдийн засгийн өсөлт, нутаг дэвсгэрийн тэнцвэртэй хөгжлийг хангах, нэмүү өртгийн сүлжээ, кластер, инновац, үйлдвэрлэлийн бүсийг байгуулах, улсын дэд бүтцийн тэнхлэгийн үндсэн сүлжээтэй холбогдох тээвэр-логистикийн нэгдсэн сүлжээг бий болгох, хөдөлмөр эрхлэлтийг нэмэгдүүлэх, төрөөс үзүүлэх нийгмийн үйлчилгээний жишиг нормативыг хангах, хүн амын шилжилт хөдөлгөөнийг зохицуулах, хөрөнгө оруулалтыг нутаг дэвсгэрээр оновчтой хуваарилахад үр дүнтэй юм.

Бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлалыг шинэчлэн боловсруулахдаа олон улсын бүсчлэлийн чиг хандлага, онол, загвар, үзэл баримтлалууд болон хөрөнгө оруулалтын хуваарилалтын хэрэгцээ шаардлагуудыг үндэслэн олон улсын практик, туршлагад ашиглагдаж буй шалгуур үзүүлэлтүүдийг матрицын аргаар хамгийн их давхцаж буй шалгуур үзүүлэлтүүдийг эрэмбэлж, байгаль орчин, эдийн засаг, нийгмийн 3 бүлэгт харилцан тэнцвэртэй байхаар сонгож авсан.


Зураг 3. Эдийн засгийн бүсчлэл тогтоох, өсөлтийн төвүүдийг тодорхойлох шалгуур үзүүлэлт



Эдийн засгийн бүсчлэл тогтоох нийтлэг 19 шалгуур үзүүлэлтийг тодорхойлж, түүнийг хөрөнгө оруулалтын үүднээс дахин засварлаж, цаашид ашиглах болно. Энэхүү 20 шалгуур үзүүлэлт нь байгаль орчин, эдийн засаг, нийгмийн 3 бүлэгт хуваарилагдсан. Улмаар шатлан үнэлэх загвараар (АНР) хувийн жинг тэнцвэртэй байх зарчимд үндэслэн тогтоосон. Үүнд:

1. Байгаль орчны бүлэгт 8 шалгуур үзүүлэлт, нийт үнэлгээний 30 хувь
2. Эдийн засгийн бүлэгт 7 шалгуур үзүүлэлт, нийт үнэлгээний 40 хувь
3. Нийгмийн бүлэгт 5 шалгуур үзүүлэлт, нийт үнэлгээний 30.0 хувийг тус тус бүрдүүлж байна.

Зураг 4. Эдийн засгийн өсөлтийн төвүүд



Эдгээр эдийн засгийн өсөлтийн төвүүдийг тодорхойлсноор салбар хоорондын уялдаа, бүсүүдийн хоршилт, төрөлжилтийг дэмжих, бүс нутгийн эдийн засгийн хамтын ажиллагааг өргөжүүлэх, байгалийн нөөц, чадавхыг эдийн засгийн өсөлт, нутаг дэвсгэрийн тэнцвэртэй хөгжлийг хангах, нэмүү өртгийн сүлжээ, кластер, инновац, үйлдвэрлэлийн бүсийг байгуулах, улсын дэд бүтцийн тэнхлэгийн үндсэн сүлжээтэй холбогдох тээвэр-логистикийн нэгдсэн сүлжээг бий болгох, ажилгүйдэл ядуурлыг бууруулах, төрөөс үзүүлэх нийгмийн үйлчилгээний жишиг нормативыг хангах, хүн амын шилжилт хөдөлгөөнийг зохицуулах, хөрөнгө оруулалтыг нутаг дэвсгэрээр оновчтой хуваарилахад үр дүнтэй.

ШИГТГЭЭ 8. АЙМАГ, СУМЫН БҮСЧИЛСЭН НОГООН ХӨГЖЛИЙН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ХӨТӨЛБӨР

Азийн хөгжлийн банкт хамтран хэрэгжүүлэх “Аймаг, сумын бүсчилсэн ногоон хөгжлийн хөрөнгө оруулалтын хөтөлбөр”-ийн зээлийн санхүүжилтийн ерөнхий хэлэлцээрийн төслийг Засгийн газрын хуралдаан, Эдийн засгийн байнгын хороо, Төсвийн байнгын хороо, Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хорооны хуралдаанд танилцуулж, дэмжигдсэн.

Улсын Их Хурлаар соёрхон батлуулахаар Засгийн газраас 2023 оны 7 сарын 6-ны өдөр өргөн барьсан. 2023 оны 07 дугаар сарын 07-ны өдрийн УИХ-аар “Аймаг, сумын бүсчилсэн ногоон хөгжлийн хөрөнгө оруулалтын хөтөлбөр”-ийн Санхүүжилтийн ерөнхий хэлэлцээрийг батлуулав.



Уг хөтөлбөр нь “Шинэ сэргэлтийн бодлого”-ын баримт бичгийн хүрээнд Монгол Улсын эдийн засгийн бие даасан байдлыг бэхжүүлэх, “Ковид-19” цар тахлын эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах, хөгжлийг хязгаарлагч хүчин зүйлийг цаг алдалгүй шийдвэрлэх, ногоон хөгжлийг дэмжих зорилтуудтай нийцсэн.

Мөн Монгол Улсын Ерөнхийлөгчийн санаачилсан “Хүнсний хангамж, аюулгүй байдал” үндэсний хөдөлгөөний хүрээнд “Хүнсний хангамж, аюулгүй байдлыг хангах талаар авах зарим арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын 2022 оны 06 дугаар сарын 17-ны өдрийн 36 дугаар тогтоолоор баталсан чиглэлүүд болон хэрэгжүүлэх үйл ажиллагаатай нягт уялдаж байна.

Тус хөтөлбөр нь хүнсний нийлүүлэлтийн сүлжээ, тогтолцоо, хүнсний аюулгүй байдлыг хангах, хот хөдөөгийн уялдаа холбоог дэмжих, аймаг, сумын төвүүдэд хүн амьдрахад таатай орчныг

бүрдүүлэх, хүнсний гол нэрийн бүтээгдэхүүний үйлдвэрлэл, экспортыг нэмэгдүүлэх, импортыг орлох ногоон, хөдөө аж ахуйн бизнесийг хөгжүүлэх үндэс болох юм.

Тус хөрөнгө оруулалтын хөтөлбөр нь хүнс, хөдөө аж ахуйн үйлдвэрлэлийг дэмжих инженерийн дэд бүтэц, тээвэр логистикийн төвийг байгуулах, хөдөө аж ахуйн салбарт оруулах ногоон санхүүжилтийг дэмжих (тухайлбал: ногоон зээл, жижиг, дунд бизнесийг хөгжүүлэх буцалтгүй тусламж, хөнгөлөлттэй зээл), хөдөө аж ахуйн менежментийг сайжруулан, түүнийг хянах тогтолцоог бүрдүүлнэ.

Хөтөлбөр нь нийт 10 жилийн хугацаанд 17 аймгийн 52 суманд хэрэгжүүлэхээр төлөвлөж байгаа бөгөөд дунд хугацааны бодлогын баримт бичигтэй бүрэн нийцсэн ба урт хугацааны бодлогын баримт бичгийн арга хэмжээг хэрэгжүүлэх суурь нөхцөл нь болно.


ШИГТГЭЭ 9. АВЛИГЫН ТӨСӨӨЛЛИЙН ИНДЕКС

Монгол Улс 2023 онд Авлигын төсөөллийн индексээр дэлхийн 180 орноос 121 дүгээрт жагсаж, өмнөх оноос 5 байраар ухарлаа. Манай улсыг Доминикан, Египет, Замби, Алжир, Украин зэрэг улсууд авлигын үзүүлэлтээр гүйцэж түрүүлсэн ба эдгээр улсуудын үнэлгээ дунджаар 3.6 оноогоор нэмэгджээ.

Транспаренси Интернэшнл олон улсын байгууллагаас тооцоолон гаргадаг тус индекс нь дэлхийн улс орнуудын төсвийн зарцуулалт, эрх мэдлээ урвуулан ашиглах байдал, авлигын гэмт хэрэгт хариуцлага тооцох тогтолцоо зэрэг үзүүлэлтүүдийг 13 орчим эх сурвалжийн судалгаа, тайланг нэгтгэн тооцдог байна. Тус индексийг 0-100 онооны хооронд үнэлж гаргадаг бөгөөд индекс 100-д ойртох тусам авлигын төсөөлж буй түвшин бага, 0-д ойртох тусам авлига их байна гэж үздэг.


Монгол Улс 2023 онд Авлигын төсөөллийн индексээр 33 оноо авсан нь дэлхийн дунджаас 10 оноо, бүс нутгийн дунджаас 12 оноогоор бага байгаа бөгөөд 2015 оны үнэлгээтэй харьцуулахад 6 оноо буурч, эрэмбэ 49 байраар ухраад байгаа ажээ. Монгол Улсын Авлигын төсөөллийн индексийн үнэлгээг нийт 7 эх сурвалжийн судалгаа, тайланд үндэслэн боловсруулсан байна. Үүнээс, IMD Дэлхийн өрсөлдөх чадварын тайланд авлига, хээл хахуулийн тархсан байдал, PRS группийн Олон улсын эрсдэлийн тайланд улс төрийн авлига гэсэн үзүүлэлтүүд сайжирчээ. Харин V-Dem Ардчиллын индексээр төрийн алба болон гүйцэтгэх засаглал дахь авлига, Шударга ёсны төслийн Төрийн зарчимт ёсны индексээр шүүх, хууль сахиулах байгууллагын авлига гэсэн үзүүлэлтүүдийн үнэлгээг бууруулсан байна.

Зураг 5. Авлигын төсөөллийн индексийн оноо, эрэмбэ



Эх сурвалж: Транспаренси Интернэшнл

Зураг 6. Авлигын төсөөллийн индексийн эрэмбэ



Индекс тооцсон улс орнуудын 2/3 нь 50-аас бага үнэлгээ авч, авлигын асуудал дэлхий дахинд тулгамдсан асуудлын нэг болж байна. Баруун Европ, Европын холбооны улсууд авлигын үзүүлэлтээр сайн үнэлэгддэг ч 2023 онд бүс нутгийн дундаж оноо 65 хүрч, өмнөх жилүүдээс нэг оноогоор буурчээ. Харин Сахарын цөлөөс өмнөх Африкийн улсууд авлигын үзүүлэлтээр хамгийн сул (33 оноо) үнэлэгдэж байна. Америк тив (43 оноо), Ази номхон далайн бүс (45 оноо), Зүүн Европ, Төв Ази (35 оноо), Ойрх дорнод, Хойд Африк (38 оноо)-т авлигын үзүүлэлт мөн л ахицгүй, бүс нутгийн дундаж оноо буурах хандлага ажиглагдаж байна.

Дэлхийд авлигын үзүүлэлтээр тэргүүлэгч байр сууриа Европын холбооны улсууд болон Сингапур улс хадгалсаар

байна. Европын холбооны улс орнуудад төрийн үйл ажиллагааны ил тод байдал, олон нийтийн хяналт илүү түлхүү хөгжсөн байх бол Сингапурт хатуу ялын бодлого, залхаан цээрлүүлэлтийг авлигын гэмт хэрэгтэй тэмцэхэд ашиглаж байна. Харин зэвсэгт мөргөлдөөний нөхцөл байдалд байгаа Сомали, Венесуэл, Сири, Өмнөд Судан, Йемен зэрэг улсууд индексээр сүүл мушгиж байна.

Авлигаас урьдчилан сэргийлэх, таслан зогсоох хүрээнд авлигын гэмт хэрэгтнүүдэд хариуцлага шударгаар тооцох, шүүхийн бие даасан байдал, ил тод байдлыг хангах, шийдвэр гаргах үйл ажиллагаанд иргэдийн оролцоо, хяналтыг нэмэгдүүлэхийг Транспаренси Интернэшнлээс дэлхийн нийтэд уриалсан байна.

ШИГТГЭЭ 10. АРДЧИЛЛЫН ИНДЕКС

Эдийн засгийн шинжилгээний төв /Economic Intelligence Unit/-өөс нэгтгэн гаргадаг Ардчиллын индексээр Монгол Улс 2023 онд дэлхийн 167 орноос 59 дүгээрт жагсаж, өмнөх оноос 7 байраар ахижээ.

Тус индекс нь дэлхийн улс орнуудын ардчиллын эрх, ардчилсан тогтоолцоог Сонгуулийн үйл явц ба олон ургалч үзэл, Иргэний эрх чөлөө, Засгийн газрын үйл ажиллагаа, Улс төрийн оролцоо, Улс төрийн соёл гэсэн 5 бүлэг үзүүлэлтээр үнэлж нэгтгэн, 0-10 оноог өгдөг. Түүнчлэн үнэлгээнд үндэслэн дэлхийн улс орнуудыг бүрэн ардчилсан (8-аас дээш оноо), ардчилсан дэглэм гажуудсан (6-8 оноо), холимог дэглэмтэй (4-6 оноо), авторитар дэглэмтэй (4 хүртэлх) гэж 4 ангилж хуваадаг байна.

Судалгааны үр дүнгээр дэлхийн нийт улс орнуудын 15 хувь нь бүрэн ардчилсан, 30 хувь нь хагас ардчилсан, 20 хувь нь хагас дарангуйлсан, 35 хувь нь дарангуйллын дэглэмтэй нийгэмд амьдарч байгаа гэжээ. Сүүлийн жилүүдэд ихэнх улсууд ардчиллаас ухарч, дарангуйллын дэглэмд шилжих хандлагатай байна. 2023 онд Ардчиллын индексийн дэлхийн дундаж оноо 2006 онд индекс тооцож эхэлснээс хойших түүхэн доод түвшиндээ хүрч 5.23 оноо авчээ. Индексийн бүлгүүдээр харьцуулахад Засгийн газрын үйл ажиллагаа бүлгээр улс орнууд хамгийн сул (4.67 оноо) үнэлэгдэж байгаа бол Сонгуулийн үйл явц ба олон ургалч үзэл бүлгээр сайн (5.49 оноо) үнэлэгджээ.

2023 онд Африк, Европ, Ойрх Дорнодод болсон дайнаас үүдэлтэй улс төрийн нөхцөл байдал ардчилалд ихээхэн сөрөг нөлөө үзүүлээ. Түүнчлэн, АНУ, БНХАУ-ын дэлхийн ноёрхлын

төлөөх тэмцэл, Саудын Араб, Турк зэрэг шинээр түрж орж буй томоохон эдийн засгууд дэлхийд өөрчлөлт шинэчлэлтийг дагуулж байна.

Ардчиллын индексээр тэргүүлж буй 10 улсын 8 нь Баруун Европын улс орнууд байна. Баруун Европ (8.37 оноо), Хойд Америк (8.27 оноо) бүс нутгийн дунджаар тэргүүлж, тэр дундаа сонгуулийн үйл явц ба олон ургалч үзэл, иргэний эрх чөлөө бүлгүүдээр дэлхийд манлайлж байна. Харин Ойрх Дорнод, Хойд Африк (3.23 оноо) болон Сахарын цөлөөс өмнөх Африк (4.04 оноо)-ийн улсууд ардчиллын үзүүлэлтээр сүүл мушгиж, үнэлгээ жилээс жилд буурч байна. Тухайлбал, Засгийн газрын үйл ажиллагаа, сонгуулийн үйл явц ба олон ургалч үзэл, иргэний эрх чөлөө бүлгүүдийн оноогоор сул үнэлэгдэж байна. Ази номхон далайн бүс (5.41 оноо), Зүүн Европ, Төв Ази (5.37 оноо), Латин Америк ба Карибын тэнгис (5.68 оноо)-ийн бүс нутгийн дундаж оноо мөн л буурах хандлагатай байна.


Монгол Улс 2023 онд ардчиллын индексээр 6.5 оноо авсан нь дэлхийн дунджаас 1.3 оноогоор өндөр байна. Индексийн 5 бүлгээс сонгуулийн үйл явц болон олон ургалч үзэл (8.8 оноо) бүлгээр сайн үнэлэгдсэн бол иргэний эрх чөлөө (6.2 оноо), улс төрийн оролцоо (6.1 оноо), Засгийн газрын үйл ажиллагаа (5.7 оноо), улс төрийн соёл (5.6 оноо) бүлгүүдээр дунджаас дээгүүр үнэлэгдэж байна. Өмнөх онтой харьцуулахад Засгийн газрын үйл ажиллагаа, иргэний эрх чөлөө бүлгүүдийн үзүүлэлт сайжирсан нь нийт үнэлгээ өсөхөд голчлон нөлөөллөө.

Зураг 7. Ардчиллын индексийн оноо



Эх сурвалж: Economist Intelligence Unit

Зураг 8. Ардчиллын индексийн эрэмбэ



Зураг 9. Ардчиллын индексийн оноо, дэлхийн топ улсуудаар



¹⁶Бүрэн ардчилсан: Улс төрийн үндсэн эрх чөлөө, иргэний эрх чөлөөг дээдэлдэг, ардчилал цэцэглэн хөгжихөд таатай, хэвлэл мэдээлэл нь олон талт бие даасан

Ардчилсан дэглэм гажуудсан: Чөлөөт шударга сонгуультай хэдий ч улс төрийн соёл хөгжөөгүй, улс төрийн оролцоо бага байдаг гэх мэт сул талтай

Холимог дэглэмтэй: Сонгууль нь шударга явагдахад саад ихтэй, сөрөг хүчний нам нэр дэвшигчдэд дарамт шахалт үзүүлдэг, улс төрийн оролцоо сул

Авторитар дэглэмтэй: Улс төрийн олон ургалч үзэл байхгүй эсвэл хязгаарлагдмал бөгөөд дарангуйллын дэглэмтэй.

ХҮСНЭГТ 1. МАКРО ЭДИЙН ЗАСГИЙН ҮНДСЭН ҮЗҮҮЛЭЛТҮҮД

	2019	2020	2021	2022	2023
МАКРО ЭДИЙН ЗАСГИЙН ҮНДСЭН ҮЗҮҮЛЭЛТҮҮД					
БОДИТ СЕКТОР					
Нэрлэсэн ДНБ (тэрбум төгрөгөөр)	37,839	37,453	43,555	53,852	68,872
Бодит ДНБ өсөлт - үйлдвэрлэл (хувиар)	5.6	-4.6	1.6	5.0	7.0
Бодит ДНБ өсөлт - эцсийн ашиглалт (хувиар)	5.5	-4.4	1.6	5.0	7.1
Дотоод эрэлтийн оролцоо (нэгж хувиар)	5.6	-12.6	17.6	11.4	1.9
Бараа, үйлчилгээний экспортын оролцоо (нэгж хувиар)	5.8	-2.7	-7.5	13.9	23.3
Бараа, үйлчилгээний импортын оролцоо (нэгж хувиар)	-5.9	11.0	-8.5	-20.3	-18.0
Бодит ДНБ-ий өсөлт дэх оролцоо (нэгж хувиар)					
Эцсийн хэрэглээ	5.5	3.6	-2.3	6.5	6.1
Өрхийн хэрэглээ	3.7	1.3	-4.0	5.1	4.8
Төрийн байгууллагын хэрэглээ	1.8	2.2	1.7	1.4	1.3
Хөрөнгийн нийт хуримтлал	0.1	-16.2	19.9	4.9	-4.3
Цэвэр экспорт	-0.1	8.2	-16.0	-6.4	5.2
(ДНБ-д эзлэх хувиар)					
Хадгаламж ба хөрөнгө оруулалт					
Үндэсний нийт хадгаламж	20.3	17.3	22.3	28.7	32.3
Үндэсний нийт хөрөнгө оруулалт	35.6	22.1	35.8	41.5	31.7
Хувийн секторын үндсэн хөрөнгийн хуримтлал	27.6	14.1	29.1	34.6	24.3
Засгийн газрын үндсэн хөрөнгийн хуримтлал	8.0	8.0	6.7	6.9	7.3
ҮНИЙН ҮЗҮҮЛЭЛТҮҮД					
Инфляц (ХҮИ-ийн өсөлт, хугацааны эцсээр, хувиар)	5.2	2.3	13.8	13.2	7.9
Зэсийн үнэ* (\$/тонн)	6,004	6,178	9,315	8,815	8,479
Алтны үнэ* (\$/трой, унци)	1,393	1,772	1,799	1,802	1,943
Газрын тосны үнэ* (\$/баррел, Brent)	59	50	61	82	79
ДНБ дефлятор (хувиар)	10.0	3.7	14.4	17.7	19.5
(өөрөөр тэмдэглээгүй бол ДНБ-д эзлэх хувиар)					
НЭГДСЭН ТӨСВИЙН ҮЗҮҮЛЭЛТҮҮД					
Нийт орлого ба тусламжийн дүн	31.8	27.9	32.8	34.4	35.3
Тэнцвэржүүлсэн орлого ба тусламжийн дүн	28.8	25.3	29.2	31.8	33.7
Нийт зарлага ба цэвэр зээлийн дүн	30.8	37.1	35.9	33.7	32.6
Үндсэн зарлага ба цэвэр зээлийн дүн	28.5	34.6	34.0	32.2	31.0
Нийт тэнцэл	1.0	-9.2	-3.0	0.7	2.7
Тэнцвэржүүлсэн тэнцэл	-2.0	-11.9	-6.7	-1.9	1.1
Тэнцвэржүүлсэн үндсэн тэнцэл	0.3	-9.3	-4.8	-0.4	2.8
ЗГ-ын нийт өр (ӨҮЦ)	55.6	62.3	50.1	51.0	39.0
ЗГ-ын нийт өр (нэрлэсэн, тэрбум төгрөгөөр)	23,915	27,895	27,116	31,945	30,765
Гадаад	20,444	24,848	24,645	29,619	30,320
Дотоод	1,400	1,137	921	1,036	234
Өрийн баталгаа, концесс, орон нутгийн зээллэг	2,072	1,911	1,550	1,291	211
МӨНГӨНИЙ СЕКТОР					
M2 мөнгөний өсөлт (хувиар)	8.2	16.2	13.8	6.5	26.8
Нөөц мөнгөний өсөлт (хувиар)	5.4	-12.7	6.5	39.9	7.4
Мөнгөний эргэлтийн хурд (нэгжээр)	1.8	1.5	1.6	1.8	1.8
Мөнгөний үржүүлэгч (нэгжээр)	4.1	5.4	5.8	4.4	5.2
Зээлийн өсөлт** (хувиар)	4.5	-4.0	18.5	7.5	22.7
(өөрөөр тэмдэглээгүй бол ДНБ-д эзлэх хувиар)					
ТӨЛБӨРИЙН ТЭНЦЭЛ					
Төлбөрийн тэнцэл	3.2	5.9	-1.4	-4.2	7.3
Урсгал дансны тэнцэл	-15.2	-5.1	-13.8	-13.4	0.7
ГВАН (сая ам.доллороор)	4,349	4,534	4,366	3,400	4,921
сарын бараа, үйлчилгээний импортын хүрэлцээ	5.6	7.4	5.7	3.4	4.3
Гадаад валютын ханш					
Валютын ханш USD/MNT (дунджаар)	2,664	2,813	2,849	3,140	3,466
Валютын ханш USD/MNT (хугацааны эцсээр)	2,734	2,850	2,849	3,445	3,411
Нэрлэсэн үйлчилж буй ханшийн индекс (дунджаар)	44.8	43.0	41.3	38.8	37.6
Бодит үйлчилж буй ханшийн индекс (дунджаар)	106.5	102.9	103.6	106.9	112.4

*Bloomberg Terminal

**Ипотекийн зээлээр баталгаажсан бондыг оруулсан дүн

ХҮСНЭГТ 2. БОДИТ СЕКТОРЫН ҮЗҮҮЛЭЛТҮҮД

БОДИТ СЕКТОРЫН ҮЗҮҮЛЭЛТҮҮД					
	2019	2020	2021	2022	2023
Нэрлэсэн ДНБ (үйлдвэрлэлийн аргаар)	37,839	37,453	43,555	53,852	68,872
Бодит ДНБ (үйлдвэрлэлийн аргаар)	27,928	26,655	27,092	28,455	30,454
(өсөлт, хувиар)					
Бодит ДНБ-ий өсөлт	5.6	-4.6	1.6	5.0	7.0
Уул уурхайн салбарын өсөлт	-1.6	-9.9	0.8	-15.3	23.4
Уул уурхайн бус салбарын өсөлт	6.9	-3.7	1.8	8.2	5.0
Хөдөө аж ахуй	5.2	5.8	-5.5	12.0	-8.9
Уул уурхай	-1.6	-9.9	0.8	-15.3	23.4
Боловсруулах аж үйлдвэр	3.8	3.4	-0.9	6.1	5.1
Цахилгаан дулаан	6.3	1.8	9.4	3.3	5.0
Барилга	20.3	-3.2	-22.8	8.2	0.6
Бөөний болон жижиглэн худалдаа	10.9	-12.5	5.8	10.1	5.7
Тээвэр ба агуулахын үйл ажиллагаа	4.4	-18.2	-7.3	9.2	39.3
Мэдээлэл, холбоо	12.1	5.2	20.7	6.6	16.4
Бусад үйл ажиллагаа	4.6	-2.6	3.8	5.4	5.2
Цэвэр татвар	9.6	-9.4	12.2	11.5	6.8
Дефлятор	10.0	3.7	14.4	17.7	19.5
(нэгж хувиар)					
ДНБ-ий өсөлт дэх салбаруудын оролцоо					
Хөдөө аж ахуй	0.7	0.8	-0.8	1.7	-1.3
Уул уурхай	-0.3	-1.4	0.1	-2.1	2.6
Боловсруулах аж үйлдвэр	0.3	0.3	-0.1	0.5	0.4
Цахилгаан дулаан	0.1	0.0	0.2	0.1	0.1
Барилга	0.7	-0.1	-0.9	0.2	0.0
Бөөний болон жижиглэн худалдаа	1.2	-1.4	0.6	1.1	0.7
Тээвэр ба агуулахын үйл ажиллагаа	0.2	-1.0	-0.3	0.4	1.8
Мэдээлэл, холбоо	0.2	0.1	0.5	0.2	0.5
Бусад үйл ажиллагаа	1.3	-0.7	1.1	1.6	1.5
Цэвэр татвар	1.0	-1.1	1.3	1.4	0.9
(тэрбум төгрөгөөр)					
Нэрлэсэн ДНБ (эцсийн ашиглалтын аргаар)	37,839	37,883	44,703	54,878	70,444
Анхдагч орлого	-4,179	-3,526	-6,359	-5,072	-6,970
Үндэсний нийт орлого	33,660	34,357	38,344	49,806	63,474
Хоёрдогч орлого	641	769	1,223	1,363	1,375
Үндэсний нийт цэвэр орлого	34,301	35,126	39,566	51,169	64,850
Нийт дотоод эрэлт	40,095	36,953	45,574	58,219	64,392
Үндэсний хадгаламж	7,674	6,556	9,985	15,747	22,763
Үндэсний хөрөнгө оруулалт	13,468	8,383	15,993	22,796	22,305
Хадгаламж - Хөрөнгө оруулалтын тэнцэл	-5,794	-1,827	-6,008	-7,050	457
(ДНБ-д эзлэх хувиар)					
Нийт дотоод эрэлт	106.0	97.5	101.9	106.1	91.4
Эцсийн хэрэглээ	70.4	75.4	66.2	64.5	59.7
Өрхийн хэрэглээ	57.3	59.8	51.6	50.9	46.8
Төрийн байгууллагын хэрэглээ	13.1	15.6	14.5	13.7	13.0
Хөрөнгийн нийт хуримтлал	35.6	22.1	35.8	41.5	31.7
Үндсэн хөрөнгийн хуримтлал	28.0	23.3	26.1	29.3	26.8
Материаллаг эргэлтийн хөрөнгийн өөрчлөлт	7.6	-1.2	9.6	12.3	4.9
Цэвэр экспорт	-6.0	2.5	-1.9	-6.1	8.6
Бараа, үйлчилгээний экспорт	59.2	57.0	57.0	63.8	76.3
Бараа, үйлчилгээний импорт	65.2	54.6	59.0	69.9	67.7
Статистикийн зөрүү (тэрбум төгрөгөөр)	0	-430	-1,147	-1,026	-1,573

ХҮСНЭГТ 3. НЭГДСЭН ТӨСВИЙН ҮЗҮҮЛЭЛТҮҮД

НЭГДСЭН ТӨСВИЙН ҮЗҮҮЛЭЛТҮҮД					
	2019	2020	2021	2022	2023
	(тэрбум төгрөгөөр)				
НИЙТ ОРЛОГО БА ТУСЛАМЖИЙН ДҮН	12,040	10,444	14,306	18,522	24,310
Ирээдүйн өв сан	1,040	914	967	0	416
Тоттворжуулалтын сан	95	66	628	1,395	676
ТЭНЦВЭРЖҮҮЛСЭН ОРЛОГО БА ТУСЛАМЖИЙН ДҮН	10,906	9,464	12,711	17,127	23,218
Татварын орлого	9,813	864	11,300	15,459	21,451
Орлогын албан татвар	2,556	2,227	3,326	3,827	5,800
Нийгмийн даатгалын орлого	2,031	1,586	2,286	3,038	3,943
Хөрөнгийн албан татвар	154	155	201	238	397
Нэмэгдсэн өртгийн албан татвар	2,486	2,209	2,838	3,946	4,773
Онцгой албан татвар	863	777	827	848	790
Тусгай зориулалтын орлого	16	17	17	19	22
Гаалийн албан татвар	790	741	939	1,256	1,464
Бусад татвар, төлбөр, хураамж	916	800	866	2,288	4,262
Татварын бус орлого	1,092	952	1,412	1,668	1,767
Нийтлэг татварын бус орлого	1,003	785	1,250	1,364	1,430
Хөрөнгийн орлого	1	1	2	4	8
Тусламжийн орлого	88	166	160	300	330
НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	11,662	13,904	15,630	18,160	22,454
Урсгал зарлага	8,229	10,829	12,804	14,229	17,047
Цалин, хөлс	2,257	2,649	2,532	1,666	2,322
Бараа, үйлчилгээний бусад зардал	1,743	2,202	2,170	2,140	2,740
Татаас	299	375	454	537	580
Урсгал шилжүүлэг	3,068	4,663	6,813	9,088	10,273
Зээлийн үйлчилгээний төлбөр	861	939	836	798	1,132
Гадаад	675	776	681	694	1,042
Дотоод	186	163	155	104	90
Хөрөнгийн зардал ба цэвэр зээл	3,433	3,075	2,826	3,930	5,408
Хөрөнгийн зардал	3,017	3,034	2,982	3,803	5,175
Эргэж төлөгдөх цэвэр зээл	416	41	-156	127	233
НИЙТ ТЭНЦЭЛ	379	-3,460	-1,324	362	1,856
НИЙТ ҮНДСЭН ТЭНЦЭЛ	1,240	-2,521	-488	1,160	2,987
ТЭНЦВЭРЖҮҮЛСЭН ТЭНЦЭЛ	-756	-4,440	-2,919	-1,033	763
ТЭНЦВЭРЖҮҮЛСЭН ҮНДСЭН ТЭНЦЭЛ	105	-3,501	-2,083	-235	1,895
АЛДАГДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	756	4,440	2,919	1,033	-763
Гадаад	1,185	2,675	487	583	1,126
ЗГ-ын бонд*	0	14	-176	-521	99
ЗГ-ын зээл*	1,185	2,661	663	1,104	1,027
Дотоод	-429	1,765	2,432	450	-1,889
Харилцах болон хадгаламжийн дансны цэвэр өөрчлөлт	-1,103	1,868	1,919	-682	-1,090
ЗГ-ын бонд*	-165	-263	-216	378	-801
ЗГ-ын зээл*	466	0	0	0	0
Өмч хувьчлал	1	21	1	2	3
Ирээдүйн өв сангийн шилжүүлэг	50	0	0	0	0
Тоттворжуулалтын сангийн хуримтлагдсан үлдэгдэл	322	139	729	752	0
Бусад	0	0	0	0	0

*Цэвэр дүнгээр

ХҮСНЭГТ 4. НЭГДСЭН ТӨСВИЙН ҮЗҮҮЛЭЛТҮҮД (ДНБ-Д ЭЗЛЭХ ХУВИАР)

	2019	2020	2021	2022	2023
(ДНБ-д эзлэх хувиар)					
НИЙТ ОРЛОГО БА ТУСЛАМЖИЙН ДҮН	31.8	27.9	32.8	34.4	35.3
Ирээдүйн өв сан	2.7	2.4	2.2	0.0	0.6
Тогтворжуулалтын сан	0.2	0.2	1.4	2.6	1.0
ТЭНЦВЭРЖҮҮЛСЭН ОРЛОГО БА ТУСЛАМЖИЙН ДҮН	28.8	25.3	29.2	31.8	33.7
Татварын орлого	25.9	2.3	25.9	28.7	31.1
Орлогын албан татвар	6.8	5.9	7.6	7.1	8.4
Нийгмийн даатгалын орлого	5.4	4.2	5.2	5.6	5.7
Хөрөнгийн албан татвар	0.4	0.4	0.5	0.4	0.6
Нэмэгдсэн өртгийн албан татвар	6.6	5.9	6.5	7.3	6.9
Онцгой албан татвар	2.3	2.1	1.9	1.6	1.1
Тусгай зориулалтын орлого	0.0	0.0	0.0	0.0	0.0
Гаалийн албан татвар	2.1	2.0	2.2	2.3	2.1
Бусад татвар, төлбөр, хураамж	2.4	2.1	2.0	4.2	6.2
Татварын бус орлого	2.9	2.5	3.2	3.1	2.6
Нийтлэг татварын бус орлого	2.7	2.1	2.9	2.5	2.1
Хөрөнгийн орлого	0.0	0.0	0.0	0.0	0.0
Тусламжийн орлого	0.2	0.4	0.4	0.6	0.5
НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	30.8	37.1	35.9	33.7	32.6
Урсгал зарлага	21.7	28.9	29.4	26.4	24.8
Цалин, хөлс	6.0	7.1	5.8	3.1	3.4
Бараа, үйлчилгээний бусад зардал	4.6	5.9	5.0	4.0	4.0
Татаас	0.8	1.0	1.0	1.0	0.8
Урсгал шилжүүлэг	8.1	12.5	15.6	16.9	14.9
Зээлийн үйлчилгээний төлбөр	2.3	2.5	1.9	1.5	1.6
Гадаад	1.8	2.1	1.6	1.3	1.5
Дотоод	0.5	0.4	0.4	0.2	0.1
Хөрөнгийн зардал ба цэвэр зээл	9.1	8.2	6.5	7.3	7.9
Хөрөнгийн зардал	8.0	8.1	6.8	7.1	7.5
Эргэж төлөгдөх цэвэр зээл	1.1	0.1	-0.4	0.2	0.3
НИЙТ ТЭНЦЭЛ	1.0	-9.2	-3.0	0.7	2.7
НИЙТ ҮНДСЭН ТЭНЦЭЛ	0.3	-9.3	-4.8	-0.4	2.8
ТЭНЦВЭРЖҮҮЛСЭН ТЭНЦЭЛ	-2.0	-11.9	-6.7	-1.9	1.1
ТЭНЦВЭРЖҮҮЛСЭН ҮНДСЭН ТЭНЦЭЛ	0.3	-9.3	-4.8	-0.4	2.8
АЛДАГДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	2.0	11.9	6.7	1.9	-1.1
Гадаад	3.1	7.1	1.1	1.1	1.6
ЗГ-ын бонд*	0.0	0.0	-0.4	-1.0	0.1
ЗГ-ын зээл*	3.1	7.1	1.5	2.1	1.5
Төслийн зээл	2.1	1.8	0.9	1.3	0.5
Хөтөлбөр болон төслийн бус зээл	1.1	5.3	0.7	0.8	1.0
Дотоод	-1.1	4.7	5.6	0.8	-2.7
Харилцах болон хадгаламжийн дансны цэвэр өөрчлөлт	-2.9	5.0	4.4	-1.3	-1.6
ЗГ-ын бонд*	-0.4	-0.7	-0.5	0.7	-1.2
ЗГ-ын зээл*	1.2	0.0	0.0	0.0	0.0
Өмч хувьчлал	0.0	0.1	0.0	0.0	0.0
Ирээдүйн өв сангийн шилжүүлэг	0.1	0.0	0.0	0.0	0.0
Тогтворжуулалтын сангийн хуримтлагдсан үлдэгдэл	0.9	0.4	1.7	1.4	0.0
Бусад	0.0	0.0	0.0	0.0	0.0
Нэмэлт үзүүлэлтүүд:					
Нэрлэсэн ДНБ (тэрбум төгрөгөөр)	37,839	37,453	43,555	53,852	68,872

ХҮСНЭГТ 5. ТӨЛБӨРИЙН ТЭНЦЛИЙН ҮЗҮҮЛЭЛТҮҮД

	2019	2020	2021	2022	2023
ТӨЛБӨРИЙН ТЭНЦЛИЙН ҮЗҮҮЛЭЛТҮҮД					
	(сая ам.доллороор)				
I. УРСГАЛ ДАНС	-2,162	-675	-2,108	-2,304	147
Бараа	1,158	1,756	1,370	1,233	4,369
Экспорт Ф.О.Б (кредит)	7,183	6,991	8,136	9,854	13,891
Импорт Ф.О.Б (дебит)	6,025	5,235	6,766	8,622	9,523
Үйлчилгээ	-1,992	-1,450	-1,675	-2,355	-2,607
Кредит	1,233	655	814	1,135	1,599
Дебит	3,224	2,105	2,490	3,490	4,206
Анхдагч орлого	-1,569	-1,253	-2,232	-1,615	-2,011
Кредит	394	341	292	344	447
Дебит	1,963	1,595	2,524	1,959	2,458
Хоёрдогч орлого	241	273	429	434	397
II. ХӨРӨНГИЙН ДАНС	161	103	114	154	137
Кредит	162	105	116	166	151
Дебит	1	2	2	12	14
III. САНХҮҮГИЙН ДАНС: (зээлдүүлэг+/зээлэг-)	-2,678	-1,504	-1,982	-1,644	-1,459
Шууд хөрөнгө оруулалт (цэвэр)	-2,316	-1,693	-2,060	-2,428	-1,683
Багцын хөрөнгө оруулалт (цэвэр)	-372	563	25	445	767
Санхүүгийн үүсмэл хэрэгслүүд (цэвэр)	6	-6	-8	-11	0
Бусад хөрөнгө оруулалт (цэвэр)	5	-369	60	351	-543
Үүнээс: Бэлэн мөнгө ба харилцах	90	278	245	298	199
Зээл	-168	-803	-501	67	-718
Худалдааны зээл	83	156	413	-15	-23
IV. Алдаа болон орхигдуулга	-224	-146	-209	-222	-286
<i>Төлбөрийн тэнцлийн нийт дүн</i>	453	787	-222	-727	1,457
V. Нөөц хөрөнгө	453	787	-222	-727	1,457
ГВУН	453	787	-225	-751	1,398
ОУВС-гийн зээл	0	0	-3	-24	-59
Тусгай санхүүжилт	0	0	0	0	0
Нэмэлт үзүүлэлтүүд:					
Нэрлэсэн ДНБ (сая ам.доллараар)	14,205	13,314	15,286	17,150	19,872
Урсгал дансны тэнцэл/ДНБ (хувиар)	-15.2	-5.1	-13.8	-13.4	0.7
Хөрөнгийн дансны тэнцэл/ДНБ (хувиар)	1.1	0.8	0.7	0.9	0.7
Санхүүгийн дансны тэнцэл/ДНБ (хувиар)	-18.9	-11.3	-13.0	-9.6	-7.3
Гадаад валютын албан нөөц (сая ам.доллараар)	4,349	4,534	4,366	3,400	4,921
Гадаад валютын албан нөөц (сарын импортоор)	5.6	7.4	5.7	3.4	4.3
Валютын ханш MNT/USD (дунджаар)	2,664	2,813	2,849	3,140	3,466
Валютын ханш MNT/USD (хугацааны эцсээр)	2,734	2,850	2,849	3,445	3,411
Бараа, үйлчилгээний экспорт/ДНБ (хувиар)	59.2	57.4	58.6	64.1	78.0
Бараа, үйлчилгээний импорт/ДНБ (хувиар)	65.1	55.1	60.6	70.6	69.1
Гадаад худалдааны нийт эргэлт/ДНБ (хувиар)	124.4	112.6	119.1	134.7	147.0

ХҮСНЭГТ 6. ТӨЛБӨРИЙН ТЭНЦЛИЙН ҮЗҮҮЛЭЛТҮҮД (ДНБ-Д ЭЗЛЭХ ХУВИАР)

ТӨЛБӨРИЙН ТЭНЦЛИЙН ҮЗҮҮЛЭЛТҮҮД (ДНБ-Д ЭЗЛЭХ ХУВИАР)					
	2019	2020	2021	2022	2023
	(хувиар)				
I. УРСГАЛ ДАНС	-15.2	-5.1	-13.8	-13.4	0.7
Бараа	8.2	13.2	9.0	7.2	22.0
Экспорт Ф.О.Б	50.6	52.5	53.2	57.5	69.9
Импорт Ф.О.Б	42.4	39.3	44.3	50.3	47.9
Үйлчилгээ	-14.0	-10.9	-11.0	-13.7	-13.1
Кредит	8.7	4.9	5.3	6.6	8.0
Дебит	22.7	15.8	16.3	20.4	21.2
Анхдагч орлого	-11.0	-9.4	-14.6	-9.4	-10.1
Кредит	2.8	2.6	1.9	2.0	2.2
Дебит	13.8	12.0	16.5	11.4	12.4
Хоёрдогч орлого	1.7	2.1	2.8	2.5	2.0
II. ХӨРӨНГИЙН ДАНС	1.1	0.8	0.7	0.9	0.7
Кредит	1.1	0.8	0.8	1.0	0.8
Дебит	0.0	0.0	0.0	0.1	0.1
III. САНХҮҮГИЙН ДАНС: (зээлдүүлэг+/зээллэг-)	-18.9	-11.3	-13.0	-9.6	-7.3
Шууд хөрөнгө оруулалт (цэвэр)	-16.3	-12.7	-13.5	-14.2	-8.5
Багцын хөрөнгө оруулалт (цэвэр)	-2.6	4.2	0.2	2.6	3.9
Санхүүгийн үүсмэл хэрэгслүүд (цэвэр)	0.0	0.0	0.0	-0.1	0.0
Бусад хөрөнгө оруулалт (цэвэр)	0.0	-2.8	0.4	2.0	-2.7
Үүнээс: Бэлэн мөнгө ба харилцах	0.6	2.1	1.6	1.7	1.0
Зээл	-1.2	-6.0	-3.3	0.4	-3.6
Худалдааны зээл	0.6	1.2	2.7	-0.1	-0.1
IV. Алдаа болон орхигдуулга	-1.6	-1.1	-1.4	-1.3	-1.4
<i>Төлбөрийн тэнцлийн нийт дүн</i>	3.2	5.9	-1.4	-4.2	7.3
V. Нөөц хөрөнгө	3.2	5.9	-1.4	-4.2	7.3
ГВУН	3.2	5.9	-1.5	-4.4	7.0
ОУВС-гийн зээл	0.0	0.0	0.0	-0.1	-0.3
Тусгай санхүүжилт	0.0	0.0	0.0	0.0	0.0
Нэмэлт үзүүлэлтүүд:					
Нэрлэсэн ДНБ (сая ам. доллараар)	14,205	13,314	15,286	17,150	19,872
Урсгал дансны тэнцэл/ДНБ (хувиар)	-15.2	-5.1	-13.8	-13.4	0.7
Хөрөнгийн дансны тэнцэл/ДНБ (хувиар)	1.1	0.8	0.7	0.9	0.7
Санхүүгийн дансны тэнцэл/ДНБ (хувиар)	-18.9	-11.3	-13.0	-9.6	-7.3
Гадаад валютын албан нөөц (сая ам.доллараар)	4,349	4,534	4,366	3,400	4,921
Гадаад валютын албан нөөц (сарын импортоор)	5.6	7.4	5.7	3.4	4.3
Валютын ханш MNT/USD (жилийн дунджаар)	2,664	2,813	2,849	3,140	3,466
Валютын ханш MNT/USD (хугацааны эцсээр)	2,734	2,850	2,849	3,445	3,411
Бараа үйлчилгээний экспорт/ДНБ (хувиар)	59.2	57.4	58.6	64.1	78.0
Бараа үйлчилгээний импорт/ДНБ (хувиар)	65.1	55.1	60.6	70.6	69.1
Гадаад худалдааны нийт эргэлт/ДНБ (хувиар)	124.4	112.6	119.1	134.7	147.0

ХҮСНЭГТ 7. МӨНГӨНИЙ ҮЗҮҮЛЭЛТҮҮД

МӨНГӨНИЙ ҮЗҮҮЛЭЛТҮҮД					
	2019	2020	2021	2022	2023
(тэрбум төгрөгөөр)					
Гадаад цэвэр актив	3,215	5,816	3,806	2,503	8,944
Дотоод цэвэр актив	17,849	18,664	24,057	27,162	28,680
Дотоодын цэвэр зээл	18,699	19,136	24,298	25,648	29,098
Бусад цэвэр зүйлс	-850	-472	-241	1,514	-418
M2 мөнгө	21,064	24,481	27,863	29,665	37,624
Хадгаламжийн байгууллагаас гадуурх мөнгө	614	753	847	831	906
Харилцах болон хадгаламж	20,449	23,728	27,016	28,834	36,719
(өсөлт, хувиар)					
Жилийн өсөлт					
M2 мөнгө	8.2	16.2	13.8	6.5	26.8
Гадаад цэвэр актив	1,191.3	80.9	-34.6	-34.2	257.4
Дотоод цэвэр активын өсөлт	-7.2	4.6	28.9	12.9	5.6
Дотоодын цэвэр зээл	-6.8	2.3	27.0	5.6	13.5
ЗГ-аас авах авлага	128.8	-29.6	-49.8	107.6	91.3
Бусад салбараас авах авлага	1.7	-2.2	19.2	9.9	19.8
Улсын байгууллагаас авах авлага	-38.5	1,492.6	25.0	-5.0	-16.7
Хувийн сектороос авах авлага	1.9	-7.2	18.8	10.8	21.7
(нэгж хувиар)					
M2 мөнгөний өсөлт дэх оролцоо					
M2 мөнгө	8.2	16.2	13.8	6.5	26.8
Гадаад цэвэр актив	15.2	12.4	-8.2	-4.7	21.7
Дотоод цэвэр актив	-7.1	3.9	22.0	11.1	5.1
Нэмэлт үзүүлэлтүүд:					
Мөнгөний эргэлтийн хурд	1.8	1.5	1.6	1.8	1.8
Нэрлэсэн ДНБ-ий өсөлт (хувиар)	16.1	-1.0	16.3	23.6	27.9
Инфляц (ХҮИ-ийн өсөлт, хугацааны эцсээр, хувиар)	5.2	2.3	13.8	13.2	7.9

ХОЛБОО БАРИХ:

Утас: +976-51-263333

Факс: +976-51-263333

И-мэйл: info@med.gov.mn

Вэбсайт: med.gov.mn

Фэйсбүүк: [medgovMN](https://www.facebook.com/medgovMN)

ХЯРГ:

Эдийн засаг, хөгжлийн яам

Монгол Улс, Улаанбаатар хот,

Чингэлтэй дүүрэг, Ж.Самбуугийн гудамж

Засгийн газрын XI байр